



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 26-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр, Баасан гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2-5
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	6-54
<i>1.Элчин сайд нарыг эгүүлэн татах, томилох асуудлаар зөвшилцөх тухай асуудал /Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2024.04.22-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх/</i>	6-11
<i>2.Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл</i>	11-47
<i>3.“Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл, 2023 оны Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл</i>	47-52
<i>4.Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын 19 гишүүн 2024.12.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	52-53
<i>5.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.04.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг</i>	53-54

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
04 дүгээр сарын 26-ны өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 72 гишүүнээс 38 гишүүн хүрэлцэн ирж, 52.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 33 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Ш.Адьяаа, А.Адъяасүрэн, Ц.Анандбазар, Ж.Бат-Эрдэнэ, Ж.Батжаргал, С.Ганбаатар, Ц.Даваасүрэн, Г.Дамдинням, Б.Жавхлан, Ц.Мөнх-Оргил, Г.Мөнхцэцэг, Н.Наранбаатар, Б.Саранчимэг, Ц.Туваан, Ч.Хүрэлбаатар, О.Цогтгэрэл, Ц.Цэрэнпунцаг;

Чөлөөтэй: Ё.Баатарбилэг, Б.Баярсайхан, Л.Оюун-Эрдэнэ, Н.Учрал, Д.Цогтбаатар;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Батболд, Б.Жаргалмаа, Ш.Раднаасэд;

Тасалсан: С.Амарсайхан, Д.Батлут, Х.Болорчулуун, Ж.Ганбаатар, Д.Өнөрболор;

Хоцорсон: Ж.Батсуурь-40 минут, Э.Батиугар-2 цаг 12 минут, С.Одонтуяа-22 минут, Ж.Сүхбаатар-01 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор, С.Бямбацогт нараас албан бичиг ирүүлснийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт үг хэлэв.

Нэг.Элчин сайд нарыг эгүүлэн татах, томилох асуудлаар зөвшилцөх тухай асуудал /Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2024.04.22-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Гадаад харилцааны дэд сайд Г.Амартүвшин, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Анхбаяр, мөн яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын захирал Д.Амарсайхан, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар, Бодлого, төлөвлөлтийн газрын захирал Г.Бямбасүрэн, Консулын газрын захирал Б.Болд, Монгол Улсын Ерөнхийлөгчийн гадаад бодлогын зөвлөх Э.Одбаяр, Монгол Улсаас Бүгд найрамдах Хятад Ард Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдад нэр дэвшигч Н.Энхболд, Монгол Улсаас Бүгд Найрамдах Индонез Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдад нэр дэвшигч Д.Энхтайван, Монгол Улсаас Бүгд Найрамдах Узбекистан Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдад нэр дэвшигч Д.Батбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Элчин сайдаар томилуулах Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар, Элчин сайдаар томилуулах

саналыг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Анужин нар танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин Элчин сайд нарыг эгүүлэн татах, томилох асуудлаар зөвшилцөх тухай асуудал нь Монгол төрийн гадаад харилцааны бодлогын түвшинд яригдах асуудал тул уг асуудлыг хаалттай горимоор хэлэлцэх нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшингийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22

Татгалзсан: 15

Бүгд: 37

59.5 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул хуралдааныг 10 цаг 53 минутад хаалттай горимд шилжүүлэв.

Хаалттай хуралдаан 27 минут үргэлжилж, 11 цаг 20 минутад нээлттэй горимд шилжүүлэв.

Хоёр.Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Х.Мөнхзул, С.Дондов, Г.Нарантуяа, Ж.Хунан, Б.Энхболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Б.Болдбаатар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат нар байлцав.

Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэлийг Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин нар танилцуулав.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар 12 цаг 21 минутаас хуралдааныг даргалав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар, С.Бямбацогт, Г.Тэмүүлэн, Ж.Чинбүрэн, Б.Бейсен, С.Одонтуяа, Ц.Идэрбат, Э.Батшугар, Ц.Мөнхцэцэг, Л.Мөнхбаатар нарын тавьсан асуултад Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Х.Мөнхзул, С.Дондов, Г.Нарантуяа, Б.Энхболд нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэлийг хэлэлцэв.

Уг асуудлыг 13 цаг 29 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. “Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл, 2023 оны Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Х.Мөнхзул, С.Дондов, Г.Нарантуяа, Ж.Хунан, Б.Энхболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат нар байлцав.

Тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагийн тавьсан асуултад Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Б.Энхболд нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.12-г заасны дагуу санал хураалтыг 05 дугаар сарын 02-ны өдөр явуулахаар тогтов.

Үдээс өмнөх нээлттэй хуралдаан 2 цаг 44 минут үргэлжилж, 13 цаг 44 минутад завсарлав.

Үдээс хойших нэгдсэн хуралдаан 14 цаг 45 минутад эхлэв.

Дөрөв. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын 19 гишүүн 2024.12.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат нар байлцав.

Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэн танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 14 цаг 50 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.04.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Соёлын сайд Ч.Номин, Соёлын дэд сайд П.Баттөр, Соёлын яамны Соёлын бүтээлч үйлдвэрлэл, инновацын хэлтсийн дарга Г.Батхуяг, мөн яамны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга С.Батцэцэг, Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн Ц.Чулуунбат, Ая зохиогч, продюсер, Дуу бичлэг бүтээгчдийн үндэсний төвийн гишүүн Д.Өлзий-Орших, Монголын анимейшний холбооны гүйцэтгэх захирал Э.Тамир, “М мюзик” ХХК-ийн захирал Д.Батмагнай нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ нар байлцав.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.12-т заасны дагуу санал хураалтыг 05 дугаар сарын 02-ны өдөр явуулахаар тогтов.

Уг асуудлыг 14 цаг 56 минутад хэлэлцэж дуусав.

Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцүүлгийг хууль санаачлагч нь байхгүй тул хойшлуулав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

Хуралдаан 3 цаг 26 минут үргэлжилж, 72 гишүүнээс 42 гишүүн хүрэлцэн ирж, 58.3 хувийн ирцтэйгээр 15 цаг 00 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Д.ЭНХБАТ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр,
Баасан гараг Төрийн ордон “Их
хуралдай” танхим 10 цаг 33 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Занданшатар: Эрхэм гишүүдийн өдрийн амгаланг айлтгая аа. Хуралдааны ирц бүрдсэн тул Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы 4 дүгээр сарын 26-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 10 асуудал хэлэлцэнэ.

Нэгдүгээрт, Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай Дэлхий дахины конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Энэ асуулт асууж үг хэлээд дуусчихсан, санал хураахад бэлэн болчихсон байгаа.

Хоёрдугаарт нь, Элчин сайд нарыг эргүүлэн татах, томилох асуудлаар зөвшилцөх тухай асуудлыг хэлэлцэнэ. Байнгын хорооны дүгнэлт одоо бэлэн болгож байгаарай. Одоо ингээд шуурхай шүүд хэлэлцэнэ шүү. Бэлэн болж байна уу? Тогтоол, дүгнэлт.

Гуравдугаарт, Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл.

Дөрөвдүгээрт, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл 2023 оны эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг хэлэлцэнэ.

Тавдугаарт, Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Зургаадугаарт, Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах тэдэнд нөхөн олговор олгуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Долоодугаарт, Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Наймд, Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэнэ.

Есдүгээрт, Эмийн үнийн өсөлтийн шалтгаан нөхцөлийг хянан шалгах үүрэг бүхий Хянан шалгах түр хорооны сонсголын тайлан, санал дүгнэлт, тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Норовын Алтанхуягаас Монгол Улсын ерөнхий сайдад хандан Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон Ирээдүй өв сангийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар тавьсан асуулгын хариуг сонсох байсан.

Монгол Улсын Засгийн газраас энэхүү асуулгын хариуг сонсох асуудлыг хойшлуулах албан бичиг ирүүлсэн.

Сангийн сайд Болдын Жавхлан Европын сэргээн босголт хөгжлийн банкттай байгуулах зээлийн хэлэлцээрийн асуудлаар томилолтоор ажиллах болсонтой холбогдуулан Улсын Их Хурлын 2024 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн нэгдсэн хуралдаанд Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон

Ирээдүйн өв сангийн тухай хуулийн хэрэгжилтийн талаарх Монгол улсын Ерөнхий сайдад тавьсан Улсын Их Хурлын гишүүн Алтанхуягийн асуулгын хариуг танилцуулах товыг хойшлуулж өгөхийг хүсье гэсэн.

Ийм учраас энэ асуулгын товыг хойшлуулж байна.

ЗГХЭГ-ын дарга Амарбаясгалангаас ирсэн бичгийг уншиж хариулсан. Ингээд албан бичиг ирүүлсэнтэй холбогдуулаад дарааллаас асуудлыг хойшлууллаа.

Чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу үг хэлэхээр 17 цагаас өмнө 2 гишүүн бичгээр саналаа ирүүлсэн байна.

Ингээд Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн алга байна, хаслаа.

Сандагийн Бямбацогт гишүүн.

С.Бямбацогт: Гишүүдийнхээ өглөөний амгаланг айлтгая аа. Тэгээд өнөөдрийн хэлэлцэх асуудалтай холбогдуулж Хүний эрхийн Үндэсний Комиссын 23 дахь илтгэл, энэ Эмийн хянан шалгах түр хорооны тайлантай холбоотойгоор нэг үг хэлье.

Монгол Улсын Их Хурлаас Хяналт шалгалтын тухай хууль баталсан. Энэ хуулийг би санаачилж Их Хурлаар батлуулсан. Үр дүнгээ өгч байгаа. Нүүрсний хулгай хөгжлийн банкны хулгай сая одоо хамгийн сүүлд эмийн одоо хяналтын сонсгол хийгдлээ. Энийг одоо маш олон одоо зөрчил, гэмт хэрэг, хууль зөрчсөн, хулгай хийсэн, төрийн хөрөнгө шамшигдуулсан асуудлууд яригддаг. Ярьж ярьчаад хууль хяналтын байгууллагад шилжүүлээ гээд орхичихдог. Эцэст нь ямар үр дүн гарав, ямар хариуцлага тооцов гэдэг нь ерөөсөө яригдахгүй байна аа. Энэ дээр бас иргэд бухимдаж байна аа. Хууль зөрчсөн юмаа,

хулгай хийсэн юмаа тэр нь тогтоогдсон юм бол яагаад хариуцлага тооцдоггүй юм бэ? Ингээд л нэг яриад өнгөрөөд байх уу? Шүдгүй арслан шиг ингээд л одоо тийм үү? Хазсан болоод л одоо хэмлэсэн болоод л ингээд хаяад байх уу? Үнэхээр одоо хууль зөрчсөн гэмт хэрэг хийсэн юм бол хариуцлагаа тооцооч. Үүнийг олон нийтэд ил тод зарлаач, мэдээлээч гэж хүсэж байна шаардаж байна аа.

Тийм болохоор Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулаад тодорхой хугацааны дараа яг ийм одоо хариуцлага тооцлоо, ингэж одоо үр дүн гарлаа гэдгээ иргэддээ ил тод тайлагнадаг мэдээлдэг баймаар байна аа. Энийг одоо нэг Хяналт шалгалтын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт хэлэлцэж байгаа болохоор ярихгүй бол ерөөсөө тэгээд л та нар ярьж л байдаг тэгээд л баахан юм ярьж л байдаг үр дүн гарахгүй байна шүү дээ. Хариуцлага тооцоо чинь хаана байгаа юм бэ гэдэг асуудал яриад байгаа юм. Энийг бид бүхэн анхаарах ёстой юм байна тэгээд энийг анхааръя гэдэг нэг санал хэлэх гэж байгаа юм.

Хоёрдугаарт нь Хүний эрхийн Үндэсний Комиссын 23 дахь илтгэлээр эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийн хэрэгжилт нөхцөл байдлын талаар ярих гэж байна. Монгол Улсын Үндсэн хуульд Монгол хүн амьд явах эрхтэй, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхтэй гээд Үндсэн хуульд заачихсан байдаг. Өнөөдөр тэгвэл энэ одоо хэрэгжилт ямархуу байгаа юм? Монголчууд одоо Монгол хүн болгон нутагтаа сайхан амьдармаар энэ өссөн төрсөн нутагтаа. Энэ бололцоо боломжийг нь Монголын төр бүрдүүлж өгөх ёстой. Энэ талаар бид нар бас энэ аймгийн төвүүдийн утааны асуудал, Улаанбаатарын утааны асуудлыг шийдэх гэж олон гаргалгаа гарц шийдэл ярьсан. Эндээс хамгийн үр дүнтэй шийдэл бол гал түлэхгүй, утаа гаргахгүй инженерийн шугам сүлжээнд гэр хорооллыг холбож амины орон сууцанд ард иргэдээ аятай

тухтай амьдруулах. Үүнтэй холбоотойгоор инженерийн шугам сүлжээнд холбогдох боломжтой айл өрхүүдийг 3 хувийн хүүтэй ипотекийн зээлд хамруулъя гэж бид нар гол нь хууль баталсан. Төсөв баталсан. Энэ ажил ерөөсөө хэрэгжихгүй байна аа. Ингэх юм бол утааны асуудал шийдэгдэнэ. Ингэх юм бол тэр өвлийн хүйтэнд хар үүрээр босоод гал түлдэг, үнсээ авдаг ээж нар эхнэрүүдийн одоо асуудал шийдэгдэнэ.

Өдөр хичээлээ тарж ирээд худгаас ус зөөдөг, өдөржин одоо түлээгээ хөрөөдөөд нүүрсээ хагалаад хичээлээ хийх завгүй ажилладаг хүүхдүүдийн асуудал шийдэгдэнэ. Ийм байдлаар бид нар уул нь гал түлэхгүй утаа гаргахгүй, халуун хүйтэн устай, цэвэр бохир устай, хашаандаа хүүхдийн тоглоомын талбайтай хүлэмжтэй амьдрах бололцоо боломжийг Ховд аймагт одоо хашаандаа сайхан амьдарцаагай төслөөр хийж хэрэгжүүлж эхэлсэн байгаа. Энэ төслийг явуулахын тулд тэр ипотекийн зээлийнх нь асуудлыг хурдан шийдмээр байна аа. Энийг ярих ёстой гэж бодож байна.

Дараагийн асуудал бол энэ сараас бид нар 4 сараас одоо орон нутгийн нэмэгдэл өгч эхэлсэн. Орон нутгийн нэмэгдэл. Алслагдсан бүсийн хөнгөлөлт нэмэгдлийн асуудлыг одоо 2011 оноос хойш ярьсан. 2017 онд бид нар одоо ААНОАТ-ыг Улаанбаатараас мянгаас дээш алслагдсан аймгуудад нэг хувь болгож 10 дахин бууруулсан. Одоо ингээд нөгөө өнгөрсөн жилийн өдийд 700 мянган төгрөгийн цалин авдаг багийн дарга энэ сараас эхлээд 2 сая төгрөгийн цалин аваад эхлэхээр хүн амын орлогын албан татвар 70 мянга биш 200000-ыг төлөх гээд байна аа. Уг нь татвар нэмэгдээгүй. Гэтэл одоо энэ дээр татвар нэмчихсэн татвар 3 дахин нэмэгдчихлээ гээд ингээд асуудал үүсгэнэ.

Тийм болохоор алслагдсан бүсийн хөнгөлөлт нэмэгдлийн асуудлыг одоо ойрын үед яриад хамтад нь одоо шийдээд

тэр өссөн төрсөн нутагтаа аятай тухтай амьдрах бололцоо боломжийг бүрдүүлэх тал дээр нэг хүн амын орлогын албан татварыг бүсээс нь хамаарч бүсчилж.

Г.Занданшатар: Тийм уг нь зөв л юм яриад байгаа юм. Тэгээд тэр өнөөдрийн хэлэлцэх асуудалтай холбоогүй юм байна. Өчигдөр хэлэлцээд Хяналт шалгалтын тухай хуулийг чинь өчигдөр хэлэлцээд дуусчихсан шүү дээ. Тийм тэгээд өчигдөр тэр чинь тогтоол л доо хууль биш. Хяналт шалгалтын хуульд өөрчлөлт оруулах тухай асуудал та яриад байна шүү дээ.

Ингээд ажилдаа оръё

Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай Дэлхий дахины конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг үргэлжлүүлж хэлэлцэнэ.

39 гишүүнээр нийт гишүүдийн олонхоор батлах учраас хуралдааны ирц сайд нь алга учраас энэ асуудлыг хойшлуулъя. Сайд нь алга учраас асуудал хойшиллоо. Хэн картаа сугалаад байна.

Дараагийн асуудалд оръё бэлэн болсон байна уу?

Тогтоол дараагийн асуудалд орно. Элчин сайд нарыг эргүүлэн татах, томилох саналыг зөвшилцөх тухай асуудлыг хэлэлцэнэ.

Ажлын хэсэг оруулъя.

Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Ерөнхийлөгчийн саналыг танилцуулах ёстой. Байхгүй учраас хойшлуулах уу? Чинзориг сайд сонгуулийн дараа хэлэлцье гэсэн горимын санал гаргаж байна. Тэр саналаар санал хураалт явуулах уу? Содномын Чинзориг гишүүн үг хэлье. Микрофонд үг хэлье.

Горим гаргаж хэлэлцэнэ л дээ.

Содбаатар дарга яасан бэ? Содбаатар дарга байхгүй бол. Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Янгугийн Содбаатар танилцуулна.

Индэрт урьж байна.

Я.Содбаатар: *Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,*

Монгол Улсаас гадаадын зарим улсад суугаа Элчин сайд нарыг эргүүлэн татах, томилох саналын тухай танилцуулъя аа.

Монгол Улсын үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн нэг дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Засгийн газрын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4, Дипломат холбооны тухай хуулийн 16 дугаар зүйлийн нэг дэх хэсгийг тус тус үндэслэн:

1.Монгол Улсаас БНХАУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Түвшингийн Бадралыг эргүүлэн татаж, Монгол Улсаас БНХАУ-д суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Нямаагийн Энхболдыг,

2.Монгол Улсаас бүгд Найрамдах Индонез Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Дашнямын Энхтайваныг,

3.Монгол Улсаас бүгд найрамдах Узбекистан Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Дааданхүүгийн Батбаатарыг тус тус томилох саналыг танилцуулж байна аа.

Эргүүлэн татагдаж буй Элчин сайд Бадралын томилолтын хугацаа нь дууссан. Харин бүгд найрамдах Индонез Улсын нийслэл Жакарт хотноо Монгол Улс ЭСЯ-аа нээн ажиллуулахаар Улсын Их Хурлын 2013 оны 6 дугаар сарын 7-ны

өдрийн 43 дугаар тогтоолоор шийдвэрлэн 2014-2017 онд үйл ажиллагаа эрхлэн явуулсан боловч эдийн засаг санхүүжилтээс шалтгаалан Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2017 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн хуралдаанаараа тус ЭСЯ-ыг бүрмөсөн татан буулгахгүйгээр санхүүжилтийг нь зогсоож санхүүгийн бололцоотой болсон үед сэргээн ажиллуулахаар шийдвэрлэсэн байдаг аа. Монгол Улсаас бүгд найрамдах Индонез улсад суугаа ЭСЯ-ны үйл ажиллагааг 2024 оноос сэргээхээр төлөвлөж айлын талаас зохих зөвшөөрлийг авсан бөгөөд Элчин сайд томилогдоогүй байгаа болно. Бүгд найрамдах Узбекистан Улсын нийслэл Ташкент хотод Монгол Улсын ЭСЯ-аа нээн ажиллуулахаар Улсын Их Хурал 2024 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр шийдвэрлэсэнтэй холбогдуулан тус улсад суух Элчин сайдыг шинээр томилох шаардлага үүсээд байна аа.

Элчин сайд нь Монгол Улсын олон улсын гэрээ, холбогдох хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрх, хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд суугаа болон хавсран суугаа ОУБ-даа Монгол Улсыг төлөөлөн ажиллаж ашиг сонирхол болон эрхийг нь хамгаалах, харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, Монгол Улсын хөгжлийн зорилтыг шийдвэрлэхэд шаардагдах судалгаа хийж төр засгийн байгууллагын мэдээллээр хангах, төр засгийн гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх, 2 болон олон талын харилцааны асуудлаар яриа хэлэлцээр хийх, гэрээ, хэлэлцээр байгуулах, Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны эрх ашиг сонирхлыг олон улсын эрх зүй, суугаа орны хууль тогтоомжийн дагуу хамгаалж ажилладгаас гадна тэргүүлж буй ЭСЯ-ныхаа үйл ажиллагааг нэгдсэн үйл ажиллагаагаар хангах чиг үүрэгтэй байдаг аа.

Элчин сайдаар томилон ажиллуулахаар нэр дэвшүүлж буй эдгээр албан хаагчид нь төрийн алба, дипломат

албанд олон жил ажилласан мэргэжлийн өндөр ур чадвартай, удирдах ажлын дадлага туршилагатай, гадаад хэлний мэдлэгтэй, төрийн болон дипломат албаны хуулийн тогтоомжийн шалгуурыг бүрэн хангасан гэж Монгол Улсын Ерөнхийлөгч үзэж байна аа. Тухайлбал БНХАУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхлэлт Элчин сайдаар Гадаад харилцааны сайдаар ажиллаж байсан Онц бүрэн эрхт Элчин сайд цолтой мэргэжсэн дипломатч туршилагатай улс төрчийг дэвшүүлж байгаа болно оо.

Иймд асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Одоо Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Анужин танилцуулна. Индэрт урьж байна.

П.Анужин: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн нэг дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Монгол Улсаас БНХАУ-д суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Нямаагийн Энхболд, Монгол Улсаас бүгд найрамдах Индонез Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Даанхүүгийн Батбаатар нарыг томилох тухай болон Монгол Улсаас БНХАУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Түвшингийн Бадралыг эргүүлэн татах саналыг 2024 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр Улсын Их Хуралтай зөвшилцөхөөр өргөн

мэдүүлснийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2024 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Сэргэлэн, Одонтуяа, Бат-Агалан, Амартүвшин нар нэр дэвшигчдээс асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Сэргэлэн, Баделхан, Ганбат, Анужин, Энх-Амгалан нар нэр дэвшигчдийг дэмжиж байгаагаа илэрхийлээд Гадаад харилцааны сайд Батцэцэг болон яамны холбогдох ажилтнууд эрхэлсэн ажлаа хариуцлагатай сайн гүйцэтгэж байгааг онцлон тэмдэглэлээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Улсын Их Хуралд зөвшилцөхөөр өргөн мэдүүлсэн Нямаагийн Энхболдыг Монгол Улсаас Бүгд найрамдах Хятад Ард Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар, Даанхүүгийн Энхтайваныг, Монгол Улсаас Бүгд Найрамдах Индонез Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар, Даанхүүгийн Батбаатарыг Монгол Улсаас бүгд найрамдах Узбекистан Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар тус тус томилох саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд 100 хувийн саналаар дэмжсэн болноо. Түүнчлэн Монгол Улсаас БНХАУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Түвшингийн Бадралыг эргүүлэн татах саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд 100 хувь дэмжлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Элчин сайд нарыг эргүүлэн татах томилох асуудлаар зөвшилцөх тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал,

дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье ээ.

Г.Занданшатар: Анхаарал тавьсан та бүхэнд баярлалаа. Ганибалын Амартүвшин гишүүн горимын санал гаргана аа.

Г.Амартүвшин: Баярлалаа Их Хурлын дарга аа.

Энэ Элчин сайд нарыг томилох асуудал Монгол төрийн гадаад харилцаа, бодлогын түвшинд ярилцах тул тэр тусмаа одоо урд хөрштэй холбоотой Элчин сайдыг томилж байгаа асуудал болохоор энэ асуудлыг хаалттай горимоор хэлэлцэхийг би санал болгож байна.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо мөн адил хаалттай горимоор энэ асуудлыг хэлэлцсэн болохоор чуулган дээр хаалттай хэлэлцье гэж горимын санал гаргаж байна аа.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 106.1-д заасны дагуу Элчин сайдыг хэлэлцэх асуудлыг нууцаар хэлэлцэх горимын санал гаргалаа.

Горимын саналаар санал хураалт явуулна.

Ганибалын Амартүвшин гишүүний гаргасан горимын саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Санал хураалт.

Байнгын хорооны дарга хаачив. 59.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ. Горимын санал дэмжигдсэн учраас чуулганы хуралдааныг хаалттай горимд шилжүүлбье.

11.20 цагт нээв.

Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаар 23 дахь илтгэлийг хэлэлцэнэ.

Г.Занданшатар: Ажлын хэсгийг оруулаарай. Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэлийг хэлэлцэнэ. Илтгэлийг Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Дугарын Сүнжид танилцуулна. Индэрт урьж байна.

Д.Сүнжид: Эрхэм хүндэт Улсын Их Хурлын дарга, эрхэм хүндэт Улсын Их Хурлын гишүүд та бүхний энэ өглөөний амар амгаланг эрэн мэндчилбье.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 7.1.12, 9.1, 17.1, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 15.1.4, Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 10.3.5-д заасан чиг үүргийн дагуу комиссоос Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний төлөв байдлын 23 дахь илтгэлийг 2024 оны 3 дугаар сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд хүргүүлсэн болно.

Энэ удаагийн илтгэлийг комиссоос 2023 онд гүйцэтгэсэн судалгаа, хяналт шинжилгээ, үнэлгээ, комисст ирсэн гомдол, мэдээлэл болон комиссын гишүүний санаачилгаар хийсэн хяналт шалгалтын үр дүн, мөн төр, иргэний нийгэм, бусад байгууллагуудын албан ёсны тайлан мэдээлэл, бусад эх сурвалжид үндэслэн 7 бүлгийн хүрээнд боловсруулсныг товчлон танилцуулж байна.

1 дүгээр бүлэг. Эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийн хэрэгжилт, нөхцөл байдал.

Эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх нь өргөн хүрээний асуудал бөгөөд энэхүү эрхийг хэрэгжүүлэхийн тулд төрөөс наад захын болоод зайлшгүй шаардлагатай нөхцөлийг бүрдүүлж, үүний үр дүнд иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны

бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхээ эдлэх боломжтой болдог.

Монгол Улсын Үндсэн хуульд заасан эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийг нарийвчлан зохицуулсан байгаль орчны салбарын хууль тогтоомж, эрх зүйн актын дүн шинжилгээний үр дүнд 16 давхардал, 29 зөрчил, 71 хийдэлтэй болохыг тодорхойлсон. Иймд хууль тогтоомж, эрх зүйн актыг боловсруулахдаа хүний эрхийн шалгуураар бодитой үнэлж, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, эрхийг хангах, үзэл баримтлалд суурилах нь ач холбогдолтой байна.

Хүрээлэн буй орчны 180 улсыг хамруулсан 2022 оны индексийн үзүүлэлтээр Монгол Улс 155 дугаар байранд байгаа бөгөөд агаар, хөрс, усны бохирдол нь үндэсний болон олон улсын стандартын үзүүлэлтээр ноцтой түвшинд байгаа учир орчны чанарыг зохистой түвшинд хүргэх, аюулгүй орчны стандартын хэрэгслийг хангах асуудал нэн тулгамдсан болохыг илэрхийлж байна.

Монгол Улсын агаарын чанар ДЭМБ-ын зөвлөсөн хэмжээ үндэсний стандартын хэвийн хэмжээнээс хэд дахин бохирдсон үзүүлэлттэй байна. Агаарын бохирдол нь бусад өвчинтэй хавсраад, хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж, нас баралт хөгжлийн бэрхшээлд хүргэх эрсдэлтэй 10 хүчин зүйлийн нэг болж байна. Нийт хүн амд ялангуяа 5 хүртэлх насны хүүхдийн амьсгалын замын өвчлөлийг нэмэгдүүлж, жирэмсэн эмэгтэйчүүд, ахмад настан, суурь өвчтэй хүмүүст илүү эрсдэл бий болгож байна. Хөрсний бохирдлын гол эх үүсвэр нь нүхэн жорлон, аюултай хог хаягдал болоод байна. Монгол орны усны нөөц сүүлийн 10 жилд 7 хувиар буурч, усны бохирдол стандартын зөвшөөрөгдөх

хэмжээнээс 10 дахин өндөр байгааг химийн шинжилгээний үзүүлэлт харуулж байна. Иймд агаарын орчны бохирдлын эсрэг бодлогыг шинэчлэн тодорхойлж, салбар хоорондын үйл ажиллагааг уялдуулан хариуцуулах байгууллагыг тогтвортой ажиллуулан үр дүнтэй арга хэмжээг авах шаардлагатай байна. Түүнчлэн энэ 1 дүгээр бүлгийн хүрээнд эрүүл аюулгүй орчинд амьдрах, агаар орчин, агаар, хөрс, усны бохирдлын зэрэгцээгээр Улаанбаатар хотын стандартын хэрэгжилтийн асуудал уул уурхайн нөлөөллийн бүсэд амьдарч байгаа иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийн хэрэгжилтийн нөхцөл байдалд хийсэн хяналт, шалгалт судалгааны үр дүнг тусгалаа.

2.Боловсролын салбар дахь хүний эрхийн нөхцөл байдал.

Монгол Улс 2023 оны байдлаар боловсролын индексээр 189 улсаас 103 дугаарт эрэмбэлэгдэж байна. Боловсролын багц хуулийн 2023 оны цогц шинэчлэлээр хүүхэд бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдэж, иргэд насан туршидаа суралцах эрх баталгаажиж, багш тасралтгүй хөгжих боломж нээгдэж, чадахуйн зарчимд суурилсан удирдлага, засаглалын тогтолцоо бэхжиж, чанар, үр дүн, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг нэвтрүүлж, орон зай, цаг хугацаанаас үл хамаарсан цахим боловсролын тогтолцоо бий болж байгааг онцолжээ. Ийнхүү Монгол Улсын боловсролын бодлогын бодлого, эрх зүйн зохицуулалт, тасралтгүй шинэчлэл байгаа хэдий ч үргэлжилж байгаа боловч хүн ам, амьжиргааны түвшин, хөдөлмөр эрхлэлт, шилжилт хөдөлгөөн, хот, суурин газрын хүн амын хэт нягтрал, суурьшлын тархалтаас шалтгаалаад боловсролын үйлчилгээ жигд хүртээмжтэй болж чадахгүй байна.

Комиссоос боловсролын салбар дахь хүний эрхийн асуудалд онцгойлон

анхаарч 9 удаагийн илтгэлдээ энэ асуудлыг тусгасан бөгөөд тухай бүр санал, зөвлөмжийг хүргүүлж байлаа. Сүүлийн 3 жилийн хугацаанд сурч боловсрох эрх зөрчигдсөн талаар 59 хяналт шалгалтыг комиссоос зохион байгуулсан бөгөөд 63 гомдол иржээ. Энэхүү сэдвийн хүрээнд сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролын салбар, дээд боловсролын салбар дахь хүний эрхийн нөхцөл байдлын судалгаа, хяналт шинжилгээ, үнэлгээ, гомдол, мэдээлэл, холбогдох байгууллагын статистик дүн шинжилгээнд үндэслэн боловсрууллаа.

3. Хүүхдийн эрхийн зарим асуудал.

Монгол Улс хүүхдийн эрхийн чиглэлээр дотоодын хууль тогтоомжийг 1992 онд баталсан шинэ Үндсэн хуулийн үзэл баримтлал, олон улсын гэрээ хэлэлцээр, конвенцод нийцүүлэн хүүхэд хамгааллын тогтолцоо үйлчилгээг шинэчлэн сайжруулах ажлыг эрчимжүүлэн тодорхой ахиц гаргаж байгаа боловч зарим шийдэгдэхгүй асуудлууд үргэлжилсээр байна. Ялангуяа эмзэг эрсдэлтэй бүлэгт хамаарах хагас болон бүтэн өнчин хүүхдүүд, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудал орхигдож байна.

Монгол Улсад 2022 оны байдлаар 1,282,373 хүүхэд бүртгэгдсэнээс хагас өнчин, 36,363, бүтэн өнчин 2,911, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй 12,882 хүүхэд байна. Төрөлжсөн асрамж халамжийн газарт амьдардаг байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хувьд очих болон хүлээн авах газар байхгүйгээс 18 насанд хүрсэн боловч асрамж халамжийн төвүүдэд үргэлжлүүлэн амьдарч байна. Энэ талаар байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн асуудлыг шийдвэрлүүлэх зорилгоор өмнө нь эрх

бүхий байгууллагад саналыг удаа дараа хүргүүлж байсан боловч шийдвэрлэлтгүй өнөөдрийг үүрээд байна. Бусдын туслалцаагүйгээр өдөр тутмын үйлдлээ бие даан гүйцэтгэх боломжгүй байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийг хамгаалуулахын тулд төрийн зүгээс онцгой анхаарал хандуулж, судалгаа, дүн шинжилгээнд тулгуурлан цаашид төрөөс үзүүлж буй халамж үйлчилгээ, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх шаардлагатай болохыг энэ бүлгийн хүрээнд онцоллоо.

4. Гэр бүлийн харилцаан дахь жендерийн эрх тэгш байдал, хүний эрхийн зарим асуудал.

Сүүлийн жилүүдэд гарч буй гэмт хэрэг зөрчлийн дийлэнх нь гэр бүлийн орчинд үйлдэгдэж байгаа бөгөөд цагдаагийн байгууллагын дуудлага мэдээллийн эхний 4-д нь гэр бүл, ахуйн хүрээний дуудлага мэдээлэл эзэлж байна. Мөн хүүхдийн эсрэг үйлдэж буй гэмт хэрэг зөрчлийн ихэнх нь гэр бүлийн орчинд эцэг эхийн зүгээс үйлдэгдсэн байна. Төрөөс гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр сүүлийн жилүүдэд тодорхой арга хэмжээ авч байнга хэрэгжүүлсээр байгаа боловч энэ төрлийн зөрчилд гэмт хэргийн тоо буурахгүй байна. Тиймээс таслан зогсоохын зэрэгцээгээр урьдчилан сэргийлэх бодлого, үйл ажиллагаанд анхаарал хандуулах, ахиц гаргах, үр дүнтэй хэрэгжүүлэх хэрэгцээтэй байна. Шүүхээр эцэг тогтоолгох, эцэг эх байх эрх хасах, хүүхдийн тэтгэлэг гаргуулах, иргэний хэрэг маргааныг шийдвэрлэсэн тоон үзүүлэлт жил бүр өсөж байгаа боловч шүүхийн шийдвэр биелэгдэх байдал хангалтгүй, эцэг эхийн хариуцлага хүлээх асуудал сул байгаагаас хүүхдийн эрх ноцтой зөрчигдөж байгаад онцгой анхаарал хандуулж, хууль тогтоомжийн зохицуулалтыг сайжруулахын зэрэгцээ хэрэгжилтийг эрчимжүүлэх эрхтэй байна.

Энэ сэдвийн хүрээнд гэр бүлийн боловсролын асуудал, гэр бүлийн хэв маяг болон хүний эрхийн зарим асуудлуудыг дүгнэлээ.

5.Иргэний нийгэм болон байгаль орчны чиглэлээр ажилладаг хүний эрх хамгаалагчдын эрхийн хэрэгжилт.

Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль хэрэгжиж эхлээд 3 жил болж байна. Хууль хэрэгжсэнээр Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдал тодорхой болсон боловч суурь алхмууд хийгдэж байгаа боловч эрх, эрх чөлөө нь зөрчигдөх явдал гарсаар байна. Ялангуяа байгаль орчны чиглэлээр ажилладаг хүний эрх хамгаалагчид болон эмэгтэй хүний эрх хамгаалагчдад аюул, эрсдэл их тохиолддог байна. Тиймээс энэ хүний эрх хамгаалагчийн аюул, эрсдэлийн механизмыг сайжруулах, ялангуяа байгаль орчны хүний эрх хамгаалагчид тулгамдаж байгаа өс хонзонгийн сэдэлтэй хүний эрхийн зөрчлийг илрүүлэх, арилгах чиглэлээр бодлого, зохицуулалтыг бий болгох, нийтийн эрх ашгийн өмгөөллийг сайжруулах хэрэгцээтэй байна. Хууль тогтоомжид байгаль хамгаалагч гэсэн эрх зүйн байдал тодорхойгүйн улмаас ажлын байр болон зохицуулалт, эрх зүйн байдал, ажиллах нөхцөл тодорхойгүй, хамгаалалтгүй байж иржээ.

Иймээс аюул заналхийлэлд өртөх эрсдэл өндөр байгаа тул байгаль хамгаалагчдын ажлын байрны үнэлгээ хийж тэдний эрх зүйн байдлын баталгааг хуульчлах тогтолцоог шинэчлэх арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Монгол Улсын хууль тогтоомжид иргэн үзэл бодолтой байх, түүнийгээ илэрхийлэх эрх чөлөө тайвнаар жагсааж цуглах эрхийг зарим талаар олон улсын хэмжээнд нийцүүлэн баталгаажуулсан нь ахиц дэвшилтэй алхам хэдий ч түүнийг

хэрэгжүүлж байгаа зарим практик хүний эрх хамгаалах үйл ажиллагааг хязгаарлах нөхцөл болсоор байна.

Иймд Үндсэн хууль, Олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд нийцүүлэн хүний эрх хамгаалагчийн эрх зүйн баталгааг хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

6.Хорих ял эдлээд суллагдсан хүмүүсийн нийгэм, эдийн засаг, соёлын эрх.

Гэмт хэрэг дахин үйлдэж, хорих ял эдэлж байгаа хоригдлуудын дийлэнх нь судлагдсаны дараа нийгэмд бие даан амьдрахад хүндрэлтэй байдгаас гэмт хэрэг дахин үйлдэх шалтгаан нөхцөл болдог байна. Хорих ял эдлээд суллагдсан хүмүүсийн 38,6 хувь нь суллагдсанаасаа хойш 2 жилийн дотор дахин гэмт хэрэг үйлдэж, хорих ялаар шийтгүүлжээ.

Нөгөө талаар хоригдлыг нийгэмшүүлэх, нийгэмд дасан зохицоход нь дэмжлэг үзүүлэх бодлого зөвхөн хорих ял эдлүүлэх явцад, эсвэл суллагдах дөхсөн хоригдолд хамааралтайгаар хэрэгжиж байгаа бөгөөд суллагдсаны дараа дэмжлэг үзүүлэх албан ёсны тогтолцоо бүрдээгүй байна. Ийм учраас энэ нь хорих ялын үр нөлөөг сулруулж, хувь хүний хөгжил, нийгмийн хөгжилд сөргөөр нөлөөлж байна гэж үзлээ.

Комисс нь хорих ял эдлээд суллагдсан хүмүүсийн нийгэм, эдийн засаг, соёлын, эрхийн хэрэгжилтэд дүн шинжилгээ шинжилгээ хийж Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, Цагдаагийн ерөнхий газар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа байгууллага, төв, орон нутгийн төрийн захиргааны болоод иргэний нийгмийн байгууллагуудаас ирсэн албан ёсны статистик мэдээлэлд тулгуурлан энэхүү бүлгийг боловсруулж дүн шинжилгээ хийлээ.

7. Хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоог нэмэгдүүлэхэд нөлөөлөх хүчин зүйлс шийдвэрлэх асуудал.

Монгол Улс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сонгох, сонгогдох эрхийг хуулиар баталгаажуулж, намууд хөгжлийн бэрхшээлтэй улс төрчийг бэлтгэх үүрэг хүлээж, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшүүлсэн намд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зохицуулалтыг бий болгох зэргээр эрх зүйн институтийн арга хэмжээг хэрэгжүүлж эхлээд байна. Эдгээр арга хэмжээ нь боловсрол эзэмисэн санхүүгийн хувьд харьцангуй хараат бус цөөн тооны хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг улс төрд оролцоход дэмжлэг болж болох боловч нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрийн оролцоог өргөн хүрээнд нэмэгдүүлэхэд өгөөж багатай юм. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 70 орчим хувь нь бие дааж амьдрах хэвшилгүй, өөрийгөө хөгжүүлэх боломж хязгаарлагдмал, санхүүгийн нөхцөл байдалд гачигдалтай амьдардаг учир орчны хүртээмжгүй байдлаас шалтгаалан нийгмийн харилцаанд чөлөөтэй оролцож чадахгүй байгаа учраас хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ядуурлаас гаргах, боловсролын чанар хүртээмжийг дээшлүүлэх, хувь хүнийг хөгжүүлэхгүйгээр улс төрийн өргөн оролцоо бодитойгоор хэрэгжихгүй юм.

Үүний тулд комиссоос хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцоо, сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийг үнэлэх судалгаанд хөгжлийн бэрхшээлтэй хүний амьдралын чанарын үзүүлэлт, тэдний улс төрийн оролцоонд хэрхэн нөлөөлж байгааг өргөн хүрээнд тодорхойлохыг зорьж хууль, эрх зүйн орчин, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгэм, эдийн засаг, соёлын, дэд бүтэц, мэдээллийн хүртээмжийн байдал, хувь хүний өөрийн үнэлэмж, бие даах чадвар, улс төрийн оролцооны идэвх, сонгох,

сонгогдох эрхийн нөхцөл байдлыг судлан дүгнэлээ.

Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улс дахь Хүний эрхийн Үндэсний Комиссоос өргөн мэдүүлсэн Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний талаарх 23 дахь илтгэл, түүнд тусгасан санал зөвлөмжийг холбогдох журмын дагуу хэлэлцэж, шийдвэр гаргаж өгөхийг хүсье ээ. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Одоо төслийн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ганибалын Амартүвшин танилцуулна. Индэрт урьж байна.

Г.Амартүвшин: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос 2024 оны 3 дугаар сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд ирүүлсэн Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаар 23 дахь илтгэлийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлд заасан журмын дагуу Хууль зүйн байнгын хороо 2024 оны 4 дүгээр сарын 16, 23-ны өдрүүдэд сэдэв тус бүрээр хэлэлцлээ.

Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэлийг Байнгын хорооны хуралдаанд Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Сүнжид болон сэдэв тус бүрийг хариуцсан илтгэгч гишүүд танилцуулсан болно.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаар 23 дахь илтгэлийг судалгаа, тайлан, хяналт шинжилгээ, үнэлгээ,

иргэдээс ирүүлсэн гомдол, мэдээлэл, дүгнэлтэд үндэслэн дараах 7 сэдвийн хүрээнд бэлтгэсэн байна. Үүнд:

1.2022 оны хүрээлэн буй орчны асуудлаар 180 улсыг хамруулсан индексийн үзүүлэлтээр Монгол Улс 155 дугаар байранд байгаа бөгөөд агаар, хөрс, усны бохирдол нь үндэсний болон олон улсын стандартын үзүүлэлтээр ноцтой түвшинд хүрсэн тул орчны чанарыг зохистой түвшинд хүргэх, аюулгүй орчны стандартыг хэрэгжилтийг хангах асуудлыг харгалзан эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хэрэгжилт нөхцөл байдлын талаар,

2.Монгол Улсын боловсролын салбар дахь бодлого, эрх зүйн зохицуулалтад тасралтгүй шинэчлэл хийгдэж байгаа хэдий ч хүн амын амьжиргааны түвшин, хөдөлмөр эрхлэлт, шилжилт хөдөлгөөн, хот, суурин газрын хүн амын хэт нягтрал, суурьшлын тархалтаас шалтгаалан боловсролын үйлчилгээг эрх тэгш, чанартай хүргэж чадахгүй байгаа асуудлыг харгалзан боловсролын салбар дахь хүний эрхийн нөхцөл байдлын талаар,

3.Монгол Улсад 2022 оны байдлаар 1,282,373 хүүхэд бүртгэгдсэнээс хагас өнчин 36,363, бүтэн өнчин 2,911, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй 12,882 хүүхэд байна. Бүтэн өнчин хүүхдийн тоо сүүлийн 5 жилийн хугацаанд буурсан, харин хагас өнчин хүүхдийн тоо болон байнгын асаргаа шаардлагатай хүүхдийн тоо өсөж байгаа асуудлыг харгалзан хүүхдийн эрхийн зарим асуудлын талаар,

4.Сүүлийн жилүүдэд гарч буй гэмт хэрэг зөрчлийн дийлэнх нь гэр бүлийн орчинд үйлдэгдэж цагдаагийн байгууллагын дуудлага мэдээллийн эхний 4-д гэр бүл, ахуйн хүрээний дуудлага мэдээлэл эзэлж байгаа бөгөөд хүүхдийн эсрэг үйлдэгдэж байгаа гэмт хэрэг зөрчлийн дийлэнх нь гэр бүлийн орчинд

эцэг эхийн зүгээс үйлдэгдэж байгаа асуудлын хүрээнд гэр бүл харилцаа дахь жендерийн эрх тэгш байдал, хүний эрхийн зарим асуудлын талаар,

5.Монгол Улс дахь хүний эрхийн чиглэлээр ажилладаг иргэний нийгмийн хүний эрх хамгаалагчид болон байгаль орчны чиглэлээр ажилладаг хүний эрх хамгаалагчид болох байгаль хамгаалагч экологийн цагдаагийн албан хаагч, төрийн бус байгууллагын ажилтан, идэвхтнүүдийг оролцуулан хийсэн иргэний нийгэм болон байгаль орчны чиглэлээр ажилладаг хүний эрх хамгаалагчдын эрхийн хэрэгжилт судалгааны талаар.

6.Хорих ял эдлээд суллагдсан хүмүүсийн нийгэм, эдийн засаг, соёлын эрхийн хэрэгжилтэд дүн шинжилгээ болон социологийн анализ хийн холбогдох хууль тогтоомж комиссоос хийсэн хяналт шалгалтын материал Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны харьяа байгууллага, төв, орон нутгийн төрийн захиргааны болон иргэний нийгмийн байгууллагаас ирүүлсэн албан ёсны, тайлан мэдээллийн талаар,

7.Хөгжлийн бэрхшээлтэй хүний амьдралын чанарын үзүүлэлт, тэдний улс төрийн оролцоонд хэрхэн нөлөөлж байгааг өргөн хүрээнд тодорхойлохыг зорьж, хууль, эрх зүйн орчин, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгэм, соёл, эдийн засаг, дэд бүтэц болон мэдээллийн хүртээмжийн байдал, хувь хүний өөрийн үнэлэмж, бие даах чадвар, улс төрийн оролцооны идэвх сонгох, сонгогдох эрхийн нөхцөл байдлыг нь судалсан талаар илтгэлийг боловсруулсан байна.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Монгол Улсад эмийн чанар, үнэ, хяналт, бүртгэлийн тогтолцоо алдагдсан нь хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхтэй салиггүй холбоотойг дурдаад энэ асуудлаар комиссын зүгээс хяналт шалгалт хийсэн

эсэх, цаашид хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа ажлын талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг, Д.Цогтбаатар нар Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүний шаардлага зөвлөмжийн хэрэгжилтийн талаар асуулт асууж, хариулт авсан бөгөөд Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийг байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд заавал биелүүлэх үүрэгтэйг дурдаад цаашид биелэлтэд хяналт тавьж ажиллах талаар үг хэлсэн болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.4 дэх хэсэг, энэ хуулийн 112.2.2, 12.2.8, 112.2.12-т заасан танилцуулга, мэдээллийг холбогдох Байнгын хороо нэгдсэн хуралдаанд заавал танилцуулах бөгөөд бусад тайлан, илтгэл, мэдээллийг холбогдох Байнгын хороо хэлэлцээд, шаардлагатай гэж үзвэл нэгдсэн хуралдаанд танилцуулж болно гэж заасны дагуу Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэлийг чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх Хүний эрхийн Үндэсний Комисс 23 дахь илтгэлийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга, Хүний эрхийн Үндэсний комиссын гишүүн Дугарын Сүнжид, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Сангишаравын Дондов, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Хүрэлбаатарын Мөнхзул, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Ганбатын

Нарантуяа, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Жаргалсайханы Хунан, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Батцэвэгийн Энхболд нар оролцож байна.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд байна уу. Салдангийн Одонтуяа гишүүнээр тасаллаа. Идэрбат гишүүнийг нэмчих. Цагаанхүүгийн Идэрбат гишүүнийг нэмье. Одоо Жамьянхорлоогийн Сүхбаатар гишүүн.

Ж.Сүхбаатар: Би бол нэг их тийм олон асуулт асуухгүй. Зүгээр Хүний эрхийн Үндэсний Комиссынхондоо иргэдэд мэдээлэл өгөх үүднээс нь туслах ийм асуулт асуух гэж байгаа юм. Манайхан хүн болгон ингээд л хүний эрх зөрчлөө гэхээр Хүний эрхийн Үндэсний Комисс руу л сүүлийн үед ингээд л шаардаад л, уурлаад л Хүний эрхийн Үндэсний Комисс бараг муу хийж байгаагаас болоод хүний эрх зөрчигдөөд байгаа юм шиг ойлгоод байгаа юм. Хүний эрхийн зөрчил бол хаа сайгүй, аль ч газар байдаг. Хүний эрхийн зөрчлийг хянан шийдвэрлэх механизмууд улс орнуудад олон янз. Гэхдээ ер нь бол гол юм нь бол шүүхийн болон шүүхийн бус журмаар хүний эрхийг хамгаалдаг. Шүүхийн болон шүүхийн бус журмаар. Азийн орнууд илүү их тийм шүүхийн бус журмаар харилцан ойлголцол, зөвшилцөл гэдэг юм уу нийгмийнхээ тэр өнгө аясаар юмыг өөрчилдөг. Мэдээж хүний эрхийн тэр шүүхийн бус журам дотор бол хууль зүйн хамгаалалтаас гадна хэвлэл мэдээллээр дамжсан хамгаалалт гэдэг юм уу янз бүрийн юмнууд бий л дээ задлаад яривал.

Тэгэхээр энэ хамгаалалтын механизмын ойлголтыг их зөв ойлгуулах хэрэгтэй байгаа юм. Одоо манайд ч гэсэн, гишүүд ч гэсэн ингээд шүүмжлээд л ярина л даа. Үгүй ээ, та нар ер нь юу хийж байгаа юм бэ л гээд л. Үгүй ээ, энэ нөгөө гаргаж байгаа тодорхой гомдлууд дээр бол ажиллаж байгаа гэдгээ та нар

тайлбарлах ёстой. Одоо жишээлбэл энэ илтгэл хийж байна. Энэ илтгэл гарахаас өмнө хэчнээн гомдол, санал та нарт тодорхой ямар хугацаанд ирэв. Тэгээд дараа нь энэ илтгэл бичнэ гэж. Ерөөсөө хүний эрхийг хамгаалах ажил бол бүх гишүүдийн л ажил байхгүй юу. Одоо энэ асуулт асуух гэж байгаа манай бүх гишүүдийн л ажил энэ бол. Хүний эрхийг хамгаалах ажил бол Улсын Их Хурлын ч ажил мөн. Засгийн газрын ч ажил мөн. Засаг даргын ажил ч мөн. Хэвлэлийн сэтгүүлчийн ч ажил мөн байхгүй юу. Нийтийн төлөө л гэж чи яриад явж байгаа юм бол хүний эрхийг хамгаалах ажил чинь хамгийн тэргүүн шугам дээр байж байгаа л зүйл байхгүй юу. Тэрнээс нэг байгууллага нь хүний эрхийг дангаараа хариуцдаг юм биш.

Тэгэхээр хуулиар та хэд маань чиг үүргээ тодорхой тайлбарлаж өгөх асуудал дутуу байгаад байгаа юм. Ингээд л нэг загнуулаад л, толгой дохиод л, тэгээд л нэг хүнд тайлбарлах гэж оролдоод л ам нь ангалзаад л тэгээд л хүний эрхийн бараг буруутан нь болоод л хувирчхаж байгаа байхгүй юу.

Сая бид Хүний эрхийн Үндэсний Комиссын хуулийг өөрчилсөн шүү дээ. Тэгээд л нийгэмд нэг бухимдалтай асуудал болохоор зэрэг нөгөө Их Хурал, Засгийн газар, бусад хүнээ загнангуут нь зөрүүлээд л Хүний эрхийн Комисс чинь ер нь ажлаа хийж байгаа юм уу гээд л эхэлдэг. Тэгэхээр та хэд маань ажил, үүргийг чинь хүрээ хязгаар юу юм. Ямар хэмжээнд хүмүүс гомдол санал өгөөд байгаа юм. Тэрний дагуу ямар зөвлөмж шаардлага тавьсан юм. Энэ дотор чинь байна лээ. Тэгээд энийгээ товчлоод ойлгуулах тал байхгүй юу.

Ер нь энэ хүний нийгмийн чинь хамгийн том проблем бие биеийнхээ тухай сургаар ингээд л хүн муу хэлээд яваад байдаг болохоос биш яг нүүр тулаад уулзахаар л олон асуудал ойлгогддог, тайлбарлагддаг байхгүй юу. Тэгээд

хамгийн гол яах вэ Хүний эрхийн Үндэсний Комисс дээр хүмүүсийн хүлээдэг юм юу юм бэ гэхээр цөхрөөд бараг нөгөө шударга бус өчнөөн юм болоод ирсний дараа энэ нэг намайгаа анхаарах болов уу л гэж очиж байгаа юм. Тэгээд шаардлага зөвлөмжийг авна. Тэгэхээр Хүний эрхийн Үндэсний Комисс дээрх тодорхой хэмжээний дарамт шахалт юу байдаг юм. Байдаг юм уу, үгүй юм уу. Тэгээд энэ илтгэл тавьж байна. Одоо 23 дахь удаагийн илтгэл шүү дээ. Энэ чинь цаашилаад Монгол Улсын Их Хурла, Засгийн газар авч үзээд цаашаа олон улсын байгууллагууд дээр бид хамгаалдаг, олон улсынхан чинь хардаг. Ер нь ардчилсан, ардчилсан бус улс орныг уг нь хамгийн энгийнээр бол юугаар хэмждэг юм бэ гэхээр иргэд нь төрөөсөө айдаг байвал тэнд дарангуйлал байна л гэж үздэг. Харин төрд байгаа хүмүүс нь иргэдээсээ эмээдэг, тэднийхээ шахалт шаардлагыг сонсдог тэр ардчилсан л улс орон болдог байхгүй юу.

Тэгэхээр одоогийн ингээд явж байгаа бид нарын юмаар бол хүний эрхийн зөрчил хавтгайдаа байгаа нь үнэн. Төрийн байгууллагууд сая бид юуны хуульд заалтууд оруулж байна. Их Хурлын тухай хууль бусад хуульд нь Төрийн албаны зөвлөл ажлын байран дахь бэлгийн дарамт, хүчирхийллийн асуудал ямар байгаа юм гээд л ингэдэг ч юм уу. Одоо ерөөсөө ингээд жендерийн мэдрэмжтэй байя. Хүчирхийллийн эсрэг мэдрэмжтэй байя гээд ахицууд гараад байгаа байхгүй юу. Ер нь манай одоо нэг үг байгаа.../минут дуусав/

Г.Занданшатар: 3 номер. Дугарын Сүнжид Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга харуулна.

Д.Сүнжид: Сүхбаатар гишүүний тайлбар, тодруулга асуултад харуулъя. Энэ үнэхээр чухал асуудал. Хүний эрхийг хэн хангах ёстой вэ. Төрийн бүх байгууллагууд хангах ёстой. Үндсэн хуулийн 19-ийг уншихаар бид нар бол

хүний эрхийн эдийн засгийн, хууль зүйн баталгааг төр бүхэлдээ энэ үүргийг хүлээх бөгөөд хэрвээ зөрчигдсөн бол түүнийг нь сэргээн илрүүлэх механизм төрийн өөрийнх нь хүлээх үүрэг болдог. Ийм учраас төрийн эрх мэдлийн бүх байгууллагууд хүний эрхийг хангах, хамгаалах тогтолцооны нэг хэсэг. Бүгд үүрэг хүлээгчид болдог. Хүний эрхийн Үндэсний Комисс энэ дунд ямар чиг үүрэг хүлээдэг вэ гэхээр хуулиараа 1 дүгээрт Улсын Их Хуралд илтгэлээрээ дамжуулаад, Хүний эрхийн тулгамдсан асуудлыг илэрхийлэх, дүн шинжилгээ хийх, шийдвэрлэх ёстой саналыг гаргах 1 дүгээр үүрэг бий.

2 дугаарт нь Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдэд хүний эрхийн асуудлуудыг санал зөвлөмж гаргах ийм чиг үүрэг байгаа. Мөн олон улсын гэрээ конвенцод нэгдэж орох эсэх талаар энэ хүний эрхийн үүднээс ямар байр суурь байгаа вэ гэдэг ийм дүгнэлтийг гаргах үүрэг бий. Гүйцэтгэх эрх мэдлийн тогтолцооны тухайд Хүний эрхийн Үндэсний Комисс хяналт шалгалтыг хэрэгжүүлдэг тогтолцоо өөрөө ажиллаж чадаж байна уу, тэнд уялдаа холбоо байна уу, эцэстээ хүний эрхийг үр дүнтэй хамгаалж чадаж байгаа юм уу, үгүй юу гэдэг хяналт шалгалтыг хэрэгжүүлж хөндлөнгөөс нь зөвлөмж шаардлага хүргүүлэх байдлаар ажилладаг. Шүүх эрх мэдлийн байгууллагатай бол зөвхөн процессын эрхийн хүрээнд 22.2 дахь заалтаар мэдээж зэрэгцэн ажилладаг шүүх эрх мэдэл байх боломжгүй учраас хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохгүй. Процессын эрхийг нь хангахад зөвлөмж шаардлага өгөх, санал хүргүүлэх, хамтран хэлэлцэх байдлаар оролцдог. Иргэний нийгмийн байгууллагуудтайгаа хамтрах ийм үүргийг хүлээдэг. Хүний эрхийн боловсролыг түгээх, дэмжих, сурталчлах, ойлгуулах энэ үүргийг хүлээдэг. Ийм үндсэн хэд хэдэн үүрэг бий. Түүнээс гадна иргэдээсээ бид нар шууд гомдлыг хүлээж авдаг.

Өнгөрсөн 2023 оны байдлаар гэхээр 1027 гомдлыг хүлээж авсан байна. Хамгийн их ирж байгаа гомдол халдашгүй байх эрхтэй холбоотой. Шударга шүүхээр шүүлгэх, эрүү шүүлтээс ангид байх, хууль зүйн туслалцаа авах гээд энэ эрхтэй холбоотой асуудлууд бий. Тэгээд дараагийнх нь хөдөлмөрлөх эрхтэй холбоотой асуудлууд ирж байна. 145 удаагийн хяналт шалгалтыг жилийн хугацаанд зохион байгуулсан. Үүнээс гишүүд өөрсдийнхөө санаачилгаар 119-ийг нээсэн байна буюу дийлэнх ихийг нь бид нар гишүүдийн санаачилгаар ингэж хийж явж байгаа юм. Ингээд нийтдээ 87 зөвлөмж шаардлагыг хүргүүлэн ажиллаж байна. Тэгэхээр энэ тогтолцоо өөрөө уялдаа холбоотой ажиллах ёстой гэж Сүхбаатар гишүүний хэлж байгаа санал их чухал юм.

Г.Занданшатар:

Жамьянхорлоогийн Сүхбаатар гишүүн тодруулж асууя. 1 минут.

Ж.Сүхбаатар: Би 1999 онд Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгийн хуулийн бодлогын зөвлөхөөр ажиллаж байсан юм. Тэр үед хүний эрхтэй холбоотой Хүний эрхийн Үндэсний Комиссын асуудал яригдаад, том төсөл тэр үедээ л том дүнтэй юм байсан. Тэгээд тэр үед би өөрөө судалж үзэж байсан юм нь ombudsman тогтолцоо байгаа. Хүний эрхийг хамгаалдаг 2 янзын юм байгаа. *dispozitive ombudsman*, *imperative ombudsman* гээдб *Dispozitive ombudsman* бол заавал биелүүлэх шаардлага тавьж чаддаггүй зөвлөмж гаргадаг байгууллага байсан. *Imperative ombudsman* тогтолцоо нь бол заавал биелүүлэх шаардлага тавиад, тэрийг нь төрийн байгууллага биелүүлдэг байсан. Тэгэхээр 20 гаруй жилийн хугацаанд, 20-иод жилийн хугацаанд бид нар бол *Dispozitive ombudsman*-ын хэлбэрээр явцуу хүрээнд явж байгаад, сая сүүлд энэ Их Хурал маань заавал биелүүлдэг ч *Imperative ombudsman*-ны тогтолцоо руу орсон.

Тэгэхээр энэ яадаг вэ гэхээр манай энэ хүмүүс бас ойлгох ёстой байгаа юм. Энэ *Imperative ombudsman*-ны тогтолцоотой улс орнууд дээр ганц Хүний эрхийн Үндэсний Комисс нь яг энэ хэлбэрээрээ ажиллахгүй. Яагаад гэвэл төрийн байгууллагууд болгон дээр хүний эрх хамгаалагч.../минут дуусав/

Г.Занданшатар: Дугарын Санжид. Энэ зөвлөмжүүд заавал биелэгдэх шинж чанартай байх тухай. 2 дугаарт нь хүний эрх хамгаалагчийг бэлтгэдэг сургууль боловсролын тогтолцоо байх уу гэсэн ийм асуудал байгаа. 3 номер. Сүнжид хариулна.

Д.Сүнжид: Сүхбаатар гишүүний тодруулгад хариулъя. Шаардлага зөвлөмж заавал биелэгдэх ёстой. 30 хоног, 60 хоногийн дотор өгч байгаа юм л даа. Тэгээд хариу биелэлтээ ирүүлдэг. Бид нар дүн шинжилгээ хийгээд илтгэлийнхээ ард хавсаргасан. Ингээд үзэхээр 87 шаардлага зөвлөмжөөс 2 шаардлага, 6 зөвлөмж энэ биелэлт хангалтгүй. Ирүүлэхийн хувьд бол ирүүлсэн. Тэгэхдээ ямар асуудал байна вэ гэхээр зөвлөмжөөр, шаардлагаар өгч байгаа асуудлыг үр дүнтэй хэрэгжүүлэх үнэхээр тэнд хүний эрхийн зөрчлийг таслан зохиох гэдэг асуудал дээр нэгдмэл ойлголттой байх үүрэг хүлээгч гэдгээ хаана хаанаа ухамсарлах асуудал үнэхээр чухал байна. Тэрнийхээ араас бид нар эргэх холбоотойгоор ажиллаж байгаа. Энэ жил энэ шаардлага, зөвлөмжийн биелэлтийн мөрөөр Хууль зүйн байнгын хороо дээр хэлэлцсэн. Бид нар нөгөө арга зүйн зөвлөгөө өгөх, туслах, таслан зогсоох, хуулийг таниулах бүх чиглэлээр хамтран ажиллахад бол бэлэн байдаг.

Хүний эрх хамгаалагчийн асуудал үнэхээр чухал байгаа юм. Энэ одоо ардчилсан нийгэмд бол хүний эрхийн асуудал бүх.../минут дуусав/

Г.Занданшатар: Сүнжид 3 номер. Хариултыг дуусгая.

Д.Сүнжид: Хүний эрх хамгаалагчийн хувьд төрийн болон төрийн бус байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллага, иргэний нийгмийн төлөөлөл, идэвхтнүүд бүгдийн хувьд л чухал байгаа. Энэ зөвхөн нөгөө төрийн биш, одоо яг халиад таны хэлээд байгаа санаагаар энд бол нөгөө байгууллагууд заавал төрийнх биш хүний эрх хамгаалагчтай байж болно. Тэндээ ер нь анхан шатдаа бид нар нөгөө таны анх хэлээд байгаа шүүхийн бус журмаар маргааныг яаж хянан шийдвэрлэх юм, тэнд яаж зөрчлийг илрүүлдэг, танддаг, хариу арга хэмжээ авдаг байх юм бэ гэдэг энэ систем дээр илүү ач холбогдол өгөх юм бол зөрчил нь буурдаг ийм л тогтолцоотой юм билээ. Олон улсын тогтолцоо бол. Тийм ч учраас жендерийн асуудал хариуцсан гээд жишээ нь байгууллага болгон дээр бусад улсын жишиг байна л даа. Хүний эрх хамгаалагч гээд бас 1 хүн оноочихдог. Тэгээд тэр хүн нь урьдчилан сэргийлэх, таниулах, мэдүүлэх, нэгдмэл ойлголттой байх, шийдвэр гаргахад нь туслах, зөвлөх энэ ажлыг хийж байдаг. Тэгээд дараа нь хэрвээ болохгүй бол бусад байгууллагууд нь гэмт хэргийн шинжтэй, зөрчлийн шинжтэй бусад асуудал байх юм бол шүүх эрх мэдлийн байгууллага, хууль хяналтын байгууллагууд нь оролцдог байх жишээтэй ийм зэрэгцсэн байж байж ялангуяа энэ шүүхийн бус журмаар явах энэ тогтолцоо хүний эрх хамгаалагчийн асуудлыг бэхжүүлж байж энэ сууриараа бүгд бэхжиж зөв болох юм билээ. Тантай санал нийлж байна.

Г.Занданшатар:

Жамьянхорлоогийн Сүхбаатар гишүүн 1 минут тодруулъя.

Ж.Сүхбаатар: Тэгээд юу л даа би зүгээр санааг нь ингээд та бүхэнд хэлэхэд яах вэ, хариулахгүйгээр цаг бага байгаа учраас. Би бол энэ том их сургуулиуд дээр нэг тийм баймаар байгаа юм эхний ээлжид. Одоо МУИС, ХААИС гэдэг юм уу

ийм олон мянган оюутнуудтай тэнд сүүлийн үед бэлгийн дарамт, элдэв юм яригддаг ингээд байна шүү дээ. Тэгэхээр Хүний эрхийн Үндэсний Комисс хүч хүрэхгүй. Олон газар тавивал бас хөрөнгө мөнгө хэцүү. Тэгэхээр Австралид жишээлбэл том их дээд сургуулиуд *ombudsman* ажилладаг юм байна лээ. Тэр сургууль дээр. Тэрэн шиг ингээд олон мянган залуучууд оюутнууд ингээд байж байгаа тодорхой ийм хэсэг дээр бол хүний эрх хамгаалагч тийм хүн ажиллаад, ажиллаад оюутнуудын гэдэг юм уу тодорхой тэр хүмүүсийн гомдол, саналыг нь авч шийдвэрлэдэг байх нь зүйтэй юм байна лээ. Би тэр утгаараа энийг та хэд маань бодоосой билээ. Өнөөдөр 23 дугаар илтгэл тавьж байна. Зөрчлүүд гараад байдаг. Цаана нь ер нь явж явж хүний сэтгэлгээг өөрчлөх, хүнтэй ажиллах ийм л потенциал чадвар дутаад байгаа шүү дээ.

Г.Занданшатар: Үг хэлчихлээ. Сандагийн Бямбацогт гишүүн.

С.Бямбацогт: Сая Сүхбаатар гишүүн хэлсэн. Хүний эрхийн Үндэсний Комисс урьд нь зөвлөмж өгдөг нэг тийм шүдгүй арслан шиг юм байсан. Бид нар 2021 онд Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийг шинэчилэн найруулж, батлаад Хүний эрхийн Үндэсний Комиссын үйл ажиллагааг илүү өргөжүүлж, шүдтэй арслан албан шаардлага хүргүүлдэг, шаардлагыг нь заавал биелүүлдэг байх ёстой. Биелүүлэхгүй бол хариуцлага тооцох энэ тогтолцоог бүрдүүлж өгсөн. Гэтэл л ажлаа бас л сайн л хиймээр санагдаад байгаа юм.

Монгол Улсын үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 2-т Монгол хүн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй гээд заачихсан. 21 аймгийн төв, Улаанбаатар хот утааныхаа асуудлыг шийдэж чадахгүй байгаа. Энэ асуудлыг шийдэх гээд л

амьхандаа орон сууцжуулах, дэд бүтцийн шугам сүлжээ тавих, амины орон сууц барьж гал түлэхгүй, утаа гаргахгүй, өвлийн хүйтэнд ээж нар нь хар үүрээр босч үнс нурамтай зууралдаад зүдрэхгүй, хүүхдүүд нь худгаас ус зөөгөөд, түлээ хөрөөдөөд, хагалаад, нүүрс зөөгөөд, хичээлээ хийх завгүй амьдрахгүй байх бололцоог бүрдүүлэх гээд л үзээд байгаа юм л даа. Энэ үндсэндээ утаагүй болох юм бол Монгол хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдлоос хамгаалуулах эрх нь хангагдана. Гэтэл энийг хийх гээд улсын төсөв дээр бид нар ипотекийн зээлийн 50 хувийг орон нутагт өгье. Дээрээс нь ипотекийн зээлийн хүүг 3 хувь болгоё. Улаанбаатарт 6 хувь, орон нутагт 3 хувь. Дахиад инженерийн шугам сүлжээтэй амины орон сууцуудад өгөх ёстой гээд Монгол Улсын Их Хурал хууль батлаад байхад ерөөсөө хэрэгжихгүй байгаад байна. Энэ дээр та бүхэн шаардлага хүргүүлээд, заавал биелүүлэх талд нь анхаараад ажиллах боломжтой юу. Энэ Улсын Их Хурлын баталсан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж чадах уу. Энэ дээр нэг хариулт өгөөч.

2 дугаарт нь Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 18 дээр байж байгаа. Монгол Улсынхаа нутаг дэвсгэр дээр чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох эрхтэй. Одоо сүүлийн үед ерөөсөө Улаанбаатарт амьдрах юм бол татвар төл, машин унаж болохгүй, орж ирсэн орон нутгийн машинуудаас татвар авна гээд ийм юм ярьж байгаа. Энэ одоо зөрчил үү. Нөгөө талдаа орон нутагт амьдарч байгаа иргэддээ бид нар орон нутгийн нэмэгдэл олгож байгаа. Улаанбаатарт хотод амьдарч байгаад нь олгохгүй байгаа. Гэтэл үүнийг цааш нь одоо олгохдоо өшөө төгөлдөржүүлээд Улаанбаатараас алслагдах тусмаа илүү хөнгөлөлттэй, илүү дэмжлэгтэй байх энэ бололцоо боломжийг бүрдүүлмээр байна л даа. Би 2011 онд хууль санаачлаад, 2017 онд батлагдсан. Улаанбаатараас алслагдсан аймгуудад Аж ахуйн нэгжийн

орлогын албан татвар 1000-аас дээш алслагдсан аймгууд 1 хувь болсон, 500-1000-тайд 5 хувь болсон. Яг үүнтэй адилхан Хувь хүний орлогын албан татварыг ийм адилхан болгох бодолтой байгаа. Ийм хууль санаачлах гэж байгаа. Ингээд явбал иргэдийг ялгаварласан болох уу, эсвэл хүний эрхийн зөрчил болох уу. Энэ харин ч зөв үү. Энэ оришин суугаа газартаа л аятай тухтай амьдрах бололцоо бүрдүүлэх гээд байна шүү дээ. Тэр хүн төрж өссөн нутагтаа сайхан амьдрах эрхтэй. Тэр эрхийг нь бүрдүүлж өгмөөр байна. Тэгэхгүй өнөөдөр Улаанбаатараас алслах тусмаа бензин өндөр, цахилгаан нь өндөр, гурил нь өндөр, будаа нь өндөр, хувцас хунар, гутал нь өндөр, чихэр жимс нь өндөр. Үүнээсээ болоод үндсэндээ зардал өндөртэй амьдраад байгаа юм. Тийм болохоор зардлыг нь бууруулах, орлогыг нь нэмэгдүүлэх ийм бас нэг ялгавартай бодлого явуулбал энэ хүний эрхийн зөрчил болох уу, болохгүй юу. Энийг хэрхэн яаж явуулж болох вэ. Энэ дээр та бүхэн тодорхой зөвлөмж санал байвал хэлээч.

Г.Занданшатар: Дугарын Сүнжид. 3 номер хариулъя.

Д.Сүнжид: Бямбацогт гишүүний 2 асуултад хариулъя. Эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх, орчны тэнцэл алдагдахуулаас хамгаалах эрх үнэхээр асуудал болсон. Бүх нийтийн асуудал болсон. Зөвхөн Улаанбаатар хот төдийгүй нийт аймгуудын төв, суурин газар бэлчээрийн доройтол бас ингээд малчдын хувьд ч гэсэн асуудал болчихсон. Одоо үүний эсрэг бид 23 дахь илтгэлдээ юу гэж дүгнэсэн бэ гэхээр ер нь Монгол Улсын Засгийн газар, Улсын Их Хурлаас 2010 оноос эхлээд энэ үнэхээр тулгамдсан асуудал болжээ гэдгийг дүгнээд, тодорхой арга хэмжээ шат шатдаа аваад байсан юм байна. Тэгэхдээ 2017 онд энийг нэгдсэн байдлаар зангидахгүй болохгүй нь гээд Агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр Засгийн газраас баталжээ. Тэрний хэрэгжилтийг

авч үзэхээр 2021 оны Аудитын газрын тайлангаар 67 хувь нь хэрэгжээгүй.

Тэгэхээр бид нар нэг өмнө тавьчихсан асуудал байгааг бүгдээрээ олж харж байгаад таниад мэдчихсэн. Энийг шийдэх ёстой гэдгийгээ боловч арга зам эх үүсвэрээ зохицуулж байгаа байдал энэ өөрөө хангалтгүй байна л гэж дүгнээд байна. Энэ зөвхөн нэг салбарын асуудал биш. Тэгэхээр энэ 2017 оны Засгийн газрын энэ саяын тогтоолыг 2025 онд дуусах ёстой. Энийг бүхэлд нь хэрэгжилтийг нь үнэлээд, өдий хүртэл 456 тэрбум төгрөг зарцуулчихсан байна гээд. Тэгээд ямар үр дүн гарсан бэ гэхээр өвлийн улиралд зарим нэг хэмжээгээр ийм сайжруулсан түлшийг Улаанбаатар хотод хэрэглээд тэр азотын хий, үхрийн хүчил нь хэмжээ нь арай буурсан боловч хэзээ ч нөгөө эрүүл мэндийн хувьд байх ёстой гээд байгаа индексдээ хүрээгүй хэвээрээ л байгаад байгаа учраас одоо цаашидаа богино, дунд, урт хугацааны бодлогоо төлөвлөх, төлөвлөхдөө тэр хэмжигдэхүйц тодорхой цаг хугацааны мөчлөгтэй тэгээд үр дүн гарахуйц тэр байдлаар шалгуур үзүүлэлтийг тавиад, хамгийн гол нь санхүүгийн эх үүсвэрээ уялдуулах талаар бодоод, хариуцаж байгаа нэгжийг тогтвортой ажиллуулахгүй 2010 оноос хойш 5, 6 удаа өөрчлөгдөөд явчихсан ийм дүр зурагтай юм билээ.

Тэгэхээр би энийг юун түрүүн өмнөх 2017 оны тогтоолын хэрэгжилтээ үнэлээд, дараагийнхаа тодорхойлох ёстой юм байна гэж үзсэн. Энэ дээр бол тэр салбар хоорондын асуудал учраас Засгийн газраас мөн цаашидаа тэр нь алсын хараа, агаар, орчны бохирдлыг бууруулах талаар бусад энэ бодлогыг шинэчлэн тодорхойлж байж, дараа нь энэ жижиг жижиг арга хэмжээгээ төлөвлөхгүй бол өнөөдрийн тулгамдсан асуудал нь түүхий нүүрсний хэрэглээ 80 хувь.

Ипотекийн зээл дээр бид нар энэ 23 дахь илтгэлдээ зээл, ногоон зээлийг гаргах, тэр шинэ техник технологи үйлдвэрлэх, дамжуулж оруулж ирэх энэ асуудлыг судалж шийдвэрлээч, мэргэжлийн хүмүүсийнх нь саналыг нь аваач л гэж зөвлөж байгаа юм.

2 дахь асуултын тухайд аль ч улс орон Үндсэн хуулиар бид нар Үндсэн хуулийн 14 дээр хэнийг ч ялгаварлахгүй гэдэг. Тэгээд тодорхой шинжийг заадаг. Гэхдээ 5 шалгуур тавьдаг. Хэрвээ бид нар тодорхой зорилттой бүлгийг дэмжих юм уу, эс дэмжих юм бол энэ шалгуурыг хангаж байна уу гэдгээ л үздэг. Үүний нэг нь бодитой нөхцөлдөө тохирсон уу, зорилгодоо нийцсэн үү л гэдэг асуудал байдаг. Энийг Их Хурлаас татвар тогтоох онцгой бүрэн эрхийнхээ хүрээнд шийдвэрлэж болох уу. Болно. Гол нь үүгээрээ бид нар ямар үр дүнд хүрэх юм бэ гэдэг тэр тэнцвэртэй байдлын зарчим гэж бид нар яриад байдаг. Үнэхээр энэ хэсгийг дэмжих шаардлагатай гэдэг үндэслэл байгаа юм бол энэ боломжийг олгодог ийм шалгуурыг тавьдаг.

Г.Занданшатар: Ганзоригийн Тэмүүлэн гишүүн асуулт асууна.

Г.Тэмүүлэн: Та бүхэнд энэ өглөөний мэндийг хүргэе. Би энэ хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлтэй холбогдуулаад, энэ тайлантай холбогдуулаад Хүний эрхийн Үндэсний комиссоос Засгийн газарт хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах, дэмжих чиглэлээр оруулж ирж байгаа энэ тогтоолын төсөлтэй холбогдуулж 2, 3 асуудлыг хөндөж ярья л гэж яриад байгаа юм.

1 дүгээрт би зүгээр зарчмын асуудал нь бид нар өөрсдөө Монгол Улс бол өөрөө ардчилсан улс учраас хүний эрхийг хамгаалах, хүний эрхийг дэмжих, хүний эрх, эрх чөлөөг хангах бол зайлшгүй шаардлагатай. Энэ бол суурь зарчмын асуудал. Энэтэй холбоотой та бүхний

тайлан дээр орж ирсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх эрх, эрх чөлөөний талаар дүгнэлт орж ирсэн байна. Би зүгээр нэг талдаа нэг зарчмын асуудлыг хөндөж ярих гээд байгаа нь ер нь бид нар энэ хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хууль томьёо болоод хууль, эрх зүйн талаасаа, хууль зүйн тодорхойлолт талаасаа, хууль зүйн утга агуулга талаасаа хөгжлийн бэрхшээлтэй гэж томьёолж байгаа чинь өөрөө зөв юм уу. Хүний эрх, эрх чөлөөнд бид нар ямар нэг байдлаар тэр хүнтэй хүнлэг харьцах ёстой. Хүний эрхийг нь хамгаалах ёстой. Ялгаварлан гадуурхахгүй байх ёстой. Гэтэл хууль, эрх зүйн тодорхойлолт нэр томьёо талаасаа эргээд тэр хүнийг хөгжлийн бэрхшээлтэй гээд ялгаад байгаа чинь өөрөө зарчмын хувьд зөв юм уу. Энэ бол нэг талдаа бид нар уг нь нэг нэр томьёог бол хэвшүүлэе гэж яриад байгаа шүү дээ. Тусгай хэрэгцээт иргэд гэдэг асуудал. Тусгай хэрэгцээ. Тэр хүмүүс бол ямар нэг байдлаар хөгжлийн бэрхшээлтэй иргэд биш байхгүй юу. Монгол улс бол тэр хүнд хөгжих боломжийг нь Монгол Улсын иргэн болгон энэ 3,5 сая иргэн болгонд хүний хөгжлийг хангах, хүний хөгжлийг нь бий болгох тал дээр бол адил тэгш хандах ёстой. Тэгш боломжийг бид нар олгох ёстой. Тэгэхээр эргээд тэр хүнийг та хөгжлийн бэрхшээлтэй гэж ялгаж болохгүй л гэж хараад байгаа юм. Тэр хүмүүс бол нэг талдаа тусгай хэрэгцээтэй. Тэр хүмүүст магадгүй хэрэгцээтэй зүйл нь л өөр байгаа болохоос биш, тэр хүмүүс болгон бүгдээрээ хөгжлийн бэрхшээлтэй гэж ялгах нь бол зарчмын хувьд буруу байна. Тэгэхээр адаглаад хууль зүйн талаасаа зөв хуульчлах ёстой юм биш үү. Эрх зүйн орчныг нь зөв бүрдүүлээд, адаглаад анхан шатаасаа хууль, эрх зүйн орчин талаасаа Монголын төр ч гэсэн зөв хандлагыг бий болгох ёстой юм биш үү. Эргээд бид нар нэр томьёо нь өөрөө буруу байхаар буруу хандлага тогтоод байдаг. Эргээд ялгаварлан гадуурхагдаад байдаг ийм асуудал үүсээд байна гэдэг асуудал энд л гээд байгаа юм. Тэгэхээр энэ тал дээр та

хэд ер нь яг Хүний эрхийн Үндэсний Комисс бол бүр суурь энэ харилцаанаасаа авхуулаад ер нь энийг анхаарч үзэх ёстой юм биш үү гэдэг 1 дүгээр асуудал.

Хоёрдугаарх нь, сая Улсын Их Хурлаас шийдвэр гарсан 4 сарын 1-ээс төрийн албан хаагч нар дээр 3 жил болоод, 5 жил ажиллах тутамд нь бол 6 сарын тэтгэмж олгож эхэлсэн. Гэтэл Улсын Их Хурлын гаргасан шийдвэрийг Засгийн газар хэрэгжүүлэхдээ журам дээрээ бол тодорхой ялгамжтай байдлаар, ялгавартай байдлаар тусгаад, эргээд эрэгтэй, эмэгтэй хүмүүс тэгш бус байдлаар тэтгэмж авах энэ хандлага бий болж гарч ирж байна. Юу вэ гэхээр 40 хүртэлх насны эмэгтэйчүүд төрийн албан хаагч нар хүүхэд төрүүлснийхээ төлөө, хүүхдээ асран хамгаалсныхаа төлөө энэ тэтгэмжийг авах боломжгүй болж байна гэдэг асуудлыг хөдөө, орон нутагт байгаа эмэгтэйчүүд, төрийн албан хаагч нар, багш нар маш ихээр ярьж байна.

Яагаад вэ гэвэл тэр эргээд Засгийн газраас заасан журмын дагуу тасралтгүй 5 жил ажилласан байх ёстой гэдэг үндсэн дээрээсээ 40 хүртэлх насны эмэгтэйчүүд үндсэндээ энэ тэтгэмжийг 3 жил болон, 5 жилийн тэтгэмжийг авах боломжгүй болчихлоо. Тэгэхээр бид нар жендерийн уг нь бол мэдрэмжтэй төсөвлөлт гэдэг асуудлуудыг яриад байгаа. Жендерийн тэгш байдал гэж яриад байгаа. Хууль хэрэгжилтийн шатан дээрээ ингээд жендерийн тэгш бус байдлыг бий болгоод байвал яах юм бэ. Энийг та нар анхаарч үзэж Засгийн газарт чиглэл өгөх тогтоол дээр оруулж байгаа юм уу. Яагаад ер нь тусгагдаагүй байгаа асуудал байна вэ.

Г.Занданшатар: 2 номер.
Нарантуяа.

Г.Нарантуяа: Тэмүүлэн гишүүний эхний асуултад хариулъя. Тэгэхээр хөгжлийн бэрхшээлтэй хүн гэдэг нэр томьёо Монгол Улсын эрх зүйн

тогтолцоонд 2006 оноос орж ирсэн нэр томьёо. Үүний өмнө Тахир дутуу хүн гэж нэр томьёо байсан. Боловсролын тухай хуулиудад бол хөгжлийн хоцрогдолтой гэдэг нэр томьёо байдаг байсан учраас энэ дээрээс үндэслээд бол тахир дутуу гэдэг ийм доромж өнгө аястай нэр томьёог өөрчлөх оролдлого нь бол хөгжлийн бэрхшээлтэй хүн гэсэн ийм хууль зүйн нэр томьёо үүсгэж бий болсон түүхтэй. Ер нь тусгай хэрэгцээтэй хүн гэхээр ер нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай Монгол Улсын хуулийн үзэл санаа бол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бол тусгай хүмүүс биш юм. Нийгэмдээ бусдын нэгэн адил амьдрах ийм боломж бололцоотой байх ёстой гэдэг энэ үзэл санааны үндсэн дээр боловсруулагдсан ийм хууль, эрх зүйн орчин үйлчилж байгаа. Энэ концепцыг бодоход бол тусгай хүмүүс тусгай хэрэгцээтэй гэдэг нэр томьёо ч гэсэндээ тусгай гэдэг категорийг илэрхийлэх ийм нөхцөл байдал үүсгэдэг. Тэгэхээр Хүний эрхийн Үндэсний Комисс дээр энэ чиглэлийн онолын чиглэлийн яриа мэтгэлцээн, маргаанууд болдог. Тулгам хүн гэж нэрлэе. Эсвэл бүр өөр цоо шинэ нэр томьёо бодож олъё гэдэг ийм санаачилгуудыг бол хүмүүс гаргадаг.

Тэгэхдээ энэ дээр 1 зүйлийг онцолж хэлмээр байгаа юм. Өнөөдөр нэр томьёо бол чухал уу, хүнлэг байх ёстой юу. Үнэхээр байх ёстой. Бид болж өгвөл нэг Монгол улсын төрийн бодлого хүнд хандаж байгаа энэ хандлагыг илэрхийлсэн хууль зүйн нэр томьёонуудыг бий болгох ёстой. Гэхдээ үүнээс чухал нэг асуудал байгаа нь бол өнөөдөр хөгжлийн бэрхшээлтэй хүн гэж хэнийг хэлэх юм бэ. Энэ нь архаг өвчтэй элэгний циррозтой хүнээс яаж ялгагдах юм бэ гэдэг энэ тодорхойлолт байхгүй байгаагаас болоод хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс рүү чиглэсэн төрийн бодлого бас төдийлөн оновчтой гарч чадахгүй байгаа гэдгийг

энэ асуулт тавьсан боломжийг ашиглаад сануулъя гэж бодлоо. Баярлалаа.

Г.Занданишатар: 3 номер Дугарын Сүнжид.

Д.Сүнжид: Тэмүүлэн гишүүний 2 дахь асуулт. Энэ үнэхээр чухал асуулт. Хүний эрхийн Үндэсний Комисст удаа дараа гомдол ирж байгаа юм. 2 асуудлаар. Саяын таны дурддаг тасралтгүй 5 жилийн асуудал байна. Түүнээс гадна зарим нэг босоо удирдлагатай байгууллагуудын орон нутагт ажилладаг албан хаагчид орон нутгийн нэмэгдлийг авч чадахгүйд хүрлээ. Засгийн газрын тогтоолын улмаас гэдэг асуудал ирж байгаа. Тийм учраас энэ дээр ажиллагаа хийгээд явж байна. Хүний эрхийн комиссоос дүгнэлт гаргана.

Г.Занданишатар: Ганзоригийн Тэмүүлэн гишүүн тодруулж асууя. 1 минут.

Г.Тэмүүлэн: 1 зүйлийг бас тодруулаад асууя. Энэ хүний эрхийг хамгаалахтай холбоотойгоор тухайлбал ажил хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүсийн ажлын байрны бид нар үнэлгээг нь хийх ёстой байгаад байгаа. Ажил хөдөлмөрөө, үүргээ гүйцэтгэх баталгааг нь бол хангах ёстой байгаад байгаа. Тэгэхээр орон нутагтай холбоотойгоор яг иймэрхүү онцлогтой, онцгой нөхцөлд ажиллаж байгаа, ажлын байрных нь нөхцөл байдал тааламжтай бус ийм нөхцөлүүд байна. Тэр дундаа юу гэдэг юм магадгүй галч нар гэдэг юм уу, дээрээс нь багш нартай холбоотойгоор бол биеийн тамирын багш, дуу хөгжмийн багш нар ч гэдэг юм уу. Тэгэхээр яг энэ ажлын байр дээр нь үнэлэлт дүгнэлт хийгээд, ялгамжтайгаар тэтгэвэрт гарах насыг нь тогтоох, наашлуулах боломж бололцоо байна уу. Эргээд аваад үзэхээр ажлын байрных нь үнэлгээ нь хийгдээгүй. Тэгээд тэрнээс үүдээд ялгамжтайгаар бид нар тэтгэвэрт гарах насыг наашлуулах 50, 55 болгох боломж байхгүй байна гэж яваад

байдаг. Гэтэл магадгүй 60 хүрч байгаа дуу хөгжмийн багш, биеийн тамирын багш нар хүүхдүүдийнхээ юу гэдэг юм хөгжлийг гүйцэхгүй ч гэдэг юм уу, ажил үүргээ бүрэн гүйцэтгэх боломжгүй болчихоод байдаг. Энэ дээр яах вэ гэдэг асуудлууд байгаа.

Г.Занданишатар: Хэн хариулах вэ. 3 номер Сүнжид.

Д.Сүнжид: Энэ нь эхлээд ажлын байрны үнэлгээгээ хийгээд, тэгээд эрх зүйн зохицуулалтыг нь бий болгож байж л яг насны ялгамжтайгаар тэтгэвэрт гарах асуудлыг л шийднэ л дээ хуулиар. Тэгэхээр одоо бол хуулиар зохицуулаагүй. Цаашид хэрвээ хуульд ийм байдлаар өөрчлөлт оруулъя гэвэл үндэслэлийг нь судалгаа, дүн шинжилгээ, бодит нөхцөл байдал, мэргэжлийн дүгнэлт дээр үндэслэж л эрх зүйн зохицуулалт, хууль тогтоомжоороо л эхлээд шийдвэрлэх шаардлагатай болно.

Г.Занданишатар: Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Ж.Чинбүрэн: Бүгдэд нь энэ өдрийн мэнд хүргэе. Өнөөдөр бид чухал асуудал, илтгэл сонсож байна. Тэгэхээр ер нь би бас энэ Их Хурлын гишүүддээ нэг уриалах гэж байгаа зүйл бол ер нь Хүний эрхийн Комиссоос гаргаж байгаа энэ илтгэл ер нь бол Их Хурлын гишүүдийн хүний эрхийг хамгаалах чиглэлд хууль санаачлах гарын авлага юм гэж хэлмээр санагдаад байгаа юм. Тэгэхээр бид эндээс болохгүй байгаа, яагаад Монгол Улс Хүний эрхийг хангадаг орнуудын дунд нэлээн тийм хойгуур орж байгаа тэр үзүүлэлтүүдийг бууруулж дээшээ гаргах, ард иргэдээ эрүүл аюулгүй орчинд амьдрах үндсэн эрхийг нь хангах чиглэлд юу хийх ёстой гэдэг санаа энэ илтгэлээр илэрч байгаа гэж хардаг учраас зориуд энийг гишүүддээ анхаараасай гэж хүсэж байна.

2-т хэлэх гэсэн зүйл түүрүүн манай гишүүд нэлээдгүй ярилаа. 16.2-т байгаа эрүүл аюулгүй орчинд амьдрах гэдэг чиглэлд та бүхэн нэг бүхэл бүтэн бүлэг болгоод ингээд тайлангууд тавьж байна. Энэ дотор орчны бохирдолд, агаарын бохирдолд, хөрсний бохирдолд гээд чухал чухал зүйлүүд байна. Мэдээж бид энэ чиглэлд юу хийж чадсан юм. Юу нь амжилтад хүрэхгүй байгаад байгаа юм. Одоо юу хийх ёстой юм энэ тэр гээд л асуудлууд байж байна. Тэгээд манай Монгол эрдэмтдийн хийсэн гаднын том том эрдэм шинжилгээ судалгааны байгууллагуудтай хийсэн судалгааны ажлуудын тайлан, дүгнэлтийг хүртэл энд референтээ оруулаад бичих юм бол та бүгдийн ярьж байгаа, бичиж байгаа зүйл чинь илүү нотолгоотой илүү их хүнд хүрэхээр байгаа байхгүй юу. Жишээлэх юм бол одоо 1.3.1-д агаарын бохирдол дээр та бүхэн түүхий нүүрсний хэрэглээг хязгаарлах гэдэг заалт байж байна. Яагаад гэхээр түүхий нүүрс түлэх нь метил, оксидын хүхрийн исэл агаарт их үүссэнээрээ энэ чинь бүр элэгний хорт хавдар үүсгэж байгаа шалтгаан болчихоод байна шүү дээ. Дэлхий дахинд шинэ нээлт хийчээд байгаа. Нээлт гэдгийг нь гайхуулаад байх зүйл биш л дээ. Тэгэхдээ Монгол Улсад энэ элэгний хорт хавдрын өвчлөлийн 4 хүн тутмын 1-ийх нь шалтгаан нь энэ түүхий нүүрс түлсэн, түүнээс ялгарч байгаа хорт бодистой холбоотой шууд үүсэж байна шүү дээ. Тэгээд энэ энэ чинь одоо Kansas research гээд том АНУ-ын том сэтгүүл дээр хэвлэгдсэн ийм нийтлэл. Би өөрөө үүний авторынх нь 1 нь байж байна.

Тэгээд ийм нотлох баримтууд гарчихсан учраас бид зөвхөн Улаанбаатар хотод түүхий нүүрс түлэхгүй байх гэж ярих биш, гишүүн болгон одоо ялангуяа бүсчилсэн хөгжлийн асуудал яригдаж байна. Энд бол одоо бид энэ бүсчилсэн байдлаар нүүрсийг ингэж түүхийгээр нь төлөхгүй байх нэгдсэн системтэй түлдэг ийм тогтолцоо руу орох асуудлыг хүртэл зөвлөмөөр байгаа байхгүй юу. Тухайлах

юм бол дөнгөж саяхан манайх энэ Баянзүрх дүүрэгт “Амгалан” дулааны станцын өргөтгөл 116мвт-ын том өргөтгөл барилаа. Тэр яндангаас гарч байгаа хийг бид 99 хувийн шүүлтүүрээр цэвэршүүлээд гаргаж байгаа шүү дээ. Тэгээд ийм сайн туршилагууд байна. Тэгвэл энэ сайн туршилагуудыг бусад бүсчилсэн хөгжлүүд дээр бусад хот, тосгон юу байдаг юм энэ болгон дээр, сумдууд дээр хэрэгжүүлдэг нэгдсэн халаалттай болох асуудлыг бид ярихгүй болохгүй ээ.

2 дахь асуудал бид энэ жорлон энэ бол ойлгомжтой. Хөрсний бохирдол ойлгомжтой. Тэгээд цаг бага байгаа учраас би дараагийн та бүхэнд хэлэх гэж байгаа чухал зүйл бол бид эмнэлгийн тусламж авах ёстой эрхийг нэг бүтэн бүлэг болгож өгөөч. Бид сая эмийн түр хорооны сонсгол хийлээ. Ямар сул байна. Ямар аюулгүй нөхцөл байдал хангагдахгүй байна гэдгийг яалаа. Тийм учраас ийм бүхэл бүтэн 1 бүлгээ оруулах асуудал дээр та бүхний энэ судалгааны ажил аль түвшинд явсан бэ. Энэ тал дээр нэг хариулт өгөөч. Энэ бол одоо бүр ярихаас өөр эцэсгүй болчихсон. Дээрээс нь Монгол Улсдаа эмчилж чадахгүй гээд бүр зарлачихсан өвчтөнүүдээ бид эмчилж чадахгүй байна гэдэг чинь хүний эрхийг зөрчөөд байгаа юм биш биз. Тэгэхээр энэ бүлгийг та бүхэн оруулах тал дээр судалгаа хийж байв уу. Энэ илтгэлд яагаад орсонгүй вэ.

Г.Занданшатар: 3 номер Дугарын Сүнжид хариулна.

Д.Сүнжид: Чинбүрэн гишүүний асуултад хариулъя. Эхний хэлсэн саналыг хүлээж авлаа. Ер нь Эрдэнэхүү доктор бичсэн, бас ярьсан танилцуулга өгсөн байсан л даа. Яг Монголын онцлогтой харьцуулсан олон улсын судалгаа хийсэн юм гээд тэр тухай референтээ оруулах л зүгээр байна гэдэг саналыг нь хүлээж авлаа. Ер нь шинэ шинэ өвчнүүд үүсгэж болж байгаа нь үнэн.

Эмнэлгийн тусламж авах, эрүүл мэндийн үйлчилгээтэй холбоотой энэ жил бид нар яг эрүүл мэндийн салбарт бүтэн судалгаа хийе гээд гадаад, дотоод зөвлөхүүдийн тусламжтай удирдамжаа боловсруулж эхлээд байгаа юм. Тэгэхээр дараагийн илтгэлд бид нар тусгая гэдэг бодолтой. Эм, эмнэлгийн хэрэгсэл, хангалт тэгээд анхан шатын болон 1, 2, 3 дугаар зэрэглэлийн үйлчилгээнүүд, эмч, эмнэлгийн ажилтны хөдөлмөрлөх эрхийн нөхцөл байдал тэгээд устгал, түүнээс гадна энэ санхүүжилт, даатгалын тогтолцоо ер нь бүхэлд нь авч үзье гэдэг байдалтай удирдамжаа боловсруулж эхлээд байна.

Г.Занданшатар: Чинбүрэн гишүүн тодруулж асууна.

Ж.Чинбүрэн: Зүйтэй. Тэгэхээр энэ асуудлыг бүр тусгайлан бүлэг болгоод, удирдамжаа батлуулаад дараагийн юун дээр бол ялангуяа дараагийн сонгогдсон парламент энэ сэдвүүдээр нэлээн их ярьдаг байх хэрэгтэй л гэж бодож байна. Хэдийгээр өнгөрсөн 4 жилийн хугацаанд бид эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн тогтолцоог илүү гүйцэтгэлд хэнийг ч орхигдуулахгүй гэдэг энэ системд оруулахаар хичээж байгаа ч гэсэндээ энэ маань өөрөө ажиллахгүй байгаа процессын алдаанууд байж байна. Санхүүжилтийг далимдуулж гувчуулдаг ийн зүйлүүд байж байна. Дээрээс нь энэ хөнгөлөлттэй эмийг бид 100 тэрбум төгрөг нэмээд байхад л ард иргэд дээр сэтгэл хангамжийн байдал энэ тэр очихгүй байгаа зүйлүүд байгаа зэрэг дээр онцгой анхаараарай. Тэгэхлээр эрүүл мэндийн салбар гэдэг өөрөө том асуудал. Энд эрт илрүүлгийг бид хийж эхэлж чадлаа. Эмнэлгийн тусламжийн санхүүжилтийг өөрчилж чадлаа. Шатлалууд хоорондоо хүртэл уялдаатай байх асуудал хүртэл нэлээн дутагдалтай байгаа бидэнд ажиглагдаж байгаа зүйлүүд байна. Тэгэхлээр энэ болгон дээр анхаарч ажиллана.../минут дуусав/

Г.Занданшатар: Үг хэллээ. Одоо Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн. Алга байна. Хаслаа. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн.

Б.Бат-Эрдэнэ: Би 1, 2 зүйл асууя. Тэгэхээр Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар батлагдсан. Энэ хуулийн зорилт Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын үйл ажиллагааны зарчим, эрх зүйн үндсийг тодорхойлж, Монгол Улсад хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүний эрхийн боловсролыг олон нийтэд түгээх дэмжихтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино гээд ингэж тодорхойлсон байгаа юм. Тэгэхээр энэ хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх энэ ажил хэр хэмжээнд явагдаж байна гэдгийг л би тодорхой асуух гээд байгаа юм. Тэгээд цаг бага байгаа учраас олон том хүрээнд ярих тийм бололцоо байхгүй. Зөвхөн боловсролын салбарт гэхэд энэ биеийн тамир спортын, биеийн тамирын хичээлтэй холбогдуулаад л хэлэхэд энэ сургуулийн биеийн тамир спортын хичээл явуулах заал, танхимын стандарт шаардлага хангахгүй ийм байгаа юм. Жишээлэх юм бол. Хэрэглэл материал дутуу, агааржуулалт, гэрэлтүүлэг, заалны стандарт, шалны стандарт. Шал гэхэд жишээлэх юм бол стандартын бус байгаагаас шалтгаалуулаад судалгаагаар бол маш олон хүүхэд залуучууд эрт үе солих шаардлагатай болно. Нурууны, хөлийн үеүд. Тэгээд ийм асуудлууд байгаад байдаг. Тэгэхээр зэрэг цаашилах юм бол бид энэ хүний эрхийг хамгаалах Үндсэн хуулиар олгогдсон эрүүл аюулгүй орчинд амьдрах энэ эрхийг хангахтай холбоотой ажлыг та бүхэн маань хийхгүй бол хаанаас хэн өргөдөл өгөх нь вэ тэр хүрээнд нь асуудал ярина гээд суугаад байх юм бол энэ байдлаараа л явна л даа.

Тэгээд өмнөх энэ Хүний эрхийн Комиссын үйл ажиллагаа, ажил хариуцаж байсан хүмүүстэй ч бид нар

асуудал ярьдаг л байсан. Тэгэхээр энэ талаас нь хүүхэд залуучуудыг, хүүхдийн гэр бүлийн хүчирхийлэл эрх нь зөрчигдөж байгаа, хүүхдээ хүмүүжүүлэх, тэжээн тэтгэх, асран хамгаалах энэ үүргээ биелүүлэхгүй байгаа ийм хүмүүстэй ямар ажил зохион байгуулж байна. Энэ хуулийн чинь тодорхой та бүхэн иргэний нийгмийн байгууллагуудтай хамтарч ажиллах, бусад байгууллагуудтай хамтарч ажиллах, салбар дундын уялдааг хангах ийм бүрэн эрх чинь нээлттэй байгаа шүү дээ. Тэгээд миний үзэж байгаагаар бол та нөхдүүд ер нь тэгээд 1 оффист суугаад л нэг тиймэрхүү л байдалтай л байдаг хүмүүс байна л гэж л ойлгогдохоор. Ажил зохион байгуулж байгаа юм чинь нэг их харагдахгүй л байна л гэж би үзэх гээд байгаа юм л даа. Эрүүдэн шүүлт, хүний эрхийн олон зөрчлүүд байгаа. Тэр дээр та нөхдүүдийн дуу хоолой тод харагдахгүй. Ажил чинь бол ер нь харагдахаасаа харагдахгүй нь их байна л гэж би ингэж үздэг хүн. Энэ мэт зүйл дээр та бүхэн маань ажилдаа ямар өөрчлөлт гаргах юм бэ. Энэ талаар бодож төлөвлөж байгаа, хийж хэрэгжүүлж байгаа, үр дүнд хүрч байгаа тийм ажил байх юм уу, байхгүй юм уу. Ийм зүйлд нэг хариулт өгөөч.

Г.Занданшатар: 5 номер.
Мөнхзул.

Х.Мөнхзул: Хүний эрхийн Үндэсний Комиссын үндсэн чиг үүрэг бол хүний эрхийн боловсролыг түгээх энэ үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх ийм чиг үүрэгтэй байгаа. Тэгэхээр хүний эрхийн боловсролыг мэдээж шат шатад нь ерөнхий боловсролын сургууль гээд, их дээд сургууль гээд энэ хүрээнд олгох асуудлыг Боловсрол, шинжлэх ухааны яам хариуцаад ингээд хийж байгаа. Хүний эрхийн Үндэсний Комисс бол мэдээж олон нийт болон төрийн холбогдох хууль хяналтын байгууллагуудад чиглэсэн хүний эрхийн зөрчлөөс сэргийлэх, урьдчилан сэргийлэх энэ сургалт сурталчилгааны ажлуудыг бол чадлынхаа хүрээнд зохион байгуулж ажиллаж байгаа.

Тэгээд хүүхдийн асуудал, ялангуяа энэ гэр бүлийн хүчирхийллийн асуудал бол сүүлийн жилүүдэд тогтвортойгоор буурах энэ асуудал ерөөсөө байхгүй, улам нэмэгдэх ийм чиг хандлагатай байгаа. Энэ дээр бид нар илүү эрт шатанд нь урьдчилан сэргийлэх ажлууд бол маш чухал байгаа. Тэгэхээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зохицуулах зөвлөл бол хүүхдийн хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх энэ чиг үүргийг хэрэгжүүлдэг. Тэгээд бид нар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлтэй хамтарч ажиллаж, ер нь бол хууль сахиулах байгууллагын ялангуяа энэ чиглэлийн асуудлыг шалгах чиг үүрэгтэй хууль хяналтын байгууллагын ажилтнуудын хүний эрхийн боловсролыг дээшлүүлэх, мөн анхан шатан дээр ажиллаж байгаа нийгмийн ажилтан, анхан шатан дээр ажиллаж байгаа хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах чиглэлээр хамтран ажиллаж байгаа.

Л.Мөнхбаатар: Одоо Улсын Их Хурлын гишүүн Буланы Бейсен асуултаа асууя.

Б.Бейсен: Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Монгол дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын тухай санал, дүгнэлттэй танилцлаа. Энэ агаарын бохирдол түрүүнээс хойш ярьж байна. Энэ жил цас их орсон. Улаанбаатар хот ер нь тэр чигээрээ хиртэй хот болсон. Энэ юуг харуулж байна гэвэл агаарын бохирдлоо харуулж байгаа байхгүй юу. Энэ сайжруулсан түлш, түүхий нүүрс ярьж байна. Сайжруулсан түлшний найрлагад хүхэр, хүхрийн хүчлийн найрлага маш их байна гээд мэргэжилтэн үзэж байгаа. Энэ тэр түүхий нүүрсний ч хорттой гээд ярьж байгаа. Одоо алтны үйлдвэр дээр хэрэглэж байгаа хүхрийн хүчлийн газар булж байгаа биз дээ. Гэтэл энэ талаараа хийлгэсэн судалгаа байна уу. Ер нь энэ бүр

хортой юм шиг санагдаад байх юм. 1 дүгээрт.

2 дугаарт энэ боловсролын салбар дээр Монгол Улсад аж төрөн амьдарч байгаа Монгол Улсын иргэд казахууд байдаг. Тувачууд байна. Энэ хос хэлний сургалтын асуудал нөгөө талаар эх хэлээ сурч байж, дараагийн үндсэн хэлээ сурах ёстой. Гэтэл дөнгөж 1 дүгээр ангид орж байгаа хүүхдүүд 5, 6-тай Англи хэл, Монгол хэл, Казах хэл зэрэг ордог. Тэгээд юу ч үгүй болдог. Тэгээд боловсролын түвшин нь доошилж байгаа асуудал байна. Энэ талаар судалгаа хийсэн юм байна уу. Уг нь эх хэлээ сурч байж дараагийн хэлээ сурах ёстой. Үндсэн хэлээ, Монгол хэлээ сурах ёстой л доо. Бид нар ч тэгээд сурсан. Энэ талаар хийсэн судалгаа байна уу.

2 дугаарт энэ иргэдийн сонгох, сонгогдох эрх зөрчигдөж байна. Төрийн албанд ажиллаж байгаа төрийн удирдлага, аймаг, сумын удирдлагад ажиллаж байгаа аль ч нам гарсан ч гэсэн маш ихээр зөрчигдөж байгаа. Жишээлбэл нэг жишээ хэлье. Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын Засаг даргыг улс төржиж ажлаас халсан. 3 шатын шүүхийн шийдвэр гарсан. Дээд шүүхийн шийдвэр гарсан. Тэр 2 сар болж байна. Эргүүлэн томилохгүй байна.

Дээд шүүхийн шийдвэрээс гарсан эрх мэдэлтнүүд бий болчихсон байна. Хариуцлага тооцохгүй. Цаана нь төрийн ажил цалгардах, энэ жилийн зудаар ч гэсэн, энэ сонгуулийн үе эхэлж байна. Маш том кампанит ажил улсын хэмжээний. Гэтэл томилохгүй байгаа тийм албан тушаалтнууд дээр хариуцлага тооцохгүй бол Монгол Улсын Дээд шүүхээс дээгүүр гарсан албан тушаалтнууд байна шүү дээ. Камелат гэдэг хүн түрүүн би орой уулзаад хэлсэн. Засаг даргын орлогч Роман гэж хүн байна. Одоо энэ 7 хоногт томилно гэсэн. Гэтэл одоо хүртэл томилохгүй. Сонгосон иргэдийн эрх, ард иргэдийн эрх маш ихээр зөрчигдөж байна. Энэ тал дээр яахгүй

тодорхой шийдвэртэй санал, дүгнэлт оруулахгүй бол улсын хэмжээнд маш ихээр зөрчигдөж байгаа. Ард иргэдийн сонгосон дарга сонголоо гэдэг. Гэтэл цаанаа улсад хохирол учирдаг. Төлбөрийг нь тухай буруутай этгээд төлдөг. Төлдөггүй. Ийм асуудлууд дээр та бүгд судалгаа хийж үзсэн үү. Улсын хэмжээнд хэчнээн хүн тийм улс төрийн хэлмэгдэлтэд өртөж байгаа хүн байна уу ер нь. Одоо Баян-Өлгий аймгийн тэр Баяннуур сумын Засаг дарга мөн томилохгүй байгаа. Толбо сумын Засаг дарга 2 жил заргалдаж байж Дээд шүүхийн шийдвэрээр эргэн томилогдсон. Одоо ийм дураараа эрх мэдэлтнүүд дээр хариуцлага тооцох тал дээр та бүгд судалгаа хийсэн үү. Хариуцлага тооцсон юм байгаа юм болов уу. Та бүгд Монгол Улсын хэмжээнд хэчнээн хүн ингэж хэлмэгдэж, сонгогчдынхоо итгэлийг хүлээж чадахгүй ингээд байж байгаа юм болов уу гэдгийг асууя.

Л.Мөнхбаатар: Бейсен гишүүний асуултад хэн хариулах уу. Хүний эрхийн Комиссын дарга Сүнжид хариулъя. Ажлын хэсгийн 3 дугаар микрофоныг өгье.

Д.Сүнжид: Бейсен гишүүний 3 асуултад хариулъя. 1 дүгээрт нь агаарын бохирдол дээр 149 ийм агаарын чанарын үзүүлэлт хэмжэдэг станцууд байна л даа. 4 л үзүүлэлтийг хэмжиж байна. 2,5, 10 гээд бүдүүн, нарийн тоосонцор хэмжэдэг юм байна. Тэгээд энэ хүхрийн хүчил, азотын хийгээ хэмжэдэг юм байна. Тэгээд энэ үзүүлэлтийг харахаар өвлийн улиралд ерөөсөө 2-7 дахин энэ үзүүлэлт хэвийн байх ёстой. Дэлхийн эрүүл мэндийн болоод үндэстний үзүүлэлтээс давдаг л гэдэг стандарттай. Тэгээд тийм болохоор энэ юуг сайжруулсан түлшийг хэрэглээд энэ нь өмнө байсан түүхий нүүрснээсээ буусан байна. Гэхдээ 2-7 дахин их хэвээрээ л байгаа. Өөрөөр хэлэх юм бол нөгөө байх ёстой стандартдаа хүрээгүй хэвээрээ байгаа гэдгийг нь хэлдэг. Тэгээд үүнээс цаашаагаа бид хэд

энэ эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийн хүрээнд яг энэ лабораторийн шинжээч нартай уулзаж ярилцлага хэлэлцүүлэг хийж үзсэн. Тэр шинжээч нарын хэлж байгаагаар бол зөвхөн энэ 4 үзүүлэлт хангалтгүй юм. Үүнээс цаашаа олон үзүүлэлтээр бид нар энийг хэмжих боломжтой л гэж байгаа юм. Тэгээд тэр хэмжсэнээрээ яах юм гэхээр хамгийн гол нь ямар бодисын улмаас, үзүүлэлтийн улмаас ямар үр дүн үүсдэг вэ ч гэдэг юм уу тэрийг нь л хэмжих боломжтой. Тэгэхдээ 1 зүйл бол бид нар энийг бууруулах л ёстой. Тэгээд тэр арга хэмжээг бол хэрэгжүүлэх ёстой л гэдэг ийм л дүгнэлт хийж байгаа юм л даа.

2 дахь асуулт Боловсролын хүртээмжийн тухайд. Нөгөө бид нар яг энэ боловсролын салбар дахь хүний эрхийн асуудлыг авч үзэхдээ хүрэлцээтэй байх, хүртээмжтэй байх, хүлээн зөвшөөрөгдсөн байх, нийцэн зохицсон байх гээд энэ эдийн засаг, нийгэм, соёлын Байнгын хорооноос өгдөг зөвлөмжийн дагуу 4 шалгуураар нь үнэлсэн. Тэгээд 1 асуулт нь энэ хүртээмжтэй байдал дээр хэд хэдэн бүлэг орхигдож байна. Анхаарах ёстой гээд. Тэрний 1 нь энэ хос хэлний боловсрол гэдгийг анхаарах ёстой. Сурах бичиг, хөтөлбөр, төсвийн асуудлыг нь шийдэх ёстой юм байна лээ. Багшийнх нь асуудлыг шийдэх ёстой юм байна лээ гэдгийг нь оруулж тусгасан. Тэгээд өөр бас нэг алслагдмал газар нутгийнхаа алслагдмал байдалаас шалтгаалаад орхигддог хүүхдүүд байдаг юм байна. Амьжиргааны түвшнээс хамаарч байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн суралцах эрх энэ дээр хөндөгдөж байгаа юм. Тэгэхээр энэ нэг анхаарах ёстой, зайлшгүй зорилготойгоор дэмжих арга хэмжээ хэрэгжүүлэх ёстой гэдэг бүлгүүдийг энэ 2 дугаар бүлэгтээ дурдаж дүн шинжилгээ хийж саналаа тусгасан.

3 дахь асуултын тухайд энэ манай яг Хүний эрхийн Үндэсний Комисс шууд гэхээсээ илүү Төрийн албаны зөвлөл хяналт хийж хэрэгжүүлдэг л дээ. Одоо

шүүхийн шийдвэр гарчихсан. Хэрэгжүүлэх ёстой. Тэрийг бид нар бүх албан хаагчид мэддэг. Шүүхийн шийдвэр гарсан бол хэрэгжих учиртай. Тэгэхдээ ингээд биелэлтийнх нь нийт статистикийг харахаар тийм биш л байна л даа. Ялангуяа Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр дээр 60 хувь хүрвэл ийм л статистик явдаг юм л даа. Тэгэхээр шүүхийн шийдвэрийг биелэх талаар ер нь тогтолцооны хувьд арга хэмжээ авах ёстой. Төрийн албаны зөвлөлөөс ялангуяа энэ дээр шууд хариуцдаг чиг үүргийнхээ хүрээнд бол хяналт тавьж ажиллана.

Л.Мөнхбаатар: Тодруулах уу. Бейсен гишүүн тодруулж асууя.

Б.Бейсен: Энэ саяын албан тушаалтнуудын хэлмэгдэлттэй холбоотой түүний ар гэр нь бас сэтгэл санааны хохирол үзэж байгаа. Хотод ч, хөдөөд ч гэсэн. Тэгээд сонгуулиар ч юм уу, намын чиглэлээр ямар нэгэн том албан тушаалд оччихоод хэлмэгдэлт явуулдаг, төрийн ажлыг цалгардуулдаг ийм хүмүүс дээр Төрийн албаны зөвлөлтэй та бүгд хамтарч ажиллаж байгаа юу. Уг нь хэчнээн хүн хэлмэгдэж байгаа бол. Хэлмэгдэлт маш их байгаа. Ер нь бодит байдал дээр ийм байгаа шүү дээ. Цаашилаад төрийн алба цалгарддаг. Одоо өвлийн зудын үер ч ингээд даргагүй байлаа шүү дээ. Тэр Баяннуур сум, Цэнгэл сум. Одоо хаврын сонгуулийн үеэр бас л томилохгүй гээд төр, шүүхээс давсан эрх мэдэлтэй ийм хүмүүс дээр хариуцлага тооцох танайх тийм механизм бий юу. Ер нь төрийн албатай хамтарч байгаа юу.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн 3 дугаар микрофоныг өгье. Сүнжид дарга хариулъя.

Д.Сүнжид: Бейсен гишүүний тодруулгад хариулъя. Төрийн албаны зөвлөлтэй 3 сарын 16-нд ажил хэргийн уулзалт хийсэн. 2, 3 чиглэлээр хамтарч ажиллахаар ярилцсан. Тэгээд дараагийнхаа уулзалт ялангуяа нөгөө

сонгууль болохтой холбоотойгоор төрийн албан хаагчдын тогтвортой, мэргэшсэн байх зарчмыг хангах, тэгээд сонгуулийн үр дүнгээс үл хамаараад энэ хүмүүсийн мэргэшсэн ийм ажлын байрандаа тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх талаар харилцан ажиллахаар ярилцаад төлөвлөөд явж байгаа.

Л.Мөнхбаатар: Хариулт хангалттай юу. Одоо Улсын Их Хурлын гишүүн Дашдондогийн Ганбат асуултаа асууя.

Д.Ганбат: Ундрэм гишүүн байна л даа. Би соёлтой хүн болохоор.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Ундрэм асуултаа асууя. Дараа нь Ганбат гишүүн асууна.

Ч.Ундрэм: Энэ Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дугаар илтгэлтэй танилцаж байна. Тэгээд энэ илтгэлийн яг гол зорилго нь юу юм бэ. Тэндээс л бидний асуулт хариулт эхлэх ёстой. Тэгээд миний ойлгож байгаагаар энэ илтгэл бидний хийсэн ажлын дүн. Одоо энэ төр ажиллаад өнөөдөр ийм л нөхцөл байдалтай байна. Тэгээд цаашид юу хийх ёстой юм бэ гэдгийг бидэнд хэлж өгч байгаа гэж би ойлгоод байгаа байхгүй юу. Тэрнээс энэ Хүний эрхийн Комисс л бидний өмнөөс очоод л бүх юмыг нь засаж янзлаад л, хууль дүрэм батлаад л, хэрэгжилтийг нь хангуулаад ингэдэг газар биш. Тэгэхээр энийгээ бид нар ойлгож байж нэг асуулт, хариултаа ядаж явуулах ёстой юм болов уу гэж бодож байгаа юм.

Энэ эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх үнэхээр зөрчигдөж байгаа. Тэгээд энэ тайлантай танилцахаар бүүр үнэхээр сэтгэл эмтэрч байна. 0-5 насны хүүхдийн эндэгдлийн 45 хувь нь дотоод орчны агаарын чанарын бохирдлоос шалтгаалдаг ийм ноцтой асуудал байна гээд. Жишээлбэл энэ өгүүлбэр үнэхээр өр эмтэлж байгаа юм.

Тэгээд энэ дотоод орчны агаарын чанарын асуудлаар 2022 онд би сонсгол зохион байгуулсан л даа. Тэгээд сонсгол зохион байгуулаад ямар үр дүнд хүрчихсэн байгаа вэ гэхээр Алтанбулаг Замын-Үүд дээр барилгын материалын лаборатори байгуулчихсан байна. Доторх тоног төхөөрөмжийн худалдан авалт нь тодорхой шалтгаанаар жоохон хойшлоод 6 сар гэхэд бэлэн болно гээд хэлж байна. Барилгын яам шинэ байшин барилгыг хүлээж авахдаа дотоод орчны тэр агаарын чанарыг нь хэмжээд тэгээд улсын комисс гарын үсэг зурж хүлээж авдаг болсон байна. 3 яамны Эрүүл мэнд, Боловсрол, Барилгын яамны сайд нарын баталсан журам батлуулсан. Шинээр сургууль, цэцэрлэг, эмнэлгийг засах гэж байгаа бол, будах гэж байгаа бол ямар төрлийн будаг, эмульс ашиглаж болох юм, болохгүй юм гээд тийм ээ. энэ барилгын стандартыг шинэчлэх гээд шинээр стандарт боловсруулаад Стандартчилал хэмжил зүйн үндэсний төв дээр авааччихсан. Тэр стандартыг маань хав дарчхаад нэг мэргэжилтэн баталж өгөхгүй байна аа. Энэ барилгын материалаас чинь болж өчнөөн хүн нас барж байна шүү дээ. Хорт хавдар тусаж байна, хорт хавдар залуужиж байна. Гэтэл энэ барилгын материалын худалдаалагчдын лоббинд автчихдаг юм уу яадаг юм, тэнд ингээд стандартыг нь баталж шинэчилж өгөхгүй, хав дарчхаад сууж байгаа. Тэр хав дарж суугаад энийг батлахад саад болж байгаа хүн та бол ёстой энэ онголын ирээдүйд гай болж байгаа хүн шүү. Эргээд карма гэж байдаг бол өөр дээр чинь ирнэ шүү гэдгийг би бүр албан ёсоор хэлчихмээр байгаа юм.

Цаашилаад энэ хүүхдийн хэрэглэж байгаа тоглоом сүүлийн үед бүр пластикаар хийдэг хувцаснууд хүртэл гарчихсан байна. Хүний биед хорттой формальдегид, формалин тийм ээ, бензол, тилол гээд аймшигтай ийм химийн бодисууд нь зөвшөөрөгдөх хэмжээнээс хэдэн мянга дахин их болчихсон. Энэ

зүйлүүдийг оруулж ирмээргүй байна, Монголд. Гаднаас тийм хор авчраад хүүхдийнхээ аманд хийгээд ингээд баймааргүй байна. Энэ дээр та хэд маань нарийн судалгаа хийж өгөөч. Тэгээд бүр надад явуулж өгөөч, хэрвээ боломж байвал шүү дээ тийм ээ.

Тэгээд би чинь сүүлдээ бүр ингээд савны үйлдвэр байгууллаа шүү дээ. Малчдын сүү сааль, усаа хийдэг сав нь хүртэл дотроо формалин гээд цэв цэвэрхэн ус хийхэд минутаар бактери үрждэг тийм савыг нь устгая гээд. Энийг энэ оруулж ирж байгаа уул уурхайн, химийн компаниуд нь буцаж өөрсдөө аваад, дахиж хэрэглэдэг болмоор байна. Эсвэл тэрийгээ устгадаг. Зүгээр нэг очоод зах дээр 10, 20 мянгаар малчдад зараад байдгаа болимоор байна. Тэрнээс болоод нөгөө малчид нь өвдөөд байдаг. Тэгээд л өвдлөө, хавдлаа гээд л нөгөө эрүүл мэндийн салбарын төсөв нь нэмэгдээд байдаг. Энэ асуудал.

Дараагийн нэг чухал асуудал нь энэ цахим орчин хөгжсөнтэй холбоотойгоор би дахиад 1 минут авчихъя, тэгэх үү, дарга аа.

Л.Мөнхбаатар: Хариулья. Хариулаад тайлбар хангалтгүй гэж үзвэл дахиад минут өгнө. Сүнжид дарга хариулья.

Д.Сүнжид: Ундрaм гишүүний асуултад хариулья. Дотоод орчны агаарын чанар үнэхээр санаа зовоосон асуудал мөн юм байна лээ. Тантай үнэхээр санал нийлж байна. Тэр гарч байгаа үр дагавар ялангуяа хүүхдүүдэд эрүүл мэнд нь хохироож байгаа байдал үнэхээр бид нар, хариуцсан байгууллагууд, төрийн байгууллагууд анхаарал тавихаас өөр аргагүй түвшинд хүрсэн. Тийм болохоор хэд хэдэн асуудал ялангуяа дотоод орчны агаарын чанар дээр дотоод орчны нөгөө магадлан итгэмжилсэн ганц л лаборатори байгаа юм байна л даа. Тэгээд

тэр лабораторийн үр дүн нээлттэй биш юм байна лээ.

Тэгэхээр бид нар 1 дүгээрт, нөгөө барилгын тэр материал үнэхээр чухал юм байна. 2-т нь, тэр засвар хийх асуудал чухал юм байна. 3-д нь, энэ нэг агааржуулалтын системийн асуудал чухал юм байна. 4-д нь, тэрийгээ хянадаг байх ёстой юм байна гэдэг үүднээс бид нар таны яг энэ саяын хэлсэн агуулгаар саналаа боловсруулж, дүн шинжилгээ хийсэн байгаа.

Л.Мөнхбаатар: Чинбатын Ундрaм гишүүн тодруулж асууя.

Ч.Ундрaм: Энэ илтгэлд цаашид энэ цахим ертөнц хөгжиж байгаатай холбоотойгоор цахим орчин дахь хүний эрхийн асуудлыг бид нар судлах ёстой гэж үзэж байгаа. ингээд жишээлбэл хүүхэдтэй холбоотой нэг гэмт хэрэг гарлаа гэхэд нөгөө хүүхэд нь хаана амьдардгийг нь зарлаад л, хэн гэдгийг нь бараг зарлаад л, тэгээд л хандалт авах гэдэг юм уу яадаг юм, улс төр хийгээд л тэгээд нөгөөдхөө өөр улс төрчидтэй, эмэгтэйчүүдтэй холбоод л ингээд л энийг болимоор байна. Энэ арай дэндэж байна.

Тэгээд л улс төрийн зорилгоор хүний насанд хүрээгүй хүүхдийг хүртэл бичлэгийг нь энд тэнд хийж цацаад л. Улс төр хийх гэж байгаабол тэр хүнтэй нь л, хүнийг нь л шүүмжилдэг юм байгаа биз тийм ээ. Тэгэхээр энэ цахим орчин дахь хүүхдийн асуудал, 1 нэгнийгээ дураараа бүүлийддэг болж байна. Худлаа гүтгээд л, тэгээд л араас нь нийгмээрээ нөгөөдхөө бүү шүүгээд л, цовдлоод л бараг. Тэгээд бүр сэтгэл санааны маш их хэмжээний хохиролд ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн 2 дугаар микрофоныг өгье.

Г.Нарантуяа: Цахим орчин хүн төрөлхтний амьдралыг бол үндсээр нь өөрчилж байна аа. Тэгэхээр Хүний эрхийн

Үндэсний Комиссоос энэ жил бүтэн жил бол технологи ба хүний эрх олон нийтийн хяналт шалгалтыг зохион байгуулж байгаа. Энэ сэдвийн хүрээнд 11 бүлэг асуудал дотроо 48 тусгай асуудлыг хамарсан. Монгол Улсын цахим хөгжлийн бодлого хүний эрхийн зарчимд нийцсэн байна уу, хүнд ээлтэй байна уу? И-монголиа системийн ажилчин хүний хувийн мэдээллийг хамгаалж, хүний эрхэд энэ зарчимд нийцэж ажиллаж байгаа нөхцөл байдал юу байна. Хууль сахиулах ажиллагаанд технологи ашиглаж байгаа байдал, нийгмийн сүлжээний зохицуулалт Монгол Улсад ямар байх юм, хиймэл оюун ухааны бодлого зохицуулалт ямар байх юм гээд энэ олон тулгамдсан асуудлууд дээр Хүний эрхийн Үндэсний Комисс төрийн бодлогыг тодорхойлоход хүний эрхийн талаас нь зөвлөх үүднээс бол энэ ажлыг эхлүүлээд явж байгаа.

Тэгэхээр ирэх жилийн хүний эрх, эрх чөлөөний төлөв байдлын илтгэлд бол технологи ба хүний эрх олон нийтийн хяналт шалгалтын үр дүн, комиссын тодорхой саналууд, зөвлөмж, ялангуяа Монгол Улсад ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Нэмж хариулах юм уу? Гүйцээгээд хариулчих. Нарантуяа.

Г.Нарантуяа: Энэ талаарх санал зөвлөмжүүдийг маш тодорхой оруулах болно. Тэгэхээр цахим орчинд үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчилтэй холбоотой асуудал энэ өөрөө Монгол Улсын өнөөгийн нөгөө уламжлалт гэмт хэрэг зөрчилтэй тэмцэх тогтолцоо маань цахим орчинд яаж үр дүнтэй ажиллах юм бэ гэдэг дээр бол бидэнд тодорхой эрх зүйн зохицуулалт бодлого шаардлагатай байгаа.

Цахим орчинд үйлдэгддэг гэмт хэрэг 3 үндсэн асуудлаар бол ердийн гэмт хэргээс ялгаатай байгаа. Эхнийх нь орон зай үл хамаарч байгаа, хаанаас ч энэ гэмт хэргийг үйлдэж болдог.

2 дугаарт нь, үйлдсэн этгээдийг нь тогтоох боломж бололцоо хязгаарлагдмал,

3 дугаарт нь, мэдээлэл маш хурдан тархдаг, мэдээллийг устгах боломж багатай байдаг. Тэгэхээр бид бол энэ дээр ямар, одоогийн эрүү зөрчлийн хэргийг илрүүлж байгаа, шалгаж байгаа, тогтоож байгаа, шийдвэр гаргаж байгаа энэ тогтолцоо маань яаж цаашидаа хөгжих юм бэ гэдэг дээр бол бид бас ирэх жилийн хүний эрх чөлөөний төлөв байдлын илтгэлд нэлээн олон асуудлыг хамарсан ийм санал зөвлөмжийг оруулна гэсэн төлөвлөгөөтэй ажиллаж байна аа.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Дашидондогийн Ганбат асуултаа асууя.

Мөнхцэцэг гишүүн дараа нь танай тогтоолыг явуулчихъя гэж байгаа юм.

Д.Ганбат: Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны талаарх тайланг нь хэлэлцэж л байна л даа, бид нар. Ингээд 23 дахь илтгэлийг хэлэлцэж байгаа юм байна.

Нөгөө талаар ингээд хараад байхад бид нар ингээд бүх байгууллагууд нь байна. Хүний эрхийн Үндэсний Комисс нь ч байх юм, ЗГ нь ч байх юм. Тэр төрийн албан хаагчид нь ч байх юм, УИХ нь ч гэсэн өнөөдөр ингээд хэлэлцээд байж байна. Тэгээд энэ бүх юм үр дүн нь ямар байна вэ? Эцсийн эцэст энэ чинь нэг дүр эсгэсэн л юм болчихоод байна л даа. Хэрвээ ингээд дүр эсгэсэн, үр дүнгүй ийм зүйл бол нөгөө байхгүй байгаагаасаа бүр долоон дор байхгүй юу. Байхгүй байвал хүмүүс өөрөө өөртөө найдна. Энэ татвар төлөгчдийн мөнгөөр цалинжсан, ардчиллын бүх элементүүд нь байгаа юм шиг болохоор хүмүүс хараад байдаг. Сүүлдээ ингээд дээшээ тэнгэр хол,

доошоо газар хатуу энэ ард түмэн маань цөхөрч байна л даа.

Энэ эрүүл аюулгүй орчинд амьдрах хэрэгтэй гээд Үндсэн хуульд заачихсан байгаа л даа. Тэгээд сүүлийн 1, 2 сард л гэхэд 10 хүн хордож нас барлаа гэж дуулдаж байна. 5 хүн хордоод 1 нь нас барчхав уу, хэдэн ч хүн нас барчхав. Өчигдөр, уржигдархан тэгээд ээж, хүүхэд 2-ын ээж нь эмнэлэгт хэвтээд, хүүхэд нь нас барчихлаа л гэж байна. Үгүй энэ үхлийн хөндий дотор чинь Улаанбаатарын энэ хөндийг би хэлээд байна л даа. Ийм олон хүмүүс ингээд нас барж байна аа. Та бүхэн ингээд очсон уу, энэ газар дээр нь ажилласан уу? Хэрвээ энэ байдлыг мэдээлсэн хэвлэл мэдээллийн байгууллагууд буруутай юм шиг болж эхэлж байна шүү дээ. Сүүл рүүгээ. Хэвлэл мэдээллийн байгууллага өөрт олдсон мэдээллээ цацах эрхтэй. бараг амыг нь барих гэж байна шүү дээ. Та нар. Эсвэл шоронд ор, эсвэл дуугүй бай. Үгүй энэ чинь тэр хүмүүс чинь байгаа мэдээллийг эх сурвалжаа нуух ч эрхтэй, өөрөө цацах ч хэрэгтэй. Яагаад гэвэл энэ нэг ямар нэгэн амлалт үүрэг хүлээсэн ийм хүмүүс биш.

Сая энэ Улсын Их Хурлын танхимд ингээд ярьж байгаа нь хүн болгон үүрэгтэй юм шиг яриад байгаа байхгүй юу. Үгүй шүү дээ. Албан тушаалтнууд л үүрэгтэй болохоос биш тэр хэвлэл мэдээллийн байгууллага, ард түмэн ийм үүрэг байхгүй ээ. Хүүхдэд маш их ээлгүй байна аа. Нөгөө хамгаалах ёстой цагдаагийн байгууллагын 4 албан хаагч нь 12 настай хүүхдийг жилийн турш хүчиндэжээ. Тэгээд хэвлэл мэдээллийн байгууллагууд тэрийг нь гаргаад тавихаар, эргүүлээд тэр хэвлэл мэдээллийн байгууллага руугаа дайрч байгаа юм. Арга ядаад сүүлийн үед хүний эрхийн мэдрэмжтэй, ардчилсан үзэл бодолтой, өр нимгэн сэтгэлтэй ийм хүмүүс хандивын аян өрнүүлбэ ээ. Хэн ч хариуцлага хүлээхгүй, улс төрийн, ёс зүйн ийм хариуцлага хүлээхгүй болохоор сөхөрч байна шүү дээ. Хандив цуглуулаад өгье өө.

Энэ дээр нөхөн төлбөр гэж байдаг юм уу? Бүх хохирлууд ингээд бий болчихлоо. Энэ хүүхдүүд чинь цаашидаа хаана яаж амьдрах юм бэ? Өмнө нь яасан, 13 настай хүүхэд хүчирхийлүүлээд ингээд амь нас нь хохироод ингээд байхгүй болсон. Эргээд дуусаагүй байхад энэ явдал гарч байна. Үүний ул мөрөөр улс төрийн ёс зүйн хариуцлага хүлээдэг хүн байна уу? Хэн ч байхгүй. Ахиад л ийм гэмт хэрэг үргэлжлээд л гарах нь ойлгомжтой. Яагаад гэхээр энийг бүгдийг нь хааж боож байгаа байхгүй юу. Хэрэв хэн нэг нь хариуцлага хүлээдэг байсан бол ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Ганбат гишүүний асуултад хариулъя. Ажлын хэсгийн 2 дугаар микрофоныг өгье. Комиссын гишүүн Нарантуяа хариулъя.

Г.Нарантуяа: Хүний эрх чөлөөний төлөв байдлын илтгэлийн 7 дугаар бүлэгт бид хөгжлийн бэрхшээлтэй хүний улс төрийн оролцооны асуудлыг яг тухайлсан сэдвийн хүрээнд оруулаагүй юм аа. Энэ болбол хүний эрхийн зарчмын тунхаглал, бодит байдлын зөрөө 2 ямар ялгаатай болоод байгаа юм бэ? Энэ ялгаа юунаас болоод байна вэ гэдгийг том зургаар нь бодлогын санамж өгөх гэж оруулсан юм аа. Дүгнэлтийн хамгийн сүүлийн өгүүлбэрийг би уншиж өгмөөр байна.

Нийгмийн тулгамдсан асуудлыг ихэнх тохиолдолд хууль тогтоомж, бодлогыг өөрчилж, асуудал эрхэлсэн байгууллага үүссэнээр бодитой шийдэгдэхгүй. Харин тухайн асуудалд нөлөөлж буй хувь хүний нийгэм, соёлын эдийн засаг, улс төр, эрх зүйн суурь хүчин зүйлийг тодорхойлж авах арга хэмжээний эрэмбийг тогтоох илүү үр дүнтэй байж болохыг энэ бүлгийн дүн шинжилгээ сануулж байна гэж бид илтгэлдээ тухайлан бичсэн юм аа.

Өнөөдөр Монгол Улсад тулгамдаж байгаа хүний эрхийн зөрчлийн хамгийн гол асуудал бол эдийн засаг,

боловсрол, эрүүл мэндийн нөхцөл байдалд байгаад байна аа. Бид энэ суурь асуудлыг шийдэхгүйгээр, дуу нэгтэйгээр энэ бүлгийн энэ илтгэлд оруулсан 4 бүлэг хүүхдийн эрх хамгааллын асуудал, гэр бүлийн хүчирхийлэл, жендөлд суурилсан хүчирхийлэлтэй холбоотой асуудал, хорихоос суллагдсан хүмүүсийн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалтай холбоотой асуудал. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн улс төрийн оролцоотой холбоотой асуудлууд бол суурь асуудлаа эхлээд тодорхойлж, хүчин зүйлсийг нь ойлгоё, тэгээд шийдэж чадах зайлшгүй шийдэх ёстой энэ бодлогын дэс дараалалыг тогтооё, түүнээс хууль батлаад, байгууллага байгуулаад бол бид нар энэ асуудлыг амжилттай шийдэж чадахгүй юм байна шүү гэдэг бодлогын саналыг бид өгөх гэж бичсэн юм аа.

Л.Мөнхбаатар: Нэмж хариулна. Хэн Энхболд хариулах юм уу? Ажлын хэсгийн 6 дугаар микрофоныг өгье. Ажлын хэсгийн 6 дугаар микрофоныг өгөөрэй. Нээгдсэн байна.

Б.Энхболд: Ганбат гишүүний асуултад хариулъя. Сүүлийн үед Улаанбаатар хотын аюулгүй орчинтой холбоотой асуудлууд анхаарал татаж байгаа. Ялангуяа энэ гал түймэр, гэнэтийн ослын улмаас төрийн албан хаагчид амь насаа алдах, иргэд эрүүл мэндээрээ хохирох энэ тохиолдлууд гарч байгаа. Энд Хүний эрхийн Үндэсний Комиссоос шуурхай хариу арга хэмжээнүүдийг авч, холбогдох байгууллагуудтай мэдээлэл солилцож ажиллаж байна.

Онцгой байдлын байгууллага руу тодорхой хяналт шалгалтыг Хүний эрхийн Үндэсний Комиссын ажлын хэсэг орсон байгаа. Удахгүй дүнг бол танилцуулж тодорхой арга хэмжээнүүдийг авна аа. Энэ дээр ямар асуудал байсан бэ гэдгийг эргээж тайлагнана.

2 дугаарт нь, цагдаагийн албан хаагчдаас үйлдсэн гэмт хэргийн асуудлыг харьяалал тогтоогоод шалгаж байгаа талаар мэдээллийг бид нар УЕП-той санал солилцоод явж байгаа. Энэ хуулийн дагуу шалгагдаад хариуцлагаа хүлээх ийм нөхцөл байдалтай явагдаж байгаа. Шалгалтын ажиллагаа бол одоогоор дуусаагүй байна гэсэн ийм асуудал байгаа.

Дараагийн асуудал бол яах аргагүй гэмт хэргийн улмаас хохирчихсон хүн төлбөрөө олж авч чадахгүй байгаа нөхцөл байдал үнэхээр яг тулгамдаж байгаа. Энийг бид нар нэн тэргүүнд шийдэх ёстой. Өнгөрсөн жил Хүний эрхийн Үндэсний Комиссын илтгэлд бүх насаар хорих ял шийтгүүлсэн хүнийг ажил хөдөлмөр эрхлэх, хохирлоо нөхөн төлүүлэх энэ боломжийг бол суулгах ёстой гэдэг саналыг өгөөд, үүний дагуу бол хуулийн төсөл боловсруулагдаж байгаа боловч одоогоор бол яг бодитой арга хэмжээ авагдаагүй байна. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасны дагуу энэ гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох асуудал бол туйлын хангалтгүй байгааг Хүний эрхийн Үндэсний Комисс анхааралдаа авч байгаа. Үүнийг удахгүй илтгэлээрээ ямар арга хэмжээний хүрээнд энэ хохирлыг барагдуулах асуудлыг шийдэх вэ гэдэг санал танилцуулна.

Шүүхийн шийдвэр гардаг. Хохирлыг барагдуулах шийдвэр албан ёсоор гардаг. Энэ нь хэрэгждэггүй байгаа байдлыг бид засах ёстой. Энийг төр хариуцлага хүлээх ёстой гэсэн ийм байр суурьтай байгаа.

Л.Мөнхбаатар: Ганбат гишүүн тодруулж асууя.

Д.Ганбат: Улаанбаатарынхан маань, ер нь Монголчууд маань бүгдээрээ л эрүүдэн шүүлгэж байна л даа. Түрүүчээсээ эхлээд хүүхдүүдийн цусанд нь хар тугалга илрээд эхэлчихсэн. Тэгээд олон хавдар энэ нөхцөл байдалтай

уялдаад бий болж байна. Тэгээд иргэд маань 300, 400 мянгаараа дайжаад гарчихлаа, залуучууд. Тэр санал асуулгаар 70 хувь нь дайжаад гарахад бэлэн гэж байна. Энэ бүхэн юутай холбоотой байна вэ? Миний хэлээд яриад байгаа юмтай та бүхэн санал нэг байна уу? Энэ ямар нэгэн байдлаар зогсоох боломж бий юү.

Ардчилсан улс оронд төр засаг нь, албан тушаалтнууд нь хариуцлага хүлээгээд л огцордог шүү дээ. Ийм үзэгдэл байна уу, байхгүй юу. Тэгээд бүр цөхөрч байна л даа. Тэгээд тийм учраас эх орноосоо зугтаж байна. Виз нь гардаг бол бүгдээрээ явъя гэж бодож байна.

Л.Мөнхбаатар: Хэн хариулах вэ? Ерөнхий л асуулт юм байна. Хүний эрхийн Комиссын дарга Сүнжид хариулъя.

Д.Сүнжид: Ганбат гишүүний сүүлийн тодруулгад хариулъя. Амьдралын чанар л сайжрах ёстой юм байна лээ л дээ. Таны хэлж байгаа хүүхдүүдийн асуудал санаа зовж байгаа үнэн. Тийм ч учраас энэ Хүний эрхийн Үндэсний Комисс жил бүрийн илтгэлдээ хүүхдийн тодорхой зорилттой эрх, дэд сэдвийг юм уу сонгож авч заавал илтгэлдээ оруулдаг. Яагаад гэвэл эндээс авч байгаа арга хэмжээ, үр дүн тийм хангалттай байж чадахгүй байна. Бид нар үнэхээр хүүхдүүдээ бүрэн дүүрэн хамгаалчихсан гэж хэлж чадахгүй байна. Орхигдчихсон хүүхдүүд байгаад байна.

Тийм учраас энэ дээр хүүхдийн эрхийн асуудлыг бид нар ямар чиглэлээр арга хэмжээг авах нь зохистой вэ гэдэг саналыг жил болгон л комиссоос илтгэлдээ оруулаад үүний мөрөөр бас тодорхой арга хэмжээ авахыг хичээж байгаа юм.

2 дахь асуудал. Ер нь, ерөөсөө амьдралын үндсэн асуудал эдийн засаг, нийгэм соёлын эрхтэй л холбоотой юм байна. Өөрөөр хэлэх юм бол тэр амьдралын чанарын асуудал хангалттай

байх юм бол авлигагүй, тэгээд ажилгүйдэл бага, ядууралгүй ийм нөхцөл хөгжих ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Ганбат гишүүн тодруулж асууя. Сүүлийн тодруулга байгаа.

Д.Ганбат: Бид нар ч тэгээд хангалтгүй л байна л даа. Хариулж байгаа нь ч гэсэн. Тэгээд бараг л нэг хүний эрхийн хойч, хүний ажил явдал дээр л байж байгаа юм шиг л бид нар ингээд сууж байна л даа. Оршуулга дээрээ байгаа юм шиг.

Боловсролын хувьд хүнд байгаа. Хөдөө орон нутагт 5, 6 жилээр хоцорчихсон. Дэлхий нийтийн үе тэнгийнхнээсээ. Улаанбаатар хотод 3, 4 жилээр хоцорчихсон ийм байдалтай байгаа гэдгийг анхаарах хэрэгтэй. Энэ талаар татвар төлөгчид, уул уурхайгаас орж байгаа баялаг ингээд байдаг. Тэр нь баахан авлигачдын карманд ороод л ингээд л явчихсан. энэ улс төрийн сонгууль гэдэг зүйл тоо нь олишрчихсон. Бүгд л улс төрийн хамгаалалтад орох гэсэн ийм хүмүүсийн л тоглоом болж эхэлж байх шиг байна. Ингээд харж байхад. Тэгээд итгэл найдвар ер нь байна уу, байхгүй юу? Энэ Монгол Улсад. Цаашидаа дарангуйлал руу явахад ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Үг хэллээ.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын дэд дарга Салдангийн Одонтуяа асуултаа асууя.

С.Одонтуяа: Өнгөрсөн 2 жил Хүний эрхийн Үндэсний Комиссынхыг хүмүүс нь шинэ томилогдсон гээд бас хатуу үг хэлж байгаагүй, үргэлж л дэмжиж ирсэн. Сүүлийн үед сая Ганбат гишүүний хэлдгээр үнэхээр нэг дүр эсгэсэн юм руу л яваад орчихлоо. Яг сая хэлж байна шүү дээ, нэг ийм ямар ч асуудал шийдэгдэхгүй, тэгээд 1 оршуулга дээр

байгаа юм шиг гэж. Би энэтэй санал нийлж байна.

Та нарыг Хүний эрхийн Үндэсний Комиссынхыг ард түмнийхээ талд зогсооч ээ, хүний эрхийн манаач байгаач ээ, энэ эрх нь зөрчихсөн асуудал дээр зоригтой шүгэл үлээгээч ээ гэж та нарыг томилсон шүү дээ. Тэрнээс биш би та нарын энэ тайланг харлаа. Тал нь ерөөсөө 80 хувь нь зүгээр л нэг судлаачийн л нэг зовлон тоочсон л юм байна. Тэдэн хувь нь ингээж байна, агаарын бохирдол тэдэн хувьд хүрлээ, ийм ийм. Үгүй энийг чинь та нартай та наргүй ард түмэн нийтээрээ мэдэж л байгаа шүү дээ. Бүх хүн хордоод, өдөр шөнөгүй хүмүүс нь угаартаад байна. Хүүхдийн эрх зөрчигдөөд байна, хүний эрх зөрчигдөөд байна гэдэг чинь та нартай та наргүй бид нар бүгдээрээ мэдэж байгаа. Энэ дотор чинь яг та нарын ингээж тэмцсэн, бид нар энэ дээр ингээж хүчин мөхөстсөн, ийм ажлыг хийх гэсэн чинь ийм бэрхшээл тулгарлаа гэж ярихгүй л байна шүү дээ. Энэ тэнд тайланд чинь алга л байна шүү дээ. Тэгээд л баахан ийм ийм хууль санаачлах ёстой гээд. Би 3 жил та нартай бас ойр ажиллах гэж хичээдэг. Над дээр нэг ч удаа нэг ч хүн, ийм хуулийн төсөл та санаачлаач гэж орж ирж байсан хүн байхгүй.

Тэгэхээр та нар бол маш их том эрх мэдэлтэй байгууллага, орон тоо чинь ч гэсэн нийт 80 гаруй хүнтэй гэсэн. Татвар төлөгчдийн мөнгөөр л байгаа шүү дээ. Тэгэхээр та нар маш том эрх мэдэл чинь юу юм бэ гэхээр энэ комиссын гишүүний 28.1-д комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийг хүлээн авсан байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд заавал биелүүлэх үүрэгтэй гээд байна шүү дээ. Та нар т энэ том эрх мэдлийг чинь өгчихсөн байна шүү дээ. Тэгээд яагаад үүгээрээ ажиллахгүй байгаа юм бэ? Та нар өнгөрсөн хугацаанд ямар төрийн өндөр дээд албан тушаалтанд хариуцлага тооцсон юм? Ямар дээд албан тушаалтан та нарыг хүлээж аваагүй юм. Энийгээ яг хариул.

Тэгээд ингээд хүмүүс нь угаартаад л нас барж л байдаг, таг дуугүй. Өдөр болгон 80-100 дуудлага хүүхдийн эрх, гэр бүлийн хүчирхийлэл ирж л байдаг. Таг дуугүй. Тэгээд л нэг ингээд судлаач шиг ингээд байдаг. Та нар арга хэмжээ авахгүй юм бол очиж тэр судлаачийнхаа ажлыг хийх хэрэгтэй шүү дээ. Тэгээд ажлын биелэлт нь 80 хувьтай гээд гаргаж байгаа байхгүй юу. 80 хувьтай гэдэг чинь хаашаа юм. Бид нар тийм их эрхээ хамгаалуулаад, бүх юм сайхан болж байгаа юм уу? Тийм юм байхгүй. Ерөөсөө та нар тэмцсэн зүйл алга. Би та нар т олон удаа хэлсэн, олигтойхон дуугараад өгөөч ээ, шүгэл үлээгээд өгөөч ээ гэсэн. Та нар ерөөсөө энэ дээр ажиллахгүй байгаа.

2 дахь асуудал бол энэ бүх бүлгээр нь би үзлээ. Зүгээр л ерөөсөө та нар комиссоороо хуралдаад л ийм ийм чиглэлээр тайлангаа тавьчихъя гээд л тавьж байгаа. Гэтэл яг нөгөө Монгол Улсын олон улсад очоод энэ нөгөө индекс нь буураад байгаа иргэний болон улс төрийн эрх, амьд явах эрх, энэ шударга шүүхээр шүүлгэх эрх, хэвлэн нийтлэх, үзэл бодлоо илэрхийлэх, тайван жагсаал, цуглаан хийх гэдэг энэ бүх зүйлээр чинь тайланд нэг ч үг алга. Яагаад үүгээрээ тайлангаа гаргаж болдоггүй юм. Олон улс чинь үүгээр үнэлээд байна шүү дээ. Тэгээд энэ индексүүд чинь байж байна. дандаа буурч байгаа байхгүй юу. Тэгэхээр үүгээр тайлан алга байна аа.

Тийм учраас энэ дээр бол маш шүүмжлэлтэй хандаж байна. Тэгээд ер нь бол та нар энэ хуулиа батлуулъя, энэ бүх зүйлээ ерөөсөө араас нь явахгүй байна шүү дээ. Зүгээр нэг тайлан биччихээд л орхихож байгаа байхгүй юу. Би та нар т олон удаа хэлсэн шүү дээ. Нийгэмд гараад энэ шүглээ үлээгээч ээ, та нар т итгэх итгэл чинь харагдахгүй байна, энэ хүмүүсийн араас зоригтой дуугараач ээ гэсэн. Юунаасаа айгаад байдаг юм бэ? Та нар т чинь энэ том эрх мэдлийг нь өгчихсөн байна шүү дээ.

Л.Мөнхбаатар: Одонтуяа даргын асуултад хариулъя. Хүний эрхийн Комиссын дарга Сүнжид хариулъя.

Д.Сүнжид: Одонтуяа гишүүний асуултад хариулъя. Шаардлага зөвлөмж 26 шаардлага, 61 зөвлөмжийг 2023 онд хүргүүлсэн байна. Байгууллагаар нь ялгаж үзвэл ЗГ, яам, агентлаг, түүний салбар нэгжид 9, хууль сахиулах чиглэлийн байгууллагад 16, нийслэл орон нутгийн Засаг даргад 62, төрийн үйлчилгээ, төрийн өмчит аж ахуйн тооцоот байгууллага 25, хувийн хэвилийн ААНБ 11 байгаа юм аа. Тэгээд, энэ шаардлага зөвлөмжийн биелэлт дээр бүгд ирүүлсэн. Хэрэгжилт нь хангалтгүй байна гэж үзсэн шаардлага 2, 6 зөвлөмж байгаа. Түүний мөрөөр арга хэмжээ авсан нь 1, арга хэмжээ аваагүй тухайн албан тушаалтан нь өөрийнхөө хүсэлтээр огцорсон гэж байсан 1 байгаа юм. Ингээд шаардлага бол биелэгдсэн. Зөвлөмжийг араас биелэлтэд нь дахин шаардаад тэгээд дахин биелэлтээ ирүүлж байгаа. Ийм үйл явцтай.

Төрийн өмнөх ингээд сүүлийн жилд биш өмнө сүүлийн 3 жилээр нь авч үзэх юм бол Их Хурлын Тамгын газарт шаардлага зөвлөмж хүргүүлсэн. Ерөнхий сайдад, Засгийн газарт, сайд нарт, АТГ-т, УЕП-т, ЦЕГ гээд бусад байгууллагууд энэ шаардлага зөвлөмжийг хүргүүлж ажиллажээ.

Л.Мөнхбаатар: Шаардлага зөвлөмж өгдөг. Өгөөд шаардлага зөвлөмжийг та бүгдийн үзэж байгаагаар хангалттай биш биелүүлсэн байна гэж үзвэл дараагийн шатанд ямар арга хэмжээ авдаг юм бэ гэсэн агуулгыг Одонтуяа дарга асуугаад байх шиг байна.

Одонтуяа дарга тодруулж асуух уу?

С.Одонтуяа: Яг Мөнхбаатар дарга зөв хэлчихлээ. энэ 28.1-ийг чинь

биелүүлэхгүй бол ямар арга хэмжээ авдаг юм бэ л гэж би асуусан шүү дээ. Тэгээд та нарын энэ явуулсан ийм их асуудалтай Монгол Улсад нэг 6, 10, 20 зөвлөмж чинь хангалтгүй байхгүй юу. Та нар ямар бүтэц бүрэлдэхүүнээр ажиллаж байгаа билээ. Ямар их асуудал байгаа билээ. Энэ бол маш хангалтгүй зөвлөмжүүд шүү.

Тэгээд зүгээр нэг сайхан зөвлөөд сууж бай гээд та нарыг тавиагүй л дээ. Энэ агаарын бохирдол ялангуяа энэ угаартаж маш олон хүн нас барж байна. Энэ бүхний чинь тэр буруутай этгээдэд яаж хариуцлага тооцсон юм бэ? Та нарын зөвлөмжийг биелүүлэхгүй бол дээд шатын дарга нь тэр хүндээ арга хэмжээ авах үүрэгтэй байхгүй юу. Гол нь танай комиссын чинь гол ач холбогдол тэр шүү дээ. Сая Ганбат гишүүн хэлээд байна. Зүгээр нэг зөвлөмж гаргаад суудаг биш гээд. Тэгэхээр энэ дээр яг төрийн дээд өндөр албан тушаалтнууд та нарын мөрөөр яг ямар ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Одонтуяа даргын асуултад тодорхой хариулъя. Хэн хариулах вэ? Хүний эрхийн Комиссын дарга Сүнжид хариулъя.

Д.Сүнжид: 23 оны байдлаар нэг шаардлага бол 2 гээд байгаа юм л даа. Тэгээд түүний нэг нь энэ аймгийн ЗДТГ-аас Хүнс хөдөө аж ахуйн газрын даргад гишүүнээс шаардлага хүргүүлсэн. Тэррийг биелүүлээгүйтэй холбоотой томилох эрх бүхий албан тушаалтанд нь тухайн шаардлагыг биелүүлээгүй албан хаагчдаа Төрийн албаны тухай хуулийн дагуу хариуцлага хүлээлгээч гэсэн. Энэ дээр шийтгэл ногдуулсан гээд ингээд тайлагналтаа ирүүлсэн байна. Ерөнхий сайдад хүргүүлсэн. Энэ дээр хотын Засаг даргатай холбоотой хуульд заасан хариуцлага тооцооч ээ. Өмнө өгсөн шаардлагыг биелүүлээгүй учраас гэдэг ийм шаардлагыг хүргүүлсэн. Тэгээд энэ хотын Засаг дарга нь энэ хугацаанд өөрөө хүсэлтээрээ чөлөөлөгдсөн юм байна.

8 зөвлөмжийн тухайд бол 6 нь биелүүлчихсэн. 2 нь тайлбараа ирүүлээд эргээж биелүүлнэ гэдэг энэ Багахангай аймгийн Засаг дарга байгаа юм. Тэгээд Петро Чайна тачин ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Нэмж хариулах юм уу, болсон уу? Тодруулъя. Одонтуяа дарга тодруулж асууя.

С.Одонтуяа: Миний нөгөө 2 дахь асуултад хариулсангүй. Энэ хүний эрхийн индекс жагсаал, цуглаан хийх эрх чөлөө, энэ бүх зүйлээр ерөөсөө тайланд үг алга байна. Энэ чинь олон улс чинь үүгээрээ тайлангаа дүгнээд явдаг, үүгээр дандаа буураад байхад тайланд 1 ч үг алга гэж асуусан. Ер нь тайланг тэр олон улсын стандарт зөвлөмжийн дагуу гаргаад байвал болдоггүй юм уу гэсэн.

Тэгээд ер нь нэг 8 зөвлөмж 88 хүний бүрэлдэхүүнтэй ийм том эрх мэдэлтэй байж нэг 8, 9 зөвлөмж гээд яриад сууж байх чинь онцгүй л байна шүү.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн 2 дугаар микрофоныг өгье. Асуултад хариулъя.

Г.Нарантуяа: Одонтуяа гишүүний 2 дахь асуултад хариулъя. Тэгэхээр яах вэ, Монгол Улсын хүний эрх, эрх чөлөөний төлөв байдлын илтгэл өнгөрсөн 23 жилд бичигдэж ирсэн жишиг бол тухайн жилд тулгамдсан асуудлуудаа тодорхойлж бичдэг. Түүнээс бүх асуудлуудыг хамрах ийм боломж бололцоо байхгүй байдагтай холбоотой. Тэгэхээр өнгөрсөн жил Хүний эрх, эрх чөлөөний төлөв байдлын илтгэлд бол Иргэний оролцооны эрх зүйн зохицуулалт гэдэг бүлгийг Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль, Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль, Ашгийн бус байгууллагын тухай хуулийг Монгол Улс шинэчлэн найруулахдаа хүний эрх, эрх чөлөөний талаас нь юуг анхаарах ёстой вэ гэдэг Хүний эрхийн Үндэсний Комиссын саналыг маш тодорхойгоор, дээрээс нь

Загвар хуулийн төслийг бичиж бид нар оруулсан юм аа. Тэгээд ер нь өнгөрсөн хугацаанд, өнгөрсөн 3 жилийн туршид бол жагсаал, цуглаан, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөтэй холбоотой явагдаж байгаа, УИХ дээр болж байгаа сонгогч, АН-аас зохион байгуулж байгаа арга хэмжээ энэ болгонд бол комисс очиж байр сууриа бод ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Идэрбат асуултаа асууя.

Ц.Идэрбат: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Тэгээд бид 23 дахь удаагийн илтгэлийг сонсож байна. Тэгээд энэ дээр яах вэ, хүний эрх гэдэг асуудал өөрөө өргөн хүрээтэй. Тэгээд нөгөө таны эрх бусдын эрхээр хязгаарлагддаг гэдэг энэ зарчим би байх ёстой болов уу гэж ингэж боддог юм. Бүгд л эрх яриад байхаас бусдынхаа эрхийг хүндлэхгүй байх.

1 дүгээрт, энэ танилцуулгаас өргөн цар хүрээгээр орсон байна. Ялангуяа эрүүдэн шүүлттэй холбоотой асуудлууд орсон байна. Энэ бие махбодтой шууд холбоотой байх, тийм ээ. Гэтэл та сая нөгөө 1 минутад 1 нь асуугаад, 1 минутад хариулсан учраас жоохон хариулт дутуу хэлчихсэн болов уу гэж ингэж бодож байна.

Цахим орчин дахь хүний эрх. Цахим орчны асуудал чинь сэтгэл санааны эрүүдэн шүүлт болж хувираад байна шүү дээ, одоо. Энэ чинь бүх насныханд. Энэ чинь ганцхан сургууль дээр ч байгаа юм биш. Энэ янз янзын энэ томоохон олон дагагчтай групп, энэ юмнууд чинь бүр тэгээд арай л дэндүү хүний эрхийг үнэн худлыг мэдэхгүй ийм олон юмнуудаар шууд хүний эрхэнд, нэр төрд, магадгүй цаашаа амьд явах эрхэд нь шууд халддаг ийм зүйлүүд байгаад байгаа юм.

Тэгэхээр энэ тал дээр ер нь ямар асуудлууд та бүхэнд хийсэн судалгаа, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ, магадгүй нөгөө танай зөвлөмж гарах ийм

зүйлүүд байгаа юу гэж 1 дүгээрт асууя гэж ингэж бодож байна.

2 дугаарт, энэ эрүүдэн шүүлт гэдэг энэ айхтар зүйл. Би тэр 1930-аад оны сүүлд Монгол гэсэн тэр айхтар зүйлийн талаар ном зохиолоос уншиж байсан. Олон хүний яриа юмнуудыг сонсож байсан. Гэтэл энэ зүйл бараг 100 жилийн дараа Монголд дахиад байсан гэхэд үнэхээр ой тойнд оромгүй л ийм л юм байна лээ шүү дээ. Тэгэхээр ер нь хүний эрхийн байгууллага энэ ялангуяа энэ цагдан хорих энэ байгууллагуудаар та бүхэн нэлээн ажилладаг. Тэгээд тийм камергүй өрөө булан, янз янзын юмнууд байдаг юм уу.

Дахиад Монгол Улсын хаа нэгтээ төрийн байгууллага дээр нь ингээд тоноглогчихсон ийм зүйл байхгүй гэдэгт та нар хэр итгэлтэй байдаг юм? Зүгээр тухайн байгууллагын албан тушаалтны яв гэсэн явж ор гэсэн өрөөг нь ороод үздэг юм уу? Тухайн бүр барилга байгууламжид нь орж үздэг юм уу. Тэгээд би бол тэгээд энэ хүний эрхийн байгууллага цаг үргэлж л энэ хүний эрхийг манаж байх ёстой юм байна. Энд нэг их нийгэм яаж солигдсоноос бол шалтгаалдаггүй юм байна гэж би харж байгаа шүү дээ. эндээс бол, тийм.

Тэгэхээр миний дараагийн санал энэ асуулт бол та бүхэн ингээд нэг зөвлөмж гаргаад сая Одонтуяа гишүүн хэлж байна, бас жоохон наадах чинь 80 хүнтэй энэ том бүх салбарт хүний эрх яригдаж байгаа энэ үед энэ нэг 8, 9 зөвлөмж зарим нь биелсэн, биелээгүй гээд. Тэгэхээр ер нь цаашидаа энэ хүний эрхийн энэ комисс энэ хууль, эрх зүйн хувьд чадамжтай болох энэ тал дээр ер нь яг ингээд ажиллаж байгаа хүмүүсийн хувьд ямар саналууд байдаг юм бол оо? Бид 23 дахь илтгэлээ сонсож байна шүү дээ.

Тэгэхээр 23 дахь илтгэл явтлах энэ хугацаанд хүний эрхийн байгууллагын чадамжийн асуудал, энэ тал дээр ер нь

ямархуу санал байдаг юм бэ гэсэн ийм үндсэндээ 3 асуулт асууя гэж бодож байна.

Л.Мөнхбаатар: Идэрбат гишүүний асуултад хариулъя. Хэн хариулах вэ? Ажлын хэсгийн 2 дугаар микрофоныг өгье. Комиссын гишүүн Нарантуяа хариулъя.

Г.Нарантуяа: Идэрбат гишүүний эхний асуултад хариулъя. Цахим орчинтой холбоотой. Тэгэхээр түрүүнд би хэлсэн, хүний эрх чөлөө технологи ба хүний эрх олон нийтийн хяналт шалгалтын үр дүн бол ирэх жилийн илтгэлийн үндсэн гол асуудал байх юм аа. Энэ дээр энэ технологийн ертөнцөд цахим орчинд бол Монгол Улсын хянаж чадах, зохицуулж чадах орон зай хязгаартай. Нэг талаасаа Монгол Улсын төрийн бодлого байх ёстой болов чиг нөгөө талдаа олон улсын эрх зүйн хөгжилд хөгжиж байгаа орны хувьд өөрийнхөө дуу хоолойг илэрхийлж, манайх шиг улсын эрх ашгийг хамгаалж чадах олон улсын эрх зүйн бодлого зохицуулалтыг бий болгох ийм гарцаагүй шаардлага үүсэж байгаа юм аа.

Тэгэхээр Хүний эрхийн Үндэсний Комиссын нэг чухал чиг үүрэг бол олон улсын эрх зүйг бүтээхэд өөрийн мандатаараа оролцдог ийм чиг үүрэг байдаг. Энэ хүрээндээ бол Ази Номхон Далайн НҮБ-ын хүрээнд, мөн хүний эрхийн Үндэсний Байгууллагуудын дэлхийн хүрээнд хиймэл оюун ухаан, олон нийтийн сүлжээний эрх зүйн зохицуулалтыг Монгол шиг улс орны эрх ашгийг хамгаалдаг болгоход комисс идэвхтэй ажиллаж байгаа гэдгийг хэлье.

Тэгээд ирэх жилийн илтгэлд маш тодорхой санал зөвлөмжүүдийг бид оруулахаар ажиллаж байна аа. Энэ ажлын бэлтгэл ажил үндсэндээ жил хагасын өмнөөс эхэлсэн.

Л.Мөнхбаатар: Нэмж хариулах уу, болсон уу? Ажлын хэсгийн 6 дугаар микрофоныг өгье.

Б.Энхболд: Идэрбат гишүүний 2 дахь асуултад эрүүдэн шүүхтэй холбоотой асуудлыг тодруулж хэлье. Хүний эрхийн Үндэсний Комиссын нэг үндсэн чиг үүрэг бол эрүүдэн шүүлтийг хянах, энэ чиглэлээр гомдол мэдээллийг шалгах энэ чиг үүрэг байгаа. Тэгэхээр Хүний эрхийн Үндэсний Комисст өнгөрсөн жил нийтдээ цагдан хорих байр халдашигүй чөлөөтэй байх, эрүү шүүлттэй холбоотойгоор бол нийтдээ 67 гомдол ирсэн байна. Энэ хүрээндээ бид нар бол бүх гомдлын хүрээнд бол хяналт шалгалтуудыг хорих ангиудад очиж хийж байгаа. Нийтдээ 20 цагдан хорих байр, 6 хорих ангид бол хяналт шалгалтыг явуулжээ. Энэ хүрээндээ бол мөн тодорхой байгууллага, албан тушаалтнуудад шаардлага, зөвлөмж өгч хариуцлага тооцуулсан асуудал байгаа. Энэ дээр бид бүхэн бүх боломжит хувилбараар камерын хяналттай бай гэдэг шаардлагыг тавьж байгаа. Бүрэн тоноглогдсон, бүрэн камержуулсан ийм нөхцөл байдал бол байхгүй байгаа. Энэ дээр бол тодорхой шаардлагуудыг өгч байгаа. Урдаас санхүү, төсөв, хөрөнгийн асуудлыг бол байнга ингэж ярьдаг. Үүнийг шийдвэрлэх шаардлагатай.

Дээр нь хорих ангид ажиллаж байгаа алба хаагчид энгэрийн камер гэдэг зүйлийг бол хэрэглэхгүй байна. Үүнийг бол тогтмол хэрэглэж байх ёстой. Дараа нь асуудал гарахаар энэ камерын хяналтуудыг үзэх, шалгах энэ нөхцөл байдлууд дутмаг байгаа дээр шаардлага зөвлөмжүүдийг өгч ажиллаж байна.

Мэдээж энэ таслан зогсоогдохгүй байгаад харамсаж байна. хүртэл янз бүрийн хувилбараар энэ хэрэг хүлээлгэх, албадах, шахалт үзүүлэх, сэтгэл санааны шаналал зовуурьд оруулах энэ янз бүрийн арга тактикууд байгаад байгааг бол таслан зогсооход бол Хүний эрхийн

Үндэсний Комисс чиг үүргийнхээ хүрээнд тасралтгүй ажиллаж байна. Энэ хүрээнд тэр урьдчилан сэргийлэх механизмтай ч хамтраад нэг нь ргөдөл гомдлыг шалгадаг, шалгасан үр дүнгээ мэдээллээ хүргэдэг, үүний мөрөөр урьдчилан сэргийлэх арга хэмжээ авдаг. Энэ хосолсон арга хэмжээнүүдийг бол аваад ингээд явж байна.

Дээр нь бид бүхэн нэг зүйлийг их болгоомжтой ярих ёстой. хүн нэгэнтэйгээ хүнлэг бус харьцсан үйлдэл болгоныг бид нар эрүүдэн шүүлт гэдэг энэ нэр томъёогоор ойлгож, хэлмээргүй байгаа юм. Цахим орчинд эрүүдэн шүүлт гэдэг ойлголт бол байх уу, үгүй юү гэдгийг эргэж харах ёстой. Харин хүнлэг бус харьцаж байгаа, нэр төрийг нь доромжлон харьцаж байгаа асуудлууд бол байгаа.

Тэгэхээр тэр эрүүдэн шүүлт гэдэг өөрөө их хүнд хэлбэрийн хэрэг хүлээлгэх зорилготой явагддаг энэ хүний эрхийн ноцтой зөрчлүүд байдаг. Үүнийг бол мэдээж таслан зогсооно. Цахим орчны хүний эрхийн асуудлуудыг хяналтдаа авч, энэ чиглэлээр судалгаа, дүгнэлтүүдийг гаргана гэж танд хэлье.

Л.Мөнхбаатар: Тодруулах уу? Идэрбат гишүүн тодруулж асууя.

Ц.Идэрбат: Би цахим орчин дахь эрүүдэн шүүлт гэдгийг кавичкад хэлсэн юм л даа, би кавичкаа харин хэлсэнгүй. Гэхдээ наадах чинь дижитал сорви гэж үг хэллэг байдаг юм байна лээ шүү дээ. Түүн дээр нэг л тавигдчихсан бол тэгээд л насан туршидаа тэнд хадгалагдаад л байж байдаг. Тийм, тэгэхээр наадах чинь сэтгэл санааны байхгүй юу, та тэрийг ойлгох хэрэгтэй. Сэтгэл санаа, би бие махбод болон сэтгэл санааны ийм хүнд байдалд орж байна гэсэн санааг хэлж байгаа юм. Тийм. Хүнийг тэнд буруу зөвийг нь мэдэгдэхгүй олон нийтийн сүлжээн дээр аваачаад тавьчихсан, тавиулчихаад тэр доор нь эсэн бусаар

хэлүүлээд сууж байгаа хүний хувьд хүнд байдал биш үү? Тийм сэтгэл санааны гэж би хэлэх гээд байгаа юм. Тэгэхээр би кавичкинд хэлэх ёстой байсан байна. Тийм.

Нөгөө талаасаа хорих нь энэ чинь нэг аймаг болгонд нэг цагдан хорих. Тэгээд хорих нь цагдан хорихын камерын асуудлыг өнөөдрийг хүртэл шийдэж чадаагүй байгаа юм уу? Би таны үгнээс тэгж ойлголоо.

Л.Мөнхбаатар: Цагдан хорих байр нь камертай байгаа юм байгаа биз дээ. Тэнд ажиллаж байгаа албан хаагчид энгэрийн камер зүүх шаардлага та нарт тавьдаг юм байна гэж ойлголоо. Тийм үү. Аль эсвэл цагдан хорих байранд орох камергүй байгаад байгаа юм уу? Энэ дээр нь тодруулаад хариулчихъя.

Ажлын хэсгийн 6 дугаар микрофоныг өгье.

Б.Энхболд: Цагдан хорих байрнууд бол бүрэн камерын хяналтад орсон. Тэнд ажиллаж байгаа яг алба хаагчдын энгэрийн камерын асуудлыг ярьсан.

Хорих ангиуд бол 100 хувь бүрэн хяналтад орсон гэхэд учир дутагдалтай байгаа. Идэрбат гишүүн ээ, үүнийг би дутуу хэлсэн байна. Хорих ангийн ингээд яг амьдралын бүс, хоригдлууд байнга байдаг, хоол сургалт явагддаг энэ хэсгүүд бол өөрөө камерын хяналттай байгаа, бүрэн. Гэтэл түүн дотор бол хорихыг ингээд тодорхой зарим хэсгүүд нь камерын хяналтаас гарах гэдэг юм уу, камерын хяналтгүй байх ийм нөхцөл байдлууд байгаад байгаа юм. Үүнийг бол 100 хувь бүрэн камертай болго гэдэг энэ шаардлагуудыг тавьж байгаа.

Дээр нь энэ камерын нөгөө бичлэгийн хадгалалт, хамгаалалт нь өөрөө учир дутагдалтай. 14 хоног, сарын дараа, 7 хоногийн дараа шалгах гээд тэгэхээр устдаг гээд энэ хүчин чадлуудыг

бол бүхэлд нь сайжруулах ийм ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: байнгын хорооны дарга Энхбаярын Батиугар асуултаа асууя.

Э.Батиугар: Баярлалаа. Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. 21 оны 12 сард Хувь хүний мэдээллийг хамгаалах тухай хууль батлагдсан. Үүнтэй холбоотойгоор Хүний эрхийн комисс нэлээн тийм том үүрэг рольтой л доо. Ялангуяа хүний эмзэг мэдээлэлтэй холбоотой боловсруулах, хадгалах мөн ашиглах заалтууд байгаа л даа. Тэгээд энэ хууль хэр зэрэг хэрэгжиж байгаа вэ? Энэ заалт. Ялангуяа ч наад захын хэдэн жишээ өгөхөд бол хаана камер байршуулах вэ, байршуулахгүй байх вэ гэдэг дээр Хүний эрхийн комиссоос зөвлөмж авдаг. Мөн гомдол гарвал Хүний эрхийн комисст ханддаг. Наад захын жишээ гэхэд жишээлбэл фитнес бүр зарим фитнес бүртгүүлье гэхээр хүний эмзэг мэдээллийг асуугаад байдаг. Өгөхгүй гэвэл бүртгэхгүй, заавал өгөх ёстой, дотоод фитнесийн дүрэм журам гэх мэтчилэн зүйлүүд гардаг л даа. Энэ дээр яг яах ёстой юм, хэр зэрэг хэрэгжиж байгаа вэ. Тухайн иргэн ийм асуудалтай тулгарвал яаж хандах уу гэдэг асуулт асууя.

2-т нь, хүний эмзэг мэдээллийг хууль бусаар авчхаад, тэгээд хүмүүсийг шантаажилдаг тийм асуудлууд их гардаг. Над дээр ч гэсэн тийм гомдлууд гарч байсан. иргэдээс. Тэгэхээр яг үүн дээр Хүний эрхийн комисс ямар зөвлөмж өгөх вэ, яаж аль тийшээ хандах вэ гэдэг дээр та бүхний байр суурь юу вэ гэж асууя. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Асуултад хариулъя. Ажлын хэсгийн 2 дугаар микрофоныг өгье.

Г.Нарантуяа: Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль батлагдсантай холбоотой Хүний эрхийн

Үндэсний Комисс дээр энэ хуулийн хэрэгжилтэд голлох үүрэгтэй оролцох шинэ тусгай мандатыг бий болгосон байгаа. Тэгэхээр хуулийн хэрэгжилтээ төдийлөн хангалттай байна гэж үзэхгүй байгаа.

Тийм учраас технологи хүний эрхийн бид нарын энэ бүтэн жил хийж байгаа хяналт шалгалтын нэг гол өнцөг бол Хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн хэрэгжилт, энэ хуулийг цаашид яаж боловсронгуй болгох вэ гэдэгтэй холбоотой асуудал байгаа юм аа. Харьцангуй нэг үеэ бодох юм бол Хүний эрхийн Үндэсний Комиссоос камер байрлуулах гэсэн юм аа. Хүний хувийн эмзэг мэдээллийг бусад хүмүүс шилжүүлж авахаар хүсэлт гаргажээ. Бид нар энэ дээр яах вэ гэдэг зөвлөгөөтүсламжийн хүсдэг ийм практик бий болжээ.

Нөгөө талдаа бол өнгөрсөн энэ хууль батлагдаж комисс чиг үүргийг хүлээж авснаас хойш бол хамгийн 1 дүгээрт, ажлыг сайн явуулахын үндэс нь өөрсдөө учраа олох байдаг. Тэгэхээр комиссын ажилтнуудыг чадавхжуулах, яг үнэхээр хүний хувийн мэдээллийг хамгаалах хууль тогтоомж чинь энэ юм шүү, ингэж хэрэгжүүлэх юм шүү, энэ заалтыг нь ингэж ойлгох юм шүү гэдэг дэг жаягийг тогтоох явдал бол чухал байлаа. Бид үүнийгээ хангалттай хийсэн гэж үзэж байгаа.

Хуулийн хэрэгжилт дээр бол хэд хэдэн асуудал байгаа. Хүний эрхийн Үндэсний Комиссын бүрэн эрхийг тодорхойлохдоо комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийг зөвхөн байгууллагад өгөхөөр тодорхойлсон байгаа. Гэтэл өнөөдөр бодит байдал дээр яаж байна вэ гэхээрээ хувь хүмүүсийн хооронд бие биеийгээ шантаажилж байгаа асуудлууд гардаг. Энэтэй холбоотой асуудлыг эрүү зөрчлийн хуулиар ший шийдүүлэхээр цагдаагийн байгууллага руу шилжүүлдэг. Гэтэл хүний

хувийн мэдээллийн талаарх ойлголт, эмзэг мэдээллийн талаарх ойлголт төдийлөн хангалттай байхгүй байгаатай холбоотой бол манай шилжүүлсэн гомдол, мэдээллийг гэмт хэргийн зөрчлийн бүрэлдэхүүнгүй байна гэж хэрэгсэхгүй болгодог ийм тохиолдлууд байгаа.

Тэгэхээр энэ асуудлуудыг бид цогцоор нь харах ёстой. Ер нь бол яах вэ, зүгээр яг үнэхээрийн хуулийг хэрэгжүүлж байгаа тэр механизмыг нь бол бид нэлээн сайжруулах ёстой байгаад байгаа юм. Энэ дээр бид ирэх жил бол маш тодорхой зөвлөмжүүдийг саналуудыг гаргана гэсэн ийм төлөвлөгөөтэй байгаа.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Мөнхцэцэг асуулт асууя.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр УИХ 2021 онд Азид анх удаа хүний эрхийн төлөө зүтгэгчдийг хамгаалах, хүний эрх хамгаалагчийн хуулийг батлан гаргасан. Энэ ажлын хэсгийг миний бие ахлан ажилласан байгаа. Тэгээд үүнээс хойш ингээд бүх бүхэл бүтэн 2 жил хагасын хугацаа өнгөрч байна. Энэ хугацаанд Монгол Улсад иргэний болон байгаль хамгаалах чиглэлээр хүний эрхийг хамгаалж байгаа хамгаалагчдын эрхийн талаар энэ тайлан илтгэлд оруулсан нь сайшаалтай байна аа. Яг энэ хуулийг батлах үед манай иргэний нийгмийн байгууллагууд, хүний эрхийн төлөө тэмцэгчдийн зүгээс маш их саналууд ирүүлж байсан. Тодорхой эрх мэдэлтэн, албан тушаалтнуудын зүгээс мөн тодорхой уул уурхайн компаниудын компаниудын зүгээс дарамтлах, айлган сүрдүүлэх, мөн тодорхой байдлаар биед нь халдах зэрэг иймэрхүү эрүүгийн болон зөрчлийн шинжтэй их олон дарамтууд байдаг гэдгийг бид нарт мэдээлж, энэ хууль маань гараад ингээд энэ 2 жил хагасын хугацаанд ер нь бол хүний эрхийг хамгаалагчдын эрх зүйн байдал бол нэлээн сайжирсан байгаа. Энэ чиглэлээр илүү зоригтой дуугарч, илүү олон иргэд, иргэний нийгмийн байгууллагууд орж

ирж, энэ хүний эрхийн үйл хэрэгт дуу хоолойгоо өргөж байна гэж бид нар итгэж байгаа.

Гэхдээ ингээд тайлан судалгаанаас харахад нэлээн анхаарал хандуулах ноцтой юмнууд байна аа. Хүний эрхийн чиглэлээр ажиллаж байгаа маш олон хүмүүс маань энэ эрхийн дарамт гэдэг юм уу тодорхой зөрчилд оюун санааны, бие махбодын, айлган сүрдэх зэрэг их олон энэ гэмт хэрэг, хүний эрхийн зөрчлүүдтэй нүүр тулгарсан байна. Ялгаварлан гадуурхдаг, сэтгэл санаа хүчирхийлэл үйлддэг, бараг нийтдээ энэ эрхэд халдсан байдлын хамгийн өндөр хувь нь энэ айлган сүрдүүлдэг, заналхийлдэг энэ юунууд их байгаа юм байна.

Мөн цахим халдлага гэдэг юм уу, тухайн хүний эрхийн төлөө зүтгэгчийн хувийн юунд халддаг, үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг нь зөрчдөг, гэр бүл ойр дотнын хүмүүсээр нь дарамтлах байдал гээд. Тэгэхээр ер нь бид нар энэ хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагааг дахин илүү хамгаалах, шүгэл үлээгчийг ажиллах нөхцөлийг бүрдүүлэхийн тулд яг манай Улсын Их Хурлаас эрх зүйн ямар санал санаачилга гаргах ёстой вэ?

Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүд маань бол яг Үндсэн хүний эрхийн комиссын тухай хуулиараа тодорхой асуудлаар олон улсын гэрээ, конвенцоор болон бусад асуудлаар, хууль тогтоох болон бусад албан тушаалтнуудад санал өгөх, хуулийн тодорхой санаачилга гаргах ийм эрхтэй байгаа. Тэгвэл тухайлан яг хүний эрхийн төлөө тэмцэгчээ хамгаалахын тулд бид нар ямар эрх зүйн юунуудыг хийх ёстой вэ гэдгийг 1 дүгээрт асууя.

2 дугаарт нь, энэ гэрч хоригчийг хамгаалах үйл ажиллагаа ерөнхийдөө учир дутагдалтай байдаг. Бид нар яг энэ шүгэл үлээгч ажлын хэсэг гэдгээр бас нэлээд олон газар очиж ажилласан. Байгууллага болон санхүүжилтийн хувьд

учир дутагдалтай байгаад байгаа. Тэгэхээр энэ гэрч хохирогчийг хамгаалах механизмыг яг энэ дараагийн том реформ болохын хувьд бид нар УИХ болон Хууль зүйн яам руугаа хандаж та бүхэн ямар санал зөвлөмж гаргаж байгаа вэ? Ер нь бол энэ аюулгүй байдалд хангах, ялангуяа энэ хүний эрхийн төлөө дуу хоолой болж байгаа, тодорхой асуудлаар шүгэл үлээж байгаа иргэн бол өнөөдөр хангалтгүй хамгаалалтгүй нөхцөл байдалд байна аа.

Тэгэхээр энэ тал дээр яг юу хийх ёстой гэдгийг Хүний эрхийн комиссын зүгээс тодорхой санал саналууд гаргасан байх ёстой. Үүнийгээ илүү тодруулж өгөх хэрэгтэй байна.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн 1 дүгээр микрофоныг өгье. Асуултад хариулъя. Мөнхцэцэг гишүүний асуултад хариулъя.

С.Дондов: Мөнхцэцэг гишүүний асуултад хариулъя. Хүний эрхийн Үндэсний Комисст 2 жилийн өмнөөс Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг хэрэгжүүлэх шинэ механизм хэрэгжин ажиллаж эхэлж байна аа. Энэ хугацаанд бол хүний эрхийн хамгаалагчийн энэ шинэ механизмыг бий болгоход бол хүндрэл бэрхшээлүүд байна. Эхний удаад бид Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг сурталчлан таниулах, 2 дугаарт нь, хүний эрхийн хамгаалагчийн бүрэлдэхүүнд ямар ямар субъектүүд орох ёстой вэ, тэнд оролцож байгаа субъектүүдэд ямар хүндрэл цаашид төрийн зүгээс зайлиггүй бодлогын хэмжээнд авч анхаарах ямар асуудлууд байна вэ гэдгийг энэ 23 дахь илтгэлдээ бол 5 дахь бүлэг болгон иргэний нийгмийн байгууллагын болон байгаль орчны хамгаалагчдын өнөөгийн нөхцөл байдал гэсэн судалгааг хийлгээд тодорхой саналыг дэвшүүлж байна аа.

Энд бол хүний эрхийн хамгаалагчдын бүрэлдэхүүнд иргэний

нийгмийн байгууллагын ажилтнууд, мөн сэтгүүлчид, өмгөөлөгчид, мөн байгаль орчны асуудлаар ажилладаг хүний эрхийн хамгаалагчид бол илүү их багтаж ордог. Эд нарт бол өнөөгийн байдлаар бидний судалсан хэмжээний хүрээнд бол хамгийн тулгамдаж байгаа асуудал бол аюулгүй байдлыг нь хамгаалах. Тэднийг аюул эрсдэл, заналхийллээс хамгаалах энэ асуудал бол манай улс орны хэмжээнд бол Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэс ЦЕГ-ын дэргэд 4 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна. Орон нутагт бол 1 мөрдөгч юм уу, 1 ажилтан л гэрч хохирогчийг хамгаалах асуудлыг ингээд хариуцаад ингээд явж байгаа байдал нь хүний эрхийн хамгаалагчийн аюулгүй байдлыг хамгаалах, мөн тэдний эрх ашгийг хангах, мөн хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан энэ аюулгүй байдлыг нь хангах, учирсан гэм хорын хохирлыг нь төр эргээж нөхөн барагдуулах гэх мэтийн ийм үйл ажиллагааг хангалттай бүрэн хэрэгжүүлэхэд бол төвөг саад учирч байна аа.

Тийм учраас бид гэрч хохирогчийг хамгаалах механизмыг Монгол Улс бүхэлд нь бий болгох асуудал дээр илүү түлхүү анхаараач гэсэн энэ саналыг бол оруулсан байгаа. Үүнд:

1 дүгээрт нь, иргэний нийгмийн байгууллагад ажиллаж байгаа, шударга шүүмжлэл өрнүүлж байгаа, асуудлаа шийдвэрлүүлэхээр бодлогын түвшинд явж байгаа, эсвэл асуудалтай хүмүүст бичгээр асуудлаа өгөх, хариулт мэдээллээ авахад маш их хүндрэл учирч байна гэсэн. Энэ бидний хийсэн судалгаагаар 47 хувь нь бид төрийн байгууллагаас үндэслэлтэй мэдээллүүдээ авч чадахгүй байна. Энэ асуудал дээр бид нарт хүндрэл бэрхшээл учирч байна гэж үзсэн. 50 орчим хувь нь бол бидний аюулгүй байдал хангалттай биш байна аа.

Тийм учраас бид нар энэ аюулгүй байдлаа хангуулах ийм механизм байхгүй

учраас өөрсдийнхөө үгээ хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, чөлөөтэй асуудлаа шийдвэрлүүлээд явах асуудалд хаалттай, төвөгтэй байна гэсэн энэ асуудлуудыг гаргаж байгаа учраас энэ байгаль хамгаалагчийн эрх зүйн байдлыг нь үндсэнд нь үнэлж гаргах, байгаль хамгаалагчийн асуудлаар бол Байгаль орчныг хамгаалах тухай хуульд тухайн хүний хэдий хэмжээний газар нутгийг хамгаалах юм, тэр хүн ямар үйл ажиллагаа явуулахыг тодруулсан хэр нь байгаль хамгаалагчийн өөрийнх нь ажлын байр тодорхойгүй, ажлын байран дээр байж байна гээд гэртээ өөрөө ирээд байж байхад нь хүмүүс ирээд чи энэ мөнгө төгрөг авах гэж, мөнгө төгрөг авах гэдэг нь Байгаль орчныг хамгаалах тухай хуульд тэр байгалийн нөөцийг ашигласнаас гарах сангийн 15 хувийг бол тодорхой хэргүүдийг илрүүлснийх нь төлөө өгнө өө гэсэн ийм зохицуулалттай уялдуулаад чамд ийм хэмжээний мөнгө хэрэгтэй байна уу гэх маягаар ирж дарамтлах, айлган сүрдүүлэх, заналхийлэх ийм явдал түгээмэл байна. Гэтэл энэ хууль хяналтын байгууллагад өөрөө зохих журмын дагуу өргөдөл, гомдлоо өгөөд шийдүүлэх гэхээр та ажлын байрандаа байгаагүй, гэртээ байсан байна аа.

Тийм учраас таныг ажлын байран дээр ажил үүргээ гүйцэтгэж явахтай чинь холбогдуулаад хууль сахиулагчийнх нь хувьд эрхийг нь зөрчжээ гэж үзэх үндэслэл байхгүй байна гэдэг асуудлаар байгаль хамгаалагчийн эрхийг удаа дараа зөрчиж байна гэсэн энэ судалгаа бол мөн бидний хийсэн судалгаагаар тодорхой гарсан.

Тийм учраас бид энэ Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулийг бодитоор хэрэгжүүлэх шаардлагатай байна аа. Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуульд бол шинээр батлан гаргаж байгаа шинэ хуулиудтай уялдуулаад зүйл заалт нэмдэг. Жишээлбэл Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль батлагдсантай холбогдуулаад

хүний эрхийн хамгаалагчийн ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг хэлэлцэж байна.

Энд Улсын Их Хурлын гишүүд нэлээн шүүмжлэлтэй хандаж байгаа зүйлүүд байгаад байна. Тэгэхээр Хүний эрхийн комиссын тухай хууль гарч байх үед би тухайн үед асууж байсан л даа. Энэ хууль яг энэ та бүгдийн энэ хяналт тавих энэ механизм, энэ хуулийг хэрэгжүүлэх механизм чинь та бүгдийн төсөөлж байгаагаар зөвлөмж, шаардлага гэсэн 2 зүйлтэй байх нь. Энэ шаардлагыг заавал бэлгэдэх гэсэн ийм чанартай гаргаж байгаагаараа их томоохон ахиц гарч байна аа. Ингээд л бид нар чинь хүний эрхийн нөхцөл байдалд хүний эрхийн байдалд нэлээн хяналт тавих энэ чиглэлээр ажиллах боломж нэлээн бололцоотой болж байна гэсэн зүйлүүдийг л хэлсэн. Тэгээд одоо бол нөхцөл байдлууд төдийлөн сайн сайжрахгүй байгаад байгаа юм.

Тэгэхээр энд эрх зүйн ахиад та бүгдэд шинэчлэл шаардлагатай байна уу? Хүний эрхийн комиссын болоод бусад дагалдах бусад хуулиудад эрх зүйн зохицуулалтууд нэмэлтээр ямар шаардлагууд байна?

2 дугаарт, бусад улс оронд олон улс оронд байдаг жишиг байгууллага. Тэгэхээр шаардлага өгдөг, шаардлага нь заавал биелэгдэх шинэ чанартай байна гэснээс илүү тийм механизмтай улс орнууд байна уу? Илүү хүчтэй гэсэн үг шүү дээ тийм ээ. Заавал та бүгдийн эрх мэдлийг нэмэгдүүлэх, энэ хууль гарцаагүй хэрэгждэг байх, хүний эрхийн байдалд тавьж байгаа энэ хяналтыг сайжруулах чиглэлээр илүү ажилладаг шинэ гэдэг юм уу, хүчтэй тийм механизм байна уу гэж би та бүгдээс тодруулаад асууя.

Хэн хариулах вэ? Хууль эрх зүйн өөрчлөлт хийхээр та нар төлөвлөж байна уу? Хүний эрхийн комиссын дарга Дугарын Санжид хариулъя.

Д.Сүнжид: Мөнхбаатар дэд даргын асуултад хариулъя. 2020 оны Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн шинэчилсэн найруулга баталсны дараагаар нэг 3 механизм өөр бусад хуулийг дагаж орж ирсэн. Нэг нь нөгөө эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа Комиссын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар шинээр бий болсон. Одоо 1 гишүүн энэхүү чиг үүргийг дагнан хариуцаад ажиллаж байна.

2 дахь нь, Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг дагаад хүний эрх хамгаалагчийг хариуцсан 1 гишүүнтэй болсон. Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулийг дагаад 1 гишүүн нь энэ хүний хувийн мэдээлэл хамгаалах чиг үүргийг давхар ингэж хариуцаж ажиллахаар болсон. Тэгэхээр энэтэй холбоотойгоор Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд энэ 3 механизмаа ажиллах уялдаа холбоог нь сайжруулах нэг ийм хэрэгцээ байна.

2 дахь нь одоо 82 түрүүн бид хэд дурдлаа, 82 албан хаагчтайгаар гишүүд нь ороод ажиллаж байгаа. 21 нь орон нутагт ажиллаж байгаа юм. Хэг нэг хүн ажилладаг, аймаг болгонд. Тэгээд энэ нь өөрөө Парисын зарчмын дагуу хараат бус үндэсний хүний эрхийн байгууллагын нэг шалгуур нь болдог. Тиймээс орон нутагт ийм салбартай байх гэдэг шалгуурыг хангаж байна гэж бид нар үздэг.

Тэгэхээр 1 хүн ажиллах их үйл ажиллагааны цар хүрээний хувьд, үр дүнгийн хувьд их хязгаарлагддаг учраас энийг цаашидаа бүс нутагт төвлөрүүлэх эсэх гээд нэг ийм асуудлыг шийдвэл зүгээр байгаад байдаг, 2 дахь санал нь.

3 дахь нь, шаардлага, зөвлөмжийн хувьд тодорхой ярьж байна. Гишүүд санал болгож байна. Тэгэхээр шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт яагаад 80 хувьтай байгаа вэ? Энэ нь эрх зүйн зохицуулалтын асуудал гэхээсээ илүү тухайн тэр үүрэг хүлээгчид төрийн албан хаагчдын хандлагын асуудал I дүгээрт нь байна.

2 дугаарт нь, төсвийн асуудал давхар яригддаг аа. Зөвлөмжөөр бид нар тодорхой асуудлыг шийд, арга хэмжээ ав. Гэхдээ давхар энэ төсвийнх нь асуудлыг шийдье гэдэг асуудлыг ярьдаг. Жишээ нь 2021, 2022 онд үргэлжилж хийсэн хүүхдийн эрхийн нээлттэй хянан шалгалтын үр дүнд хийсэн анхан шатын тэр тогтолцоо хүүхдийн эрхийн хамгааллын тогтолцоог бэхжүүлэхэд төсөв бол нөгөө энэ анхан шатад нь хүрдэггүй юм байна гэдгийг нь удаа дараа хэлдэг. Ингээд төсвийнхөө асуудлыг шийд, хүүхэд хамгааллын бодлого, арга хэмжээ, хөтөлбөрийг хэрэгжүүлэх төсвөө шийд гэхээр тэрийг нь шууд шийдчих тийм боломж, арга механизм учир дутагдалтай байгаад байдаг.

Тийм болохоор үүнийг холбох хэрэгтэй юм байна гэдэг ийм саналтай байгаа.

Дараагийн нэг санал нь Комиссын тухай хуульд 22.2 гэж нэг заалт бий. Өөрөөр хэлэх юм бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, шүүхээр шүүх болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд явж байгаа үйл ажиллагаанд оролцох эрхгүй байдаг, Хүний эрхийн Үндэсний Комиссоос. Тэгэхээр бид нар энэ хүрээнд процессын эрх зүйн хувьд нь оролцоод ингээд явдаг аа. Тэгэхээр энэ дээр заримдаа энэ нь аль хүрээнд оролцох эсэх, оролцох уу, үгүй юү гэдэг дээр бид нар тодорхой асуулт үүсгэдэг учраас журмыг нь илүү тодруулах хэрэгтэй юм байна гэж үздэг. Эвлэрүүлэн зуучлах гээд нэг заалт байгаа юм. Тэгэхээр Шүүхийн тухай хуульд

заасан эвлэрүүлэн зуучлахаас манай заалт арай өөрөөр хэрэгжих учиртай болдог. Тусдаа магадлан итгэмжлэл ирэхгүйгээр.

2-т нь тэр хэрэг маргааныг урьдчилан шийдвэрлэх ажиллагааны шат байна. Тэгээд энэ юу шүүхийн шатад байгаа тэр мөрдөн шалгах ажиллагаанд байгаа хэрэгтэй аль хүрээнд нь бид нар энэ процессын эрхийг ойлгож хэрэглэх юм бэ гэдэг энэ асуудлуудыг процессынх нь хувьд тодруулж өгөх шаардлагатай юм байна гээд байна гэдэг ийм ийм саналууд бий.

Л.Мөнхбаатар: Гишүүд асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

Нэгдсэн хуралдаанаар Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэлийг хэлэлцлээ.

Дараагийнхаа асуудалд орёе.

13.29 цагт

“Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл, 2023 оны эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцье.

Төслийн талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Хүний эрхийн дэд хорооны дарга Цэрэнжамцын Мөнхцэцэг танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Ц.Мөнхцэцэг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүний эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2023 оны

тайланг ХЗБХ 2024 оны 04 сарын 16, 23-ны өдөр тус тус хэлэлцсэн.

ХЗБХ Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1-д заасныг баримтлан “Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэлд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2023 оны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Сэргэлэн төсөлд туссан хүүхдийн тэтгэлгийн сангийн талаар болон шүүхийн шийдвэрээр тогтоогдсон иргэдийн хохирлыг барагдуулах чиглэлээр ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Мөнхцэцэг гэрч хохирогчийг хамгаалах бие даасан механизмыг бий болгох асуудал болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх боломжийн талаар тус тус асуулт асууж, хариулт авсан.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Энхбаяр төслийн 4 дэх хэсгийн хүүхдийн тэтгэлгээ хугацаанд нь төлөхгүй байгаа болон хүүхдээ хүмүүжүүлэх, тэжээн тэтгэх үүргээ биелүүлэхгүй байгаа асран хамгаалагч, эцэг эхэд хүлээлгэх хариуцлагын талаарх зохицуулалтыг Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд туссан тул уг тогтоолын төслөөс хасах нь зүйтэй гэсэн саналыг Байнгын хорооны гишүүдийн олонх дэмжээгүй бөгөөд хүүхдийн тэтгэлгийн сантай холбоотой асуудлын талаарх уг заалтыг тогтоолын төсөлд хэвээр үлдээх нь зүйтэй гэж үзлээ.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Энхбаяр эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх нэгж нь Хүний эрхийн Үндэсний Комиссын дэргэд байх нь зүйтэй буюу эрүү шүүлтийн асуудал хариуцсан гишүүн нь төсвийн ерөнхийлөн захирагч болох нь зохисгүй талаар санал хэлээд, тогтоолын төслийн 9 дэх хэсгийн Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх механизмтай холбоотой зохицуулалтад нэмэлт, өөрчлөлт оруулах талаарх заалтыг хасах санал гаргасныг Байнгын хорооны гишүүдийн олонх дэмжээгүй буюу эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх механизмыг олон улсын гэрээ конвенцод заасны дагуу боловсронгуй болгох талаар Засгийн газарт чиглэл өгөх нь зүйтэй гэж үзлээ.

“Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаар 23 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2023 оны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулах нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, “Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2023 оны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Мөнхцэцэг даргад баярлалаа.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүн байна уу? Байхгүй байна. Одонтуяа даргаар тасаллаа.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын дэд дарга Салдангийн Одонтуяа асуулт асууя.

С.Одонтуяа: Тэгэхээр өнгөрсөн хугацаанд Улсын Их Хурлаас 3 тогтоол гарсан байдаг. Ялангуяа энэ хүний эрхийн нөхцөл байдлыг сайжруулах, эрүүдэн шүүхтэй эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх талаар чухал тогтоолууд гарсан. Энэ тогтоол дээр нэг 2 үндсэн зүйл байгаа юм аа. Энийг би хуулийн төсөл өргөн барихаар бэлтгэж байгаа. Энэ ямар утга учиртай юм бэ гэхээр 1 дүгээрт, энэ та бүхэн мэдэж байгаа, манай Хүний эрхийн дэд хороо ч хэд хэд хуралдсан. Энэ цэргийн байгууллагуудад цэргийн албан хаагчдын дунд энэ дүрмийн бус ажиллагаа маш их зөрчлүүд гарсан. Олон хүний амь үрэгдсэн ийм асуудлууд байгаа. Тийм учраас Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд энэ зэвсэгт хүчин, хилийн болон дотоодын цэргийн анги гэдэг заалтыг нэмсэн байгаа. Өөрөөр хэлбэл, эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх энэ үндэсний ажиллагааны гишүүд маань эдгээр байгууллагад очиж, урьдчилан сэргийлэх ийм боломжтой болж байгаа. Энэ бол маш чухал зүйл.

Өөрөөр хэлбэл аливаа хэргийг гарсных нь дараа биш өмнө нь урьдчилан сэргийлж, сайн ажиллах хэрэгтэй. Тэгэхээр энэ би 23 оны ажлын тайланг харлаа. Тэгээд түрүүн тэр Энхболд гишүүн ч ярьж байна. Энэ маш сайн зүйлүүдийг хийсэн байгаа. Урьдчилан сэргийлэх дээр. Жишээлэхэд 8200-аад хүнд сургалт хийсэн, 979 онд ганцаарчилсан зөвлөгөө өгсөн гээд л ингээд олон юм байна л даа. 1440 хүнтэй албан хаагчидтай ингээд ганцаарчилсан ярилцлага авсан, асуумж авсан.

Тэгэхээр би бид нар ингэж байж энэ урьдчилан сэргийлэх ажиллагаа чинь яг амьд байх юм. Тэгэхээр энэ хууль дээр зэвсэгт хүчин, хилийн болон дотоодын цэргийн анги гээд нэмэх юм бол эдгээр байгууллагуудад энэ урьдчилан сэргийлэх, эрүүдэн шүүхтэй холбоотой урьдчилан сэргийлэх ажиллагаа хийх боломжтой болно оо. Үүнийг бол гишүүд ерөнхийдөө санал солилцоход дэмжиж байгаа.

2 дахь асуудал бол энэ тогтоолд нэг ийм зүйл байгаа юм. Олон улсын гэрээ конвенцуудад дотоодын хууль тогтоомжийг нийцүүлэх ажлыг эрчимжүүлэх гэж байгаа юм. Тэгэхээр энэ дээр миний тэр өргөн барих гэж байгаа хуульд эрүүдэн шүүхийн энэ урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хараат бус байх ёстой гэсэн ийм заалтыг оруулсан. Хараат бус байх ёстой гэж. Энэ бол би бодож олоогүй л дээ. Энэ олон улсын зөвлөмжийн дагуу танай улс чинь энэ хараат бус байхгүй бол буруу байна. Энэ механизм чинь буруу байна. Санхүүгийн хувьд, тэгээд л унаа тэрэг бүх юмны хувьд хараат байхаар энэ асуудал чинь явдаггүй юм гэсэн зөвлөмж өгсөн байгаа.

Тэгэхээр энэ асуудлыг бол Улсын Их Хурлаар хэлэлцэнэ ээ.

Миний зүгээр нэг эмзэглэж байгаа асуудал юу вэ гэхээр ер нь энэ эрүүдэн шүүгдэж байгаа хүмүүсийг ингээд хүнд, хүнд кэйсүүдийг аваад үзэхээр дандаа ардаа том артай, ардаа улс төрийн захиалгатай ийм хүмүүс эрүүдэн шүүхийн маш том хэргүүдийг хийсэн байдаг.

Тийм учраас энэ өөрөө асар их хараат бус байх ёстой гэдгийг дэлхий нийтээрээ энэ олон улсын экспертүүд чинь яриад байгаа. Тэгээд энд сууж байгаа 6 хүн бараг бүгдээрээ шахуу эрүүдэн шүүхийн энэ үйл ажиллагааг хараат бус байх ёстой, санхүүгийн хувьд хараат бус байх ёстой гээд бүгдээрээ гар, хөлийн үсгээ зурчхаад гэнэт мурьж

байгаа байхгүй юу. Яаж мурьж байгаа гэхээр Улсын Их Хурлын гишүүдтэй очиж уулзаад энэ хараат бус байлгaмааргүй байна, эд нар салан тусгаарлах гээд байна гэдэг ийм асуудал яригдаж байгаа. Би энэ дээр асар эмзэглэж байна.

Харин Хүний эрхийн Комиссын гишүүд үүнийг хараат бус байлгаад өгөөч ээ, энэ хэзээ нэгэн цагт гай болох вий гээд энэ дээрээ яагаад ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Асуулт уу. Одонтуяа даргын асуултад хариулъя. Хууль тогтоомжтой асуудлууд байна. Хэн хариулах вэ? Хүний эрхийн Үндэсний Комисс хуралдаж байгаад шийдэх юм уу, хэн хариулахын. Хэн нь вэ? хэддүгээр микрофон? 6.

Б.Энхболд: Одонтуяа гишүүний асуултад хариулъя.

Мэдээж Хүний эрхийн Үндэсний Комиссын нэг чиг үүрэг бол энэ 20 жилийн хугацаанд хийж ирсэн асуудал энэ эрүү шүүлтийн асуудлыг анхааралдаа авч ирсэн байдаг. Тэгэхээр олон улсын гэрээ конвенцоор эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх гэдэг нэг ойлголт, эрүү шүүлтэд гомдол, мэдээллийг хүлээн авч хянаж шалгах гэдэг энэ ойлголт нь өөрөө тусдаа байна гээд энэ конвенцын нэмэлт протоколын гол агуулга нь юм байгаа юм. Бид бүхэн мэдээж ямар нэгэн байдлаар хараат бус байлгахгүй гэсэн санаа зорилго бол байхгүй байх. Илүү тэр төсөв санхүүгийн асуудал дээр комиссын дарга тайлбар хэлэх байх. Зүгээр юу байдаг вэ, гэхээр одоо Хүний эрхийн Үндэсний Комисс дээр эрүү шүүлттэй холбоотой гомдлууд ирдэг ээ. Үүний хүрээнд бид нар тодорхой шалгалтуудыг хийдэг. Энэ нь үндэсний байгууллагынхаа мандатад байдаг ийм асуудал байгаа юм.

Урьдчилан сэргийлэх чиг үүрэг маань бол өөрөө тасралтгүй, байнгын тогтмол, энэ хуульд заасан газруудад очиж ажиллах, тэдгээрт зөвлөгөө өгөх.

Өнөөдрийн хийж байгаа энэ үйл ажиллагаагаа улам эрчимжүүлэх ийм л ажил байгаа юм. Хамгийн гол нь энэ 2 хоорондоо яаж холбоотой ажиллах вэ гэдэг асуудал. Хүний эрхийн үндэсний байгууллагад ирсэн өргөдөл гомдлоо бид нар шалгаж дууслаа. Зөвлөмж шаардлагаа гаргалаа. Энийг урьдчилан сэргийлэх механизмдаа өгөөд ийм асуудлууд чинь гарах гээд байна шүү. Ийшээ анхаарлаа хандуулаарай. Урьдчилан сэргийлэх механизм явж хяналт шалгалт хийж ирээд ийм зөрчил байна, энийг та нар шалгаад дүгнээдэх гээд энэ хоорондын уялдаа холбооны асуудал дээр илүү ярих гээд ярих нь зүйтэй болохоос биш яг нэг тал руу нь бол илүү юу гэдэг юм, гомдлоо шалгаад, урьдчилан сэргийлээд, хянах гэдэг энэ нөгөө конвенцынхоо агуулгатай бүрэн дүүрэн нийцэж байна уу, үгүй юү гэдэг дээр мэргэжлийн том хүмүүстэй ярилцах хэрэгтэй юм шиг байгаа юм. Комисс бол энэ чиглэл дээрээ нэлээн ярилцаад энэ асуудал ийм байгаа гээд учир зүйг нь ялгахыг бол нэлээн анхаарч үзэж байгаа.

Дээр нь ер нь эрүү шүүлт гэдгийг бас эрүү шүүлт хүнлэг бус харьцаа гээд энэ зүйлүүдээ бид нар ялгахгүй бол одоо зэвсэгт хүчин, хилийн цэргүүдийн тэр газруудад байгаа тэр дүрмийн бус харьцааг энэ хүнлэг бус харилцаа. Гэхдээ энийг яг эрүү шүүлт гэж үзэх үү, үгүй юу? Ингээд үзэх юм бол тэр салбарын хүмүүс чинь тэр цэргүүдтэй эрүү шүүлт тулгаад байдаг юм шиг ингэж ойлгогдох гээд байдаг.

Тэгэхээр энэ ойлголтуудыг онолын түвшинд нарийн салгаж, конвенцын агуулгатай нь авч үзэж байгаад энийг бол яаж нэмэлт, өөрчлөлт оруулахыг бол манай хууль тогтоогч шийдэх байх. Бид бүхэн мэргэжлийн экспертийн хувьд ийм байдаг юм шүү гэдэг санал зөвлөмжөө л гаргаж тавьж байгаа. Ийм асуудал байгаа.

Санхүүгийн хувьд ямар асуудал байдаг юм гэдгийг бол манай комиссын дарга хариулах байх.

Л.Мөнхбаатар: Хүний эрхийн комиссын дарга Дугарын Санжид хариулья.

Д.Сүнжид: Эрүүдэн шүүхийн эсрэг, хүнлэг бус, хэрцгий харьцаа, доромжилж харьцах, шийтгэхийн эсрэг конвенцод Монгол Улс нэгдэн орж, соёрхон баталсан учраас үүрэг хүлээнэ, нэмэлт протоколд нь үүрэг хүлээнэ. Энийг Эрүүгийн хуульдаа эрүү шүүлт гэмт хэрэг гэдгийг нь оруулчихсан. Тэгээд Комиссын тухай хуульд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх гээд гишүүнийг бий болгосон. Одоо энэ дээр эрүүдэн шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явах ёстой юу, явах ёстой. Энэ урьдчилан сэргийлснээр бид нар энэ олон зөрчил гаргахгүй, хүний эрхийн зөрчил гаргахгүй, таслан зогсоох наад шатад нь таслан зогсоох ойлголттой болох, хамтдаа нэгдмэл ойлголттой болох ёстой.

Тэгэхээр энэ үйл ажиллагаагаа яаж уялдуулах вэ гээд сая Энхболд гишүүний тайлбарлаад байгаа дээр бид нар энэ хууль тогтоомжийн хувьд ийм харилцаа холбоо байх хэрэгтэй байна аа. Яаж харилцан ажиллах юм бэ. Гомдол мэдээллийг хүлээн авч хянан шийдвэрлэж байгаа нь комиссын гишүүд эрүү шүүлтэд өртсөн гээд 100 гомдол ирж байгаа юм, жилдээ. Тэгэхээр эрүү шүүлтэд үнэхээр өртсөн үү. Энийг нь хянаж шалгадаг энэ хүмүүс нь бол энэ хүн Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүдийн мандат юм аа.

Төсвийн хувьд нэг механизм дээр манайх сая 3 механизм байна гээд нөгөө 21 оны нэмэлт, өөрчлөлттэй холбоотойгоор 3 механизм байгаа. Тэгээд 1 механизмд нь энэ нийт Хүний эрхийн Үндэсний Комиссын 10 хувь ноогдож байгаа юм.

Хөдөө томилолтыг нь аваад үзэхээр 23 оных 33 хувийн нийт томилолтын 33 хувийг эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулсан байдаг. Тэгэхээр энэ 5 хүнтэй үйл ажиллагаа явуулж байгаа. Үлдсэн 69 хувь нь тэгээд энэ 70 хувийн зарцуулалтаа явж байгаа юм. Тэгэхээр одоо бол энэ байгаа төсвийнхөө хүрээнд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх гишүүн ба нэгж нь шаардлагатай гэж үзсэн бүх төсвийг нь энэ 5,1 тэрбумынхаа хүрээнд л зарцуулалтынхаа зардлынх нь ангиллын дагуу л зарцуулаад явж байгаа юм.

Л.Мөнхбаатар: Яах юм, тодруулах юм уу. Одонтуяа дарга тодруулж асууя.

С.Одонтуяа: Тэгэхээр энэ эрүүдэн шүүлт, хүнлэг бус харьцаа, нэр төр гутаан доромжилсон гээд энэ өөрөө маргаантай байгаа гэх юм. Олон улсын хэллэгээр чинь ер нь эрүүдэн шүүнэ гэдэг чинь зөвхөн хүнийг зодож, цохиж биед нь гэмтэл учруулах биш ер нь хүнтэй хүнлэг бус харьцсан, нэр төрийг нь гутаан доромжилж харьцсан эд нар чинь бүгд л эрүүдэн шүүхийн нэг хэлбэрт орж байгаа шүү дээ.

Тэгэхээр та нарын энэ урьдчилан сэргийлэх ажиллагаагаар энэ хорих ангиуд дээр хийсэн урьдчилан сэргийлэх ажиллагаа үнэхээр үр дүнгээ өгсөн үү гэвэл өгсөн. Тэнд очиж байнга сургалт хийж байна, ярьж байна, хэлж байна. Түүн шиг би энэ цэргийн ангиуд дээр энэ эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх ажиллагааг нэмье л гэж байгаа юм. Яагаад энэ их олон хүн амь насаа алдаад байгаа юм бэ. Тийм л мундаг юм бол Хүний эрхийн Үндэсний Комиссынхон энийг тэгвэл таслан зогсоочихгүй яасан юм. Та нар энэ дээр хангалтгүй л ажилласан юм шүү дээ.

Тэгээд энэ дээр нь ингээд хуулийн төсөл өргөн барья ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Үг хэллээ, тийм ээ.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Байнгын хорооны саналаар санал хураалт явагдана.

Одоо 13 цаг 43 минут болсон байна.

Чуулганы үдээс өмнөх хуралдааныг завсарлуулж байна. 14 цагаас санал хураалтаар үдээс хойших чуулган эхэлнэ.

ЗАВСАРЛАГА

Г.Занданшатар: Улсын Их Хурлын чуулганы үдээс хойших нэгдсэн хуралдаанын нээснийг мэдэгдье. 04 дүгээр сарын 26-ны өдрийн үдээс хойших нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Цэдэвийн Сэргэлэн танилцуулна. Индэрт урьж байна.

Ц.Сэргэлэн: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын гишүүд 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн

хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Хууль зүйн байнгын хороо 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан журмын дагуу Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулах үед нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж, олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төсөлд нэмж тусгасан эцсийн хувилбарын төсөл болон зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны танилцуулга болон зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Ганбаатарын Төгөлдөр Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын нарийн бичгийн дарга.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Алга байна.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн

батлах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлээ.

14.50 цагт

Дараагийн асуудалд оръё.

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Чинбатын Ундрэм танилцуулна. Индэрт урьж байна.

Ч.Ундрэм: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2023 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны 2023 оны 02 дугаар тогтоолоор хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундармаар ахлуулан, Улсын Их Хурлын гишүүн А.Адьяасүрэн, П.Анужин, Т.Аубакир, Э.Батишугар, Г.Дамдинням, Б.Жаргалмаа, Г.Мөнхцэцэг нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажиллуулсан бөгөөд ажлын хэсгээс хуулийн төслийн талаар гаргасан саналаа Байнгын хорооны хуралдаанд танилцуулсан.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдаанаараа Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу зүйл бүрээр хэлэлцэн дараах санал, дүгнэлтийг та бүхэнд танилцуулж байна.

1. Соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээ, худалдан авах эрхийн бичиг олгох насыг Иргэний улсын бүртгэлийн тухай хуультай нийцүүлж 16-18 нас байхаар,

2. юуны өмч бүтээхийг урамшуулах хамгаалах, оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулж үйлдвэрлэлд нэвтрүүлэн үр шимийг нь уран бүтээлчдэд хүртээхийн тулд соёлын бүтээгдэхүүнийг арилжааны зорилгоор ашиглах, бүртгэх, хянах систем бүхий дэд бүтэц нэвтрүүлэхээр төсөлд тусгасныг бусад холбогдох хуультай нийцүүлж, боловсронгуй болгохоор,

3. Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчийг бусдын оюуны өмчийн эрхийг зөрчихгүй байхыг үүрэг болгох өөрчлөлтийг хийсэн бөгөөд мөн Засгийн газар батлахаар 13 журам байсныг цөөлж, санал бэлтгэн ажилласан болно.

Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хурааж, Байнгын хорооны гишүүдийн олонх нь дэмжсэн бөгөөд төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт болон санал гараагүй болно.

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх тус Байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг та бүхэнд тараасан.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Чинбатын Номин Соёлын сайд, Цэрэндоржийн Чулуунбат Монгол Улсын Урлагийн гавьяат зүтгэлтэн, Дашийн Өлзий-Орших ая зохиогч, продюсер, Дуу бичлэг бүтээгчдийн үндэсний төвийн гишүүн, Энхсайханы Тамир Монголын анимэйшний холбооны гүйцэтгэх захирал, Дашнямын Батмагнай М мюзик ХХК-ийн захирал, Баттөр байхгүй байгаа юм байна. Готовцэрэнгийн Батхуяг Соёлын яамны Соёлын бүтээлч үйлдвэрлэл, инновацын хэлтсийн дарга, Содномжамцын Батцэцэг Соёлын яамны Хууль эрх, зүйн хэлтсийн дарга.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Асуулт алга байна.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 48 санал байгаа.

Мөнхбаатар дарга, Тогтохоо дарга аа.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор

санал хураалт явуулахын тулд Улсын Их Хурлын Тамгын газар зарим хуулийн зөрчилтэй саналын томъёоллуудыг хууль зүйн лавлагаа, дүгнэлт гаргах болон намын бүлгүүдээр хэлэлцэх ийм санал гаргасныг харгалзан үзээд дэгийн тухай хуулийн 14.2-т заасны дагуу ирэх 4 дэх өдөр санал хураалт явуулахаар хойшлууллаа.

Ажлын хэсэгт баярлалаа.

Ирэх 3 дахь өдөр чинь ээлжит бус чуулган, ирэх 4 дэх өдөр.

Ажлын хэсэгт баярлалаа.

Дараагийн асуудалд орно.

14.56 цагт

Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Засгийн газрын гишүүн танилцуулах ёстой. Хууль санаачлагч байхгүй байгаа учраас хуулийн төслийг хойшлууллаа.

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул чуулганы нэгдсэн хуралдааныг өндөрлүүлж байна.

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

14.45 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН:ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА